

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 23
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	24 – 131
1. <i>Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	28 – 48
2. <i>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	48 – 53
3. <i>Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	53 – 69
4. <i>Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	69 – 88
5. <i>Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал нууц санал хураалтаар үргэлжлэв</i>	88 – 90
6. <i>Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв</i>	90
7. <i>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв</i>	90 – 131

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 82 гишүүн хүрэлцэн ирж, 65.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баттулга, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Р.Сэддорж, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, Г.Уянгахишиг;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 7 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 55 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 55 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т “Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.” гэж заасны дагуу Монгол Улсын иргэн Э.Баясалцэнгэлээс нийтийн ашиг сонирхлыг хөндсөн автомашины болон зам ашигласны татварыг бууруулах тухай ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдлийн системд 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр нийтэлсэн уг өргөдөл 2026 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33 мянган 216 иргэнээс санал авсан тул нийтийн өргөдөлд дурдагдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Н.Мягмар, Ц.Уртнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Баясах нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Байнгын хорооны саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Б.Пүрэвдорж, Ц.Мөнхбат, Д.Ганбат, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, нэр дэвшигч Н.Мягмар, Ц.Уртнасан хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 16.30 цаг хүртэл хойшлуулав. /15:06/

Чуулганы нэгдсэн хуралдаан 15 цаг 06 минутаас 15 цаг 20 минутад түр завсарлав.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Э.Тамир, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны орон тооны бус дэд ерөнхийлөгч Б.Алтанхуяг, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Ч.Нанжидсамбуу, мөн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга Э.Энхжаргал, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, судлаач Ч.Өнөржаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Ц.Долгормаа нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан 2 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /15:30/

Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын

дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад, Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран, мөн газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, Б.Нарангэрэл, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Г.Ганбаатар, Ц.Туваан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 16.30 цаг хүртэл хойшлуулав. /16:07/

Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Номинчимэг, О.Саранчулуун, О.Цогтгэрэл, М.Ганхүлэг, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 34
Бүгд: 105

67.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, М.Нарантуяа-Нара, Х.Булгантуяа, Б.Хэрлэн, Ж.Батсуурь, С.Эрдэнэбат нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал нууц санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Н.Мягмар, Ц.Уртнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Баясах нар байлцав.

С.Бямбацогт: Нэргүйн Мягмарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 31
Бүгд: 105
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Цэцэгмаагийн Уртнасанг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 36
Бүгд: 105
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. *Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17.00/*

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад, Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран, мөн газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, Б.Нарангэрэл, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, Х.Шижирмөнх нар байлцав.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Л.Соронзонболд, Р.Сэддорж нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “5” гэснийг “7.5” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 27
Бүгд: 105
74.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Э.Тамир, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны орон тооны бус дэд ерөнхийлөгч Б.Алтанхуяг, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Ч.Нанжидсамбуу, мөн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга Э.Энхжаргал, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, судлаач Ч.Өнөржаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Ц.Долгормаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./17:06/

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Ганмаа, Ж.Баярмаа, С.Эрдэнэбат, Ц.Туваан, Б.Түвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Э.Тамир нар хариулж, тайлбар хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпхар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийн “хоёр хүртэлх гэрээнээс сонгон” гэснийг “нэг гэрээнээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22” гэснийг “15-24” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “25” гэснийг “26” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 34
Бүгд: 107
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал уг саналтай холбогдуулан үг хэлэв.

С.Бямбацогт: 3.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.

Тайлбар: Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл авах талаар үг хэлж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

С.Бямбацогт: 4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс” гэсний дараа “доошгүй орлогоос” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 32
Бүгд: 107
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 1 болон 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ

хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 30
Бүгд: 107
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “биечлэн” гэсний дараа “, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн бол асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “0.3, 1.0, 1.5” гэснийг “0.3, 1.2, 2.2” гэж, “10.4, 11.1, 11.6” гэснийг “10.4, 11.3, 12.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 32
Бүгд: 107
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсгийн “шимтгэл төлөлтийн” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “тухайн гэрээ бүрт” гэснийг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 38
Бүгд: 107
64.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт болон 7, 10 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжээгүй санал:**

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11, 7.12 дахь хэсгийг тус тус хасах;

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах гэсэн 2 саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

С.Бямбацогт: 3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22 насны суралцагч” гэсний дараа “, мөн тухайн насны бүтэн бус цагийн ажил эрхэлж буй ажилтан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийн “2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш” гэснийг хасах гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

С.Бямбацогт: 5.Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Эхний 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа гарааны бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 48
Бүгд: 107
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.30 дахь хэсгийг “болон төрийн бус байгууллага” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 44
Бүгд: 107
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин 7.Нэгтгэсэн төслийн “4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах”, гэснийг мөн зүйлийн “7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасах гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

1/Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 3 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журам, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 34
Бүгд: 107
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.8. “суурь тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авагч ахмад настанд авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан тооцож улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 3.2, 3.5, 3.6 дахь хэсгийн, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн “баталгаат” гэснийг тохиолдол бүрт “суурь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийн “Бт” гэснийг “Ст” гэж, “Бсд” гэснийг “Сүд” гэж, 3.5, 3.6 дахь хэсгийн “Баталгаат тэтгэврийн суурь дүн” гэснийг “Суурь тэтгэврийн үндсэн дүн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэгт дурдагдсан “2027” гэснийг “2027, 2028” гэж, “2028” гэснийг “2029” гэж, “2029” гэснийг “2030” гэж, “2030” гэснийг “2031” гэж, “2031” гэснийг “2032” гэж “2032” гэснийг “2033” гэж тус тус харгалзуулан өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Суурь тэтгэврийг доор дурдсан насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгоно:

3.4.1.энэ хуулийн 5.1.1-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч;

3.4.2.энэ хуулийн 5.1.2-5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй 60 насанд хүрсэн, эмэгтэй 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч, мөн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 35
Бүгд: 107
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасаж, төслийн дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 34
Бүгд: 107
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжээгүй санал:**

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг, төслийн 4 дүгээр зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж,” гэснийг тус тус хасах;

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.4 дахь заалтыг хасах;

3.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтыг хасах гэсэн 3 саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

3/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийг” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг” гэж өөрчлөх;

2.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн 2 саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

С.Бямбацогт: 3.Нэгтгэсэн төслийн 3, 4 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 39
Бүгд: 107
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4/Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжээгүй санал:**

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5/Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжээгүй санал:**

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 37
Бүгд: 107

65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “баталгаат” гэснийг “суурь” гэж, мөн зүйлийн 2 дугаар заалт буюу 8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийн “баталгаат” гэснийг “суурь” гэж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 5, 6, 7 дахь хэсгийн “баталгаат” гэснийг “суурь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 32
Бүгд: 107
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 34
Бүгд: 107
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 35
Бүгд: 107
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 36
Бүгд: 107
66.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжээгүй санал:**

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 55 хоногоор тооцож олгоно.” гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

9/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын “сэргээн засах” гэсний дараа “, гэрээр асрах, сувилах болон хувилбарт тусламж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (Ст)-ийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгоно.”

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл авах талаар үг хэлж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй тэтгэвэр авагчид 60 насанд, эмэгтэй тэтгэвэр авагчид 55 насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 32
Бүгд: 107
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1} дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 31
Бүгд: 107
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 33
Бүгд: 107
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Бусад. Америкийн Нэгдсэн Улсын Монгол судлалын төвийн оюутан судлаачид, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын урилгаар Увс аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын малчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар Баянгол дүүргийн 12 дугаар хорооны хэсгийн ахлагч ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Л.Соронзонболд нарын урилгаар Хилийн цэргийн 0132 дугаар ангийн эмэгтэй албан хаагчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 31 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 110 гишүүн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
14 цаг 01 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 82 гишүүн буюу 65 хувийн ирцтэй ирц хүрсэн учраас чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Долоо хоногийн тов дараалалд тусгасан хэлэлцэх асуудлын тухай.

“Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан хойшилсон тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүдийн тухай.

6 дугаар сарын 29-нд Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ төрсөн байна.

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд орсон эртэч гишүүдээ танилцуулъя.

Өлзийхүүгийн Шижир гишүүн 9 цаг 52 минутад, Аюушийн Ариунзаяа гишүүн 10 цаг 10 минутад, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн 10 цаг 14 минутад, Мэндбаярын Мандхай гишүүн 10 цаг 14 минутад, Баатаржавын Мөнхсоёл гишүүн 10 цаг 17 минутад ирцэд орсон байна.

Өнөөдөр Олон улсын парламентын холбооны өдөр болж байгаа. Олон улсын парламентын холбооны өдөрт зориулж Монгол Улсын парламентаас мэндчилгээ дэвшүүлж үг хэлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд “Олон улсын парламентын холбоо байгуулагдсаны 137 жилийн ой” олон улсын парламентын холбооны өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

1889 оны 6 дугаар сарын 30-ны өдөр олон улсын парламентын холбоо байгуулагдсан бөгөөд энэхүү түүхэн өдрийг Нэгдсэн Үндэстний Байгууллага 2018 оноос “Олон улсын парламентад өдөр” болгон тэмдэглэж ирсэн билээ.

Парламент бол ардчиллын тулах цэг, ард түмний хүсэл зоригийг хууль, бодлого болгох индэр. Парламент бол төр төвтэй бус хүн төвтэй хүмүүлэнг, энэрэнгүй иргэний нийгэм байгуулах тухай манай Үндсэн хуулийн үзэл санааны гал голомт юм.

Энэ өдөр бид төлөөллийн дээд байгууллагын чиг үүргээ хэр гүйцэтгэж байгаадаа дүгнэлт хийх өдөр.

Ил тод байдал, хариуцлага, иргэддээ ээлтэй, бас нээлттэй байх зорилгодоо хүрэх замынхаа чухам хаана яваагаа бид эргэж харах ёстой.

Ардчилсан парламентын үнэт зүйлсийг олон нийтэд сурталчлан таниулах чухал ач холбогдолтой өдөр юм.

Өнөөдөр дэлхий дахинд 183 үндэсний парламент Олон улсын парламентын холбоонд нэгдэн 188 улсын парламент 44 мянга орчим парламентч, парламентын гишүүн, ардчилал, энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжлийн төлөө үүрэг хүлээн амжилттай ажиллаж байна.

Монгол Улс 1962 онд Олон улсын парламентын холбоонд элссэнээс хойш ялангуяа байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан 1990 оноос хойш парламентын ардчиллыг бэхжүүлэх, хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдал, залуучуудын оролцоог хангах, парламентын дипломат харилцааг хөгжүүлэх чиглэлээр тус байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж ирсэн билээ.

Энэ жил “Олон улсын парламентын өдөр”-ийг “Хүний эрхийг анхаарлын төвд авчиръя” уриан доор улс орнууд тэмдэглэж байна.

Хүний эрх бол иргэн бүрийн төрдөө итгэх итгэл, шударга ёс, эрх чөлөө, аюулгүй байдлын үндэс юм.

Хүний эрхийг хэн хангаж, хамгаалж чадаж байна гэдгээс хууль, шударга ёс, парламентын дархлаа шууд хамааралтай.

Хууль тогтоох, төсөв батлах, Засгийн газарт хяналт тавих, иргэдийн өргөдөл, гомдлыг сонсох гээд парламентын бүхий л үйл ажиллагаанд нэгдүгээрт хүний эрхийг хамгийн бодит шалгуур болгох ёстой.

Хариуцлагатай, сайн парламент гэж олон хууль баталдаг парламентыг хэлэхгүй ээ. Харин хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалдаг, иргэнийхээ дуу хоолойг сонсдог, баталсан хууль нь амьдрал дээр хууль болохгүй гуйвахгүй хэрэгждэг, гаргасан шийдвэр нь ойлгомжтой, хяналт нь бодитой, ёс зүй нь өндөр парламент л иргэдийнхээ итгэлийг бүрэн хүлээж чадна.

Төрд итгэх иргэдийн илтгэл, парламентад итгэх итгэлээс эхэлдэг. Иймээс хүний эрхийг дээдэлсэн, иргэндээ ойр, нээлттэй, хариуцлагатай сайн парламентыг төлөвшүүлэх нь бидний парламентын шинэчлэлийн үндсэн зорилт юм.

Монгол Улсын Их Хурлын даргаар томилогдсоноос хойш хууль тогтоох үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог бодитой хангах, чуулганы ирц хариуцлагын тогтолцоог илүү сайжруулах томоохон шинэчлэлийг Улсын Их Хурлын гишүүдийнхээ хамт амжилттай эхлүүлээд байна.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал өнөөдөр 126 гишүүнтэй, тэдгээрийн 32 нь эмэгтэй гишүүн буюу 25.4 хувийг бүрдүүлж байгаа нь Азидаа дээгүүрт орох үзүүлэлт юм.

Мөн 45 хүртэлх насны 51 гишүүн байгаа нь манай парламентад нийгмийн олон талт төлөөллийг илүү өргөн оролцуулах боломж нэмэгдсэнийг харуулж байна.

Гэхдээ энэ бүх тоон үзүүлэлтээс илүүтэй иргэдээ төлөөлөх төлөөлөл нь бодит оролцоо болж оролцоо нь оновчтой шийдвэр болж, бодлого шийдвэр нь иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчирдаг учиртай.

Хийрхсэн улс төржилтөөс илүү хууль тогтоомжийн үр нөлөө, хоосон шуугианаас илүү бодит үр дүн, улс үндэстнийхээ язгуур эрх ашиг, улс төрийн тогтвортой байдлаа ямагт эрхэмлэн ард түмнийхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, алс хэтийн бодлогод чиглэсэн оновчтой шийдвэр гаргах нь сайн парламентын үүрэг юм.

Олон улсын парламентын энэ өдөр Монгол Улсын Их Хурал хүний эрхийг дээдэлсэн, иргэддээ ойр, ил тод, нээлттэй, хариуцлага, ёс зүй, сахилга баттай парламентыг төлөвшүүлэх үйлсэд тууштай зорин ажиллахаа илэрхийлж байна.

Нийтийн эрх ашгийг тугаа болгож, нийгмийн зөв хөгжилд хөтлөн дагуулсан хариуцлагатай сайн парламентыг төлөвшүүлэх үйл хэрэгт хүчин зүтгэж буй Та бүхэнд “Олон улсын парламентын өдөр”-ийн мэндийг дахин дэвшүүлье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Дөрвөн асуудал байгаа.

— Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

— Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл. Анхны хэлэлцүүлэг. Асуулт асуух хугацаа 60 минут. Зарчмын зөрүүтэй 50 санал байгаа.

— Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Зарчмын зөрүүтэй 1 саналтай.

— Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог гэх. Хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэг.Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 7 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 55 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд.

Гурав.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 55 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-т нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын даргад саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Энх-Амарын Баясалцэнгэлээс нийтийн ашиг сонирхлыг хөндсөн автомашины болон зам ашигласны татварыг бууруулах тухай ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдлийн системд 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр нийтэлсэн уг өргөдөл 2026 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33 мянган 216 иргэнээс санал авсан тул нийтийн өргөдөлд дурдагдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан.

Холбогдох Байнгын хороод иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Зочин танилцуулъя. Америкийн Монгол судлалын төвийн оюутан судлаачид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхлан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Цэцэгмаа овогтой Уртнасан, Нэргүй овогтой Мягмар нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал дэвшигчийн сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно гэж, 4.5 дахь хэсэгт хорооны гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно гэж заасан.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан нэр дэвшигчийн сонсгол явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

Нэг.2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай 6 дугаар тогтоолыг баталж 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тогтоож, сонсгол даргалагчаар миний бие томилсон.

Хоёр.Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Түүнчлэн сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудас бүхий зарыг Улсын Их Хурлын цахим хуудсад 14 хоногийн хугацаанд байршуулсан болно.

Зар мэдээллийн дагуу Байнгын хорооны ажиглагч, оролцогчоор бүртгүүлэх хүсэлт ирээгүй болно.

Гурав.Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, Э.Болормаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд, Ц.Даваасүрэн, С.Зулпхар,

Л.Мөнхбаатар, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Ч.Ундрал, Ө.Шижир, Ц.Туваан, Ч.Лодойсамбуу, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа, Б.Энхбаяр нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж нэр дэвшигчийн сонсголыг зохион байгууллаа.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу хэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар сонсголын тайлан гаргах бөгөөд уг тайлан сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргаж тухайн тайлан нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулахаар заасны дагуу 2026 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүд сонсголын тайланг дэмжсэн тул Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Цэцэгмаагийн Уртнасан, Нэргүйн Мягмар нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэр дэвшигчдийн танилцуулга, тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулын ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дахиад танилцуулга хийх ёстой байх. Тийм ээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхлан танилцуулна.

Индэрт урьж байна.

Байнгын хорооны санал, Байнгын хорооны санал, дүгнэлт хоёр хоёулаа уншигдсан юм байна.

Нэг нь санал, нэг нь дүгнэлт унших ёстой.

Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Нэргүйн Мягмар, Цэцэгмаагийн Уртнасан нар хүрэлцэн ирсэн байна. Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. /алх цохив/

Ц.Мөнхбат гишүүнээр тасаллаа. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Микрофон өгье.

Н.Батсүмбэрэл: Үг цуг юм уу?

С.Бямбацогт: Асуулт, үг хамтдаа.

Н.Батсүмбэрэл: Эрхэм нэр дэвшигч нарт амжилт хүсье.

С.Бямбацогт: Нэр дэвшигч хариулж байх уу? 4 дүгээр микрофон. Ц.Уртнасан нэр дэвшигч.

Ц.Уртнасан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Миний бие 2012-2015 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагчаар ажиллаж байсан.

Энэ хугацаанд нийгмийн даатгалын сангийн чадавх, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар төрийн аудитын байгууллага, мөн тухайн үед ажиллаж байсан мэргэжлийн хяналтын байгууллага, мөн Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээгээ амжилттай биелүүлэн ажиллаж байсан.

Нэр дэвшигчийн хүснэгтэд хариулаагүй тухайд 2020 онд нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргын үйл ажиллагаатай холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан байгаа. Энэ асуудал 2020 онд яллагдагчаар татаж шалгагдаж байсан.

Өнөөдөр хүртэл хууль хяналтын байгууллагаас ямар нэгэн шийдвэртээ хариу өгөөгүй ийм байр байдалтай байж байгаа.

Тийм учраас би тэр асуумжийг бөглөөгүй юм.

Би Ардчилсан намын дэд дарга, Ардчилсан намын гүйцэтгэх удирдлагад ажиллаж байсан.

2016 оноос төрийн албанд Ардчилсан намын гэдэг юм уу, өөр үзэл бодолтой төрийн албан хаагчид ажиллах тийм бололцоо хязгаарлагдмал байсан учраас би намын байгууллагад шилжиж ажилласан юм.

Улс төрийн ямар нэгэн сонгуульд би нэр дэвшиж байгаагүй.

С.Бямбацогт: Б.Жавхлан даргын микрофон ажиллахгүй байдаг. Бүгд болохгүй байгаа юм уу. Манай хуралдаан зохион байгуулах.

Тэгвэл нөхөн хариулчихъя. Яах вэ? Тэгвэл индэр дээрээс хариулах юм уу? Тэнд нэг сул юу байгаа шүү дээ. О.Цогтбаатар гишүүний хажууд. Наана чинь. Болсон уу? Болдын Жавхлан гишүүнд микрофон өгье.

Индрийн 1 дүгээр индрийн микрофон өгье.

Б.Жавхлан: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Хоёр нэр дэвшигч маань хамгийн гол нь төрд тогтвортой ажилласан жилүүд. Хамгийн гол шалгуур нь жинхэнэ төрийн албан хаагч байх ёстой. Эдгээр шалгууруудаа хоёр нэр дэвшигч маань хоёулаа бүрэн хангаж байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2 квот байгаа. Энэ дээр ингээд орж ирж байгаа.

Тэгээд 2 нэр дэвшигчийг маань дэмжиж өгөөрэй.

С.Бямбацогт: Н.Батсүмбэр гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Одоо тэгээд сая нэр дэвшигч өөрөө хариуллаа. Эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа юм байна. Тэр нь дуусаагүй юм байна. Яллагдагчаар татагдчихсан явж байгаа хүнийг төрийн сонгууль зохион байгуулах байгууллагад нэр дэвшүүлж болдог юм уу? Үүнийг Төрийн байгуулалтын байнгын хороо нэмж хариулж өгөөч.

Нэр дэвшигч өөрөө тэрийгээ мэдэж байгаа байна. Нэрээ татаж болдоггүй юм уу?

С.Бямбацогт: Индрийн 1 дүгээр микрофон.

Б.Жавхлан: Асуултад нэмж хариулъя.

Нэр дэвшигч маань тийм мэдээлэл байгаа. Гэхдээ энэ чинь шүүхээр ороод гэм буруутай нь тогтоогдсон зүйл хараахан байхгүй шүү дээ. Тэгэхээр энд нэр дэвшигч бүрэн нэрээ дэвшүүлэх, Байнгын хорооноос нэр дэвшүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн. Тийм.

С.Бямбацогт: Шүүхээс хүний гэм бурууг тогтоогоогүй бол гагцхүү шүүх л гэм бурууг тогтооно. Шүүхээс гэм бурууг тогтоогоогүй бол гэм буруутайд тооцохгүй гэсэн Үндсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Заалтаа гишүүд унших хэрэгтэй байх. Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2022 онд Үндсэн хуулийн өөрчлөлт явсан. Энэ дээр би 99 гишүүнтэй больё гэдэг ийм санал тавиад үүнийхээ төлөө тэмцсэн. Гэвч тухайн үеийн эрх баригч нар, дээрээс нь манай намын удирдлагуудтай тохироод ерөнхийдөө 126 болгосон л доо.

Тэгээд би Байнгын хороо, Их Хурал дээр эсэргүүцэл, бойкот хийж ядаж 108 гишүүнтэй больё гэдэг ийм бойкот хийсний үр дүнд үүнийхээ тодорхой буулт хийж Сонгуулийн ерөнхий хорооны санал тоолох машины хөрөнгө шинээр авах, дээрээс нь программ хангамжтай болгох, мөн түүнчлэн Улсын ерөнхий газрын харьяа тэр хурууны хээний тоног төхөөрөмжийг шинээр авах, программ хангамжийг нь авах энэ хөрөнгө оруулалтын асуулыг төсвийн хууль дээр тавих ийм зүйлийг тохиролцоод тэгээд үүний дагуу 2024 оны сонгууль, энэ санал тоолох машинууд нь хангалттай хэмжээнд хийж гүйцэтгэсэн гэдэг ийм зүйл байдаг.

Тэгэхээр ер нь **Dominion Voting**-ийнхон санал тоолох машинаа илүү орчин үеийн, дээрээс нь ядаж **ES&S** (Election Systems & Software) гээд Америкийн 50 мужийн 42-т нь хэрэглэгддэг. Энэ хэмжээнд хүрэх шаардлагыг Сонгуулийн хорооны гишүүн болж байгаа хүмүүс бүгдээрээ үүнийг шаардах ёстой шүү.

Өөрөөр хэлбэл энэ санал тоолох машин чинь хэдэн цагаар хамаагүй цахилгаан байхгүй байлаа гэхэд өөрийн батарейгаар ажиллах боломжтой болсон.

Мөн түүнчлэн заавал онлайн горимд ажиллах шаардлагагүй, оффлайн горимдоо ажиллаад, аваад, саналаа тоолоод байх боломжтой болсон. Ийм ийм зүйлүүд байгаа. Түүн дээрээ манай Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг хэлье.

Мэдээж хоёр том нам ээлжлээд Сонгуулийн ерөнхий хороонд хэн нь эрх баригч байна түүн дээрээ илүү хүн тавиад явдаг. Өнөөдөр томилогдож байгаа 2 хүн маань очингуутаа Сонгуулийн ерөнхий хорооны бүтцийн асуудал, томилгооны асуудалд оролцох ёсгүй шүү.

Ер нь бүх 9 гишүүн бүгдээрээ томилогдсоны дараагаар тэр дотоод томилгооны асуудлыг хийх ёстой шүү. Хэрвээ тэгэхгүй урьдчилж очоод л цөөхөн хэдэн хүнээрээ асуудлаа шийдээд ийм байдлаар явах юм бол бид дараа дараагийнхаа улс төрийн акцуудыг хийх болно гэдгийг анхааруулж хэлмээр байна. Энэ дээр одоо тэнд... /минут дуусав/

С.Бямбацогт: Б.Пүрэвдорж гишүүн 1 минут.

Б.Пүрэвдорж: Тэнд очоод хүй, хай гэхийн завгүй тэнд нэг албан тушаал горьдоод яваад байх ийм шаардлага байхгүй гэдгийг хэлье.

Гуравдугаарт нь, Н.Батсүмбэрэл гишүүний асуултад нэр дэвшигчээс асууж байх шиг байна.

Ер нь С.Эрдэнэ даргын үед нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг банкнуудад байршуулж арвижуулах ажлыг хийдэг байсан юм. Үүнийг нь хэл амнаас айгаад буцаад тэрийг нь идэж уусан нь мэдээж аль намын ямар банкир байсныг Та нар өөрсдөө мэдэж байгаа. Ардын намыг л санхүүжүүлж байсан байх. Тэр банк.

Тэгээд түүнээс хойш Ч.Хүрэлбаатар сайд очсоноос хойш тэр нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын чөлөөт үлдэгдлийг ерөөсөө банкуудад хадгалдаггүй төрийн сан руу хийгээд хэзээ ч арвиждаггүй. Үүнээсээ бүр их хохирсон байхгүй юу даа. Үүнийг Б.Жавхлан ч засаагүй.

Тийм учраас жижиг тулга тойрсон хэрүүл хийх юм бузар нь... /минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Уучлаарай. **Зочин танилцуулъя.** Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын малчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. /алх цохив/

Ц.Мөнхбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Мөнхбат: Өнөөдөр Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшиж байгаа 2 гишүүний асуудал орж ирж байна.

Өмнө нь 4 гишүүний асуудал орж ирсэн.

Тэгээд Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшиж байгаа гишүүд тодорхой намуудын ойлголцлын хүрээнд аль аль талаасаа орж ирээд явж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд Төрийн байгуулалтын Байнгын хороогоор ороод даваад гараад ирсэн улсуудыг улс төрийн өнгө аястай янз янзын асуудал 50-иад хэрэггүй болов уу гэж бодож байгаа юм.

Хэн нэгнээс бөөс түүгээд байвал гарч ирж л таарах байх. Манай Н.Батсүмбэрэл гишүүнээс ч хайгаад байвал гараад л ирнэ.

Тэгэхээр ийм улс төрийн асуудлыг улс төр болгож асуудалд хандаад хэрэггүй болов уу гэж бодож байна. Тэрийгээ бас хэлчихье гэж бодсон юм.

Хоёрдугаарт, одоо дахиад Дээд шүүхээс ч бас нэр дэвшүүлэлт яваад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд маань гүйцэж намар гэхэд 9 гишүүнтэй болох юм байна гэж ойлгож байгаа.

Манай Н.Мягмар даргын хувьд Сонгуулийн ерөнхий хорооны дарга болох тохироотой байгаа гэсэн мэдээлэл байгаа юм.

Тэгэхээр Б.Пүрэвдорж гишүүнтэй санал нэг байгаа юм. Одоо очингуутаа бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтүүдийг хийгээд л, яарч сандраад л баахан ажлууд хийгээд байх нь зохимжгүй байх шүү. Яг тэр 9 гишүүнээ бүрдүүлж байгаад тэр дундаасаа шинэ бүтцээрээ зохион байгуулалт хийгээд явах нь зөв болов уу гэсэн бодолтой байна. Үүнийгээ Та хэрэгжүүлж ажиллаарай гэж хэлэх байна.

Сая Үндсэн хуулийн цэц дээр тийм л дүр зураг харагдсан. 2 Үндсэн хуулийн цэцийн гишүүн томилогдоод, тэгээд очоод бүрдсэнийхээ дараа Үндсэн хуулийн цэцийн дарга шинээр сонгогдоод явсан байна лээ.

Тэгээд Сонгуулийн ерөнхий хороо сонгууль болохоор хамгийн их үүрэг гүйцэтгэдэг, хамгийн их хэл ам, хэрүүл тэмцэлд ордог, хар сэр дагуулдаг ийм л байгууллага.

Тэгээд Та бүхэн хоорондоо тэр 9 хүнийхээ хувьд хууль чандлан сахиж, эв нэгдэлтэй, аливаа асуудлыг зөвшилцөл, ариа хэлэлцээний шугамаар шийдэж явах нь их чухал шүү гэдэг... /минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Дашдондогийн Д.Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: 2 нэр дэвшигч байна. Энэ 2 маань орон тооны бус уу? Орон тооны гишүүд байгаа юу? Сонгуулийн ерөнхий хороо чинь орон тооны хоёр, гурван гишүүн, орон тооны бус нэг хэдэн гишүүдээс бүрддэг байгаа.

Та 2 чинь яг алинд нь дэвшээд байна вэ?

Энэ Н.Мягмар гэдэг хүн чинь харин төрийн хар хүн юм уу даа. Манай монголчуудын ярьдгаар. Анкет юм хумыг нь харж байхад таних ч үгүй, мэдэх ч үгүй юм байна.

Ардын намаас сүүлийн үед дэвшүүлээд байгаа хүмүүс дотор анх удаагаа янз бүрийн юманд орооцолдоогүй хүн оруулж ирж байх шиг байна.

Ер нь аливаа нэг юманд тавихдаа сүүлийн үед нэг үзүүлэлт нь гэмт хэрэг, янз бүрийн хэл аманд орооцолдсон хүмүүсийг тавих нь ерөөсөө бараг давуу тал болсон юм уу хаашаа юм.

Тэгээд удахгүй хоёр сонгууль Та нарын өмнө зогсож байна.

2008 оны 7 сарын 01-нийг Та бүхэн санах ёстой. 5 хүний амь нас үрэгдсэн. Тийм нөхцөл байдал бий болох магадлал энэ ирж байгаа сонгууль дээр маш өндөр байна. Яагаад гэхээр өнөөдрийн эрх барьж байгаа намын хийж байгаа ажил, байгаа байдал, амлалтаа биелүүлж байгаа. Өнөөдөр манай Улсын Их Хурлын танхим, Засгийн газрыг харж байхад гэмт хэрэгтэйгээ тэмцэх биш нөгөө гэмт хэрэгтнүүдийн батцайз нь болсон байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүлээлт нь ард түмэнд энэ сонгуулийг шударга, зөв явуулах, хуулийн дагуу явуулах энэ юм чинь та нарын өмнө зогсож байна. Арай ийм байдалд хүргэхгүйгээр явуулах тийм боломж бололцоо байгаа юу? Юу гэж бодож байгаа вэ? Бэлтгэлтэй байгаа юу? Сэтгэл санааны гэсэн ийм асуултууд байна.

Ер нь хараад байхад 2008 оны 7 сарын 01-нд сүүлд нь хэдэн цагдаа нар хохироод л, тэгээд л цаана нь байсан тэр 5 хүний амь насанд хүрсэн тэр юм ямар ч хариуцлага хүлээгүй байна шүү дээ.

Өнөөдөр ард түмний байгаа амьдрал 3 настай хүүхэд ч гэсэн тэгээд л нас барж л байна. Энэ хариуцлагагүй байдлаас. Энэ авлига, хулгай гаарсан. Одоо эрх барьж байгаа Монгол Ардын нам гэхэд тэр дүрэмдээ яллагдагчаар татагдсан хүнийг намын гишүүнээсээ шууд хөөнө гэсэн заалтыг сонгуулийн өмнө орууллаа гээд л сүр дуулиантай мэдэгдээд л байсан. Өнөөдөр тэр нь байхгүй л байгаа шүү дээ. Би эрх барьж байгаа нам болохоор ярьж байгаа шүү. Зүгээр ямар ч хамаагүй нам байсан би тэд нарын дотоод хэрэгт оролцоод байх юм ерөөсөө алга.

Тэгээд энэ намууд чинь татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжиж байгаа шүү дээ. Ийм юман дээр Сонгуулийн ерөнхий хороо... /минут дуусав/

С.Бямбацогт: Хоёр нэр дэвшигч хариулъя. Д.Ганбат гишүүний асуултад. Н.Мягмар нэр дэвшигч эхэлж хариулъя.

Н.Мягмар: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Н.Мягмар.

Сонгуулийн төв байгууллага Монгол Улсын Үндсэн хууль болон Сонгуулийн төв байгууллагын тухай хууль бусад сонгуулийн хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг бол Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага.

Тийм учраас хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд сонгуулийн үйл ажиллагааг ил тод, бүх нийтээрээ, чөлөөтэй, саналаа нууцаар гаргах зарчмын үндсэн дээр зохион байгуулах энэ үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.

Энэ байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулахад ганцхан сонгуулийн төв байгууллага энэ үйл ажиллагаанд оруулцохгүй. Нөгөө талдаа сонгогч, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, мөн нөгөө талаас хуулиар хүлээсэн үүрэг бүхий хууль сахиулах байгууллагууд, Харилцаа холбооны зохицуулах хороо, Улсын бүртгэлийн байгууллага гэх мэт байгууллагууд өөр өөрсдийн чиг үүргээрээ оролцдог.

Тийм учраас энэ байгууллагуудын үйл ажиллагааг зөв зохицуулж сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагааг сонгуулийн бүх нийтээрээ чөлөөтэй, нууцаар гаргасан саналыг ил тод, шударга үр дүнг танилцуулах нь энэ байгууллагын үүрэг.

Тийм учраас Сонгуулийн ерөнхий хороо хуулийн дагуу олонхоороо үр дүнгээ гаргаж олон нийтэд хуулийн дагуу зохион байгуулж танилцуулна гэдэгт итгэлтэй байна.

Хэрэвзээ янз бүрийн сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байдал гарах асуудал дээр мэдээж сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой маргаан байх юм бол маргаан шийдвэрлэх хуулийн зохицуулалтаараа л явах ёстой гэж үзэж байгаа.

2008 оны 7 сарын 01 шиг үйл явдал цэвэр онц байдал тогтоох хэмжээний асуудал үүссэн. Энэ нь хуулиараа Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах асуудал. Үүнийг хууль сахиулах байгууллага, Засгийн газар зохион байгуулдаг хуулийн зохицуулалттай.

Тийм учраас энэ хуулийн зохицуулалтаараа холбогдох байгууллагууд амар тайван нийгмийн дэг журмыг хамгаалах үйл ажиллагаагаа явуулж таарна.

Тийм учраас сонгуулийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд сонгуулийн үйл ажиллагааг ил тод, шударга зохион байгуулахад төрийн байгууллагуудынхаа уялдаа холбоог хамтатгаж үр дүнг танилцуулна гэдэгт итгэлтэй байна.

С.Бямбацогт: Ц.Уртнасан нэр дэвшигч хариулъя.

Ц.Уртнасан: Нэр дэвшигч Ц.Уртнасан. Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Миний бие Сонгуулийн ерөнхий хорооны орон тооны бус гишүүний мандат дээр нэр дэвшиж байгаа гэж ойлгож байгаа.

Хоёрдугаар асуултын хувьд 2008 оны 7 сарын 01 шиг тийм эмгэнэлт үйл явдал гарахгүй байх гэж бодож байна.

Монгол хүн амны бэлгээрээ гэдэг. Би өнөөдөр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдоод ажиллах юм бол хамтын шийдвэр гаргадаг Сонгуулийн ерөнхий хорооны бусад гишүүдтэйгээ хамтраад, мөн Улс төрийн намын тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хороонд оноосон чиг үүргийн дагуу бид нийгмийн өргөн зөвшилцөл, ойлголцлын хүрээнд төрийн сонгуулиа зохион байгуулж чадах юм бол ийм эмгэнэлт түүх давтагдахгүй байх гэж бодож байна. Үүний төлөө би хичээж чармайж ажиллах болно. Баярлалаа.

С.Бямбацогт: Д.Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Сонгуулийг хариуцлагатай явуулах хэрэгтэй. Сонгууль хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой. Ерөөсөө манайхны нэг тийм юу байдаг. Монгол Ардын нам чинь арван хэдэн жил засаглалаа.

Тэгээд ард түмний амьдрал ийм байгаад байдаг. Цаашдаа ч хүндрэх төлөвтэй байна. Гэмт хэрэгтэйгээ, энэ хулгайч авлигачтайгаа эвлэрч байгаа байгаа байдлыг харахад ард түмэн бүр дайжиж байна шүү дээ.

Тэгэхээр энэ сонгуулийг захиалдаг, өрсөлдөгчөө, хамгийн авлигач хулгайчийг нь олдог. Өөрсдөө тийм болсон учраас хэн авлига бага хулгай хийснийг нь биднийг сонгох болов уу гэж найддаг. Тэр нь тэгээд улс орныг эмх замбараагүй байдал руу түлхдэг. Ийм юм руу оруулж болохгүй шүү нөхдүүдээ. Үүнийг би бүгдэд нь хэлж байна. Тийм. Нэг их эмзэглээд байх юм байхгүй шүү.

С.Бямбацогт: Үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалан: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд 6 жилээр Улсын Их Хурлаас томилогддог. Тэгээд энэ жил Сонгуулийн ерөнхий хорооны 9 гишүүний бүгдийнх нь хугацаа дуусаад түрүү долоо хоногт 4 гишүүн томилогдоод ажилдаа орсон гэж ойлгож байгаа.

Тэгээд энэ бүрэлдэхүүн тэр чигтээ солигдож байгаа.

Тэгэхээр энэ цаг хугацаан дээр бид өнгөрсөн хугацаанд өнгөрсөн бүрэлдэхүүний бүрэн эрхээ хэрэгжүүлсэн цаг хугацаанд ямар үйл явдлууд болж өнгөрөв гэдэг дээр тодорхой дүгнэлт хийх ёстой байх.

Тэгээд 2020 он, 2021 оны сонгуулийг би сануулахыг хүсэж байгаа. Яасан бэ гэхээр 2020 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшсэн хэд хэдэн нэр дэвшигч нарыг сонгуулийн компанит ажлынх нь цаг хугацаан дээр шоронд аваачаад хийсэн байдаг. Тэгээд тухайн асуудал дээр Сонгуулийн ерөнхий хороо эс үйлдэхүй үзүүлсэн гэж харж байгаа.

Тэгээд сонгуульд нэр дэвших эрхийг тэгж булааж авна гэдэг бол бас л чөлөөт шударга сонгууль явуулах асуудлыг үндсээр нь устгаж байгаа явдал. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль дээр бүр илүү ноцтой асуудал болсон. Тэр нь юу вэ гэхээр Үндсэн хуулиар олгогдсон Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намууд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ гэж заасан байдаг.

Тэгэхэд энэ эрхийг эдлэх ёстой Ардчилсан намыг тамга тэмдгийг нь захиргааны байгууллагын шийдвэрээр хувааж өгөөд хоёр талд хоёр дарга цэрэг үүсгэж байгаад тэгээд Ардчилсан намаас нэр дэвшигчийг захиалж байгаад сонгууль явуулсан.

Тэгээд тухайн цаг хугацаанд Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг Ардчилсан намын гишүүд Сүхбаатарын талбай дээр өлсгөлөн зарлах хүртэл арга хэмжээ авч байсныг Та бүхэн санаж байгаа байх.

Тэгээд тун удахгүй ердөө ганцхан жилийн дараа бид дахиад Ерөнхийлөгчийн сонгууль хийх гэж байна. Та бүхэн ер нь ингээд ажил дээрээ ороод л тэгээд л тун удахгүй Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил руу орно. Тэгээд Ерөнхийлөгчийн сонгуульд энэ удаад 5 субъект нэр дэвшүүлэх эрхтэй байх нь байна.

Тэгээд энэ цаг хугацаанд саяын миний дурдсан шиг асуудал гаргахгүй байх тал дээр бид хаана хаанаа маш их анхаарч хичээж ажиллах ёстой байгаа. Яагаад вэ гэхээр чөлөөт, шударга, ардчилсан сонгууль Монголын ардчиллын үндэс суурь ийм асуудал байгаа.

Тэгээд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд гэдэг бол эрх ямба эдлэхээсээ илүү яг энэ ардчилсан тогтолцоог хамгаалах тэр хариуцлагыг Та бүхэн Улсын Их Хурлаас мандат аваад нуруундаа үүрэх ёстой ийм субъектүүд.

Тэгээд ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд маш их санаа зовж байгаа. Одоогоороо гэхэд Иргэний Зориг Ногоон намын даргын асуудал, тамга тэмдгийн асуудал гээд л будилаантай юм болоод байгаа. Тэрийг бид маш анхааралтай ажиглаж байгаа.

Тэгэхээр иймэрхүү нөхцөл байдлыг дахиж бид бүрдүүлж болохгүй гэж харж байгаа.

Нөгөө талаас сая гишүүдийн хэлсэнтэй санал нэг байна. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүн бүтэн болтол ямарваа нэгэн бүтцийн... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэг нэмээд 1 минут. Асуултаа дуусгая.

Б.Жаргалан: Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүн бүтэн болтол ямарваа нэгэн тийм бүтцийн өөрчлөлт хийхгүй буюу орон тооны гишүүдээ томилохгүй байх нь чухал гэж харж байна.

Ер нь би анхнаасаа ямар байр суурьтай байсан бэ гэхээр нэгэнт Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн хугацаа нь дуусаж байгаа, дуусах нь ойртсон яг ийм цаг хугацаан дээр бүрэлдэхүүнээ бид Улсын Их Хурал есүүлэнг нь хамтад нь томилох ёстой байсан гэсэн байр суурьтай байсан.

Яагаад вэ гэхээр бид бүрэлдэхүүнээ бүтнээр нь харж байгаад тэгээд юу гэдэг юм тэр үүрэг чиглэлээ өгөөд явуулах ёстой байхгүй юу. Гэтэл одоо ингээд уван цуван орж ирж байгаа нөхцөлд бид бүрэлдэхүүн бүрдсэний ар дээр Та бүхэн маань энэ зохицуулалтуудаа хийгээрэй. Эс бөгөөс цөөнхийн бүлгийн гишүүд байр суурь нэгтэй байгаа шүү. Энэ асуудал дээр гэдэг ийм зүйлийг хэлэх байна.

Тэгээд яах вэ, би асуулт асуухгүй. Гэхдээ Та бүхэн энэ хариуцлагаа ухамсарлахыг хүсье.

Ардчиллын манаач байх хариуцлага бид бүхний хариуцлага. Тэр дундаа Сонгуулийн ерөнхий хороон дээр томилогдож байгаа 9 гишүүний... /минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Б.Жаргалан гишүүн. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Жаргалсайхан: Орж ирж байгаа нэр дэвшигчдийг дэмжиж байгаа. Хоёр намын төлөөлөл гэж ойлгогдож байна.

Ер нь Сонгуулийн ерөнхий хороо бол сонгуулийг нэг талыг барихгүйгээр аль аль талын үзэл санаа, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ард иргэдээ сонгох, сонгогдох эрхийг хангах нь зөв байгаа юм. Тийм учраас дэмжиж байна.

Сонгуулиар маш их үл ойлголцох, будилаан маргаан их гардаг.

Тийм учраас сонгуулийн Ерөнхий Хороо маш сайн ажиллах шаардлагатай байна. Хоёр нэр дэвшигчээс асуулт асуумаар байна.

Монголын сонгуулийн тухай хууль, улс төрийн намын тухай хуулиудад зөндөө өөрчлөлтүүд орж байна. Та хоёр очоод яг ямар ажлуудыг хийх вэ? Жишээ нь, Сонгуулийн ерөнхий хороо аль аль намын төлөөллийг авч чадаж байна. Орон нутагт сонгуулийн салбар хороон дээр дандаа төрийн албан хаагч нар ажиллаж байгаа. Тэр төрийн албан хаагч нар яг тэр орон нутагт ямар нам ялснаас шалтгаалаад яг тэр намын төлөөллүүд байгаа.

Тийм учраас бусад намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн эрхийг хангахгүй байх асуудал зөндөө байна. Жишээ нь, Баянхонгор аймагт гэхэд. Би

жишээ ярьж байна. 2020 онд. Бүр яг багаар нь яривал 6 дугаар баг дээр дансаар нь мөнгө хийгээд тараагаад бусдын саналд нөлөөлсөн асуудал байгаа.

Энэ нь шүүхээр тогтоогдоод, тэр нэр дэвшигчдийн асуудал үндсэндээ шүүхээр хүчингүй болсон ч гэсэн дараагийнх нь нэр дэвшигчийг тодруулах хугацаагүйгээр шүүхийн баахан маргаанууд явчхаж байгаа байхгүй юу.

Энэ асуудлыг яаж богино цаг хугацаанд шийдвэрлэх вэ? Энэ дээр ямар санаа оноо байна вэ?

Мөн яг энэ асуудал яг дахиад давтагдаж байгаа юм. 2020 онд давтагдсан бол яг 2024 онд манай Баянхонгор аймгийн 9 дүгээр баг дээр яг ийм асуудал гарч байгаа юм. Хоёрхон хоногийн өмнө шүүх хурал нь болоод тав дахь өдөр гэдэг чинь гурав хоногийн өмнө шүүх хурал нь болоод яг одоо яг ийм байдлаар хүмүүст мөнгө тараагаад, тэр мөнгө нь бүр өгсөн авсан авсан нь нотлогдоод, цагдаа яг тэр үед нь очоод бүр тогтоочоод байхад энэ асуудал шийдэгдэхгүй явсаар байгаад хоёр жилийн дараа саяхан шийдэгдэж байгаа юм.

Тэгэхээр сонгуультай холбоотой эд материал тараах, бусдын саналыг худалдаж авах зорилгоор явагдаж байгаа энэ асуудлыг яг тэр цаг хугацаанд нь шийдвэрлэх дээр та хоёр юу бодож байна вэ гэсэн асуулт байна.

Дараагийн асуулт. Иргэдийн сонгох, сонгогдох эрхээ эдлэхдээ бусдын нөлөөнд автахгүй байх дээр Сонгуулийн ерөнхий хороо ямар ажлуудыг зохион байгуулах ёстой вэ? Энэ дээр та хоёр хариулаач. Ямар ажил арга хэмжээг хийх ёстой вэ? Тэнд очоод. Ямар байдлаар бид сонгуулиа будилаангүй, ард иргэдийн саналыг яг үнэн зөвөөр авч чадах вэ гэдэг дээр та хоёр дорвитой ямар ажлууд хийх вэ гэсэн асуултуудыг асууя.

Сонгуулийн үед бид харж байдаг. Ирцийн асуудал маш муу байдаг юм. Ирцийг нэмэгдүүлэх дээр Та хоёр... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэр дэвшигчид хариулъя. Н.Мягмар нэр дэвшигч хариулъя. Индрийн 4.

Н.Мягмар: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч М.Мягмар.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол мэдээж Сонгуулийн ерөнхий хороо олонхоороо шийдвэрээ гаргадаг хуулиар хүлээсэн байгууллага.

Тийм учраас мэдээж олноороо хэлэлцэж байж шийдвэрээ гаргаж... /минут дуусав/

С.Бямбацогт: Микрофон яагаад унтарчхав. Гурав, дөрвөн асуулт асуусан. Тийм ээ.

Н.Мягмар: Тийм учраас сонгуулийн зохион байгуулалттай холбоотой сонгуулийн тойрог, хэсгийн хороодын үйл ажиллагаанд орон нутгийн оролцоог анхаарах ёстой гэдэг зүйлийг хэлж байна.

Ер нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хуулиараа тодорхой албан тушаал руу ордог, Сонгуулийн ерөнхий хорооны хэсгийн хороонд ордог, тойргийн хороонд ордог улсууд байгаа. Тухайлбал, Засаг даргын Тамгын газрын дарга, хариуцсан Улсын бүртгэлийн хэлтсийнх нь дарга гээд.

Тэгэхээр энэ хуулиар хүлээсэн байгууллагуудын оролцоог мэдээж хуулийнх нь дагуу хангаж таарна.

Нөгөө талаасаа орон нутгаасаа ирүүлж байгаа тойргийн хэсгийн хороодод оруулах саналыг Сонгуулийн ерөнхий хороо өөрсдөө авч харгалзан үзэж шийдвэрээ гаргадаг.

Тийм учраас энэ зарчмынх нь дагуу оролцоог, ялангуяа төрийн албан хаагч, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид оролцох хуулийн зохицуулалттай байгаа учраас энэ хуулийн зохицуулалтаа гаргаж ажиллана гэж бодож байна.

Мөн таны асуултад байгаа мөнгө тараасан үйл явдлууд гардаг. Үүнийг цаг хугацаанд нь шийдвэрлүүлэх асуудал дээр мэдээж хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой зөрчил болон Эрүүгийн хуулиар хориглолт, хязгаарлалт, ял шийтгэл, хариуцлагын асуудал зохицуулагдсан байдаг.

Тийм учраас энэ зөрчил, гомдлыг хэрэг хянан шийдвэрлэх харьяаллынхаа дагуу холбогдох албан тушаалтнууд хуулийн хугацаанд нь, богино хугацаанд шийдвэр гаргаж, мөн энэ шийдвэрийн үндсэн дээр үндэслэж сонгуулийн төв байгууллага шийдвэрээ гаргах энэ тал дээр анхаарч ажиллана гэж тооцож байна.

Мэдээж шүүхээр шийдвэр эцэслэгдэн гарсан, сонгуулийн үр дүн гарснаас хойш ийм шийдвэр гарсан тохиолдолд энэ маань сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотойгоор сонгогдож гарсан этгээдийг эгүүлэн татах асуудал Улсын Их Хурал болон бусад эрх бүхий субъектүүдийн эрх хэмжээ болж таарна.

Тийм учраас хуулийнхаа дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны этгээдүүдийн богино хугацаанд шийдвэрлэхтэй холбоотой хуульд заасан тодорхой хугацаанууд заагаад өгсөн байгаа. Тэр хугацаанд нь шийдвэрлүүлэх тал дээр анхаарна гэж тооцож байна.

Мөн нөгөө талаасаа Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнд цагдаагийн байгууллагын төлөөлөл орж ажилладаг учраас ялангуяа энэ байгууллагын үйл ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээрээ анхаарахад тус болох байх гэж харж байна.

Бусдын нөлөөнд автахгүй байх, саналаа шударгаар өгөх асуудал дээр мэдээж энэ бол сонгуулийн боловсролын асуудал байгаа.

Тийм учраас сонгогчид Үндсэн хуульд зааснаар шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулж төрийн үйл хэрэгт оролцох эрхээ тодорхой мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгийн хүрээнд саналаа худалдах ийм зүйл байж болохгүй. Энэ таны эрх. Нөгөө талаасаа улсынхаа тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой шийдвэр гаргах төрийн эрх байгууллагын төлөөлөл... /минут дуусав/

С.Бямбацогт: Нэр дэвшигч Ц.Уртнасан хариулъя. Гүйцээгээд хариулъя.

Ирцтэй холбоотой асуудал дээр. Ирцийг яаж сайжруулах вэ гэж асуусан. Тэрийг нэмээд хариулъя. Ер нь товчхон тодорхой хариулна шүү. 2 минутдаа багтаагаад.

Н.Мягмар: Тийм учраас бусдын нөлөөнд автахгүй байх дээр сонгуулийн боловсрол байгаа.

Тийм учраас үүнийг ганцхан сонгуулийн цаг хугацаанд биш, энэ тасралтгүй байнга явуулах тал дээр анхаарах ёстой гэж харж байгаа.

Нөгөө талаасаа ирц муу байгаа асуудал яах арга байхгүй бас энэ залуучуудын сонгуулийн статистик дүн мэдээгээс харж байхад сонгуулийн насанд хүрсэн залуучуудын оролцоо муу байгаа.

Тийм учраас энэ бол эргээд л сонгуулийн боловсролын асуудал байна.

Мөн зарим статистикаас харж байхад зам тээвэр, уул уурхайн салбарын алба хаагчид ажлын байран байх ийм тохиолдолд байнга оршин суух хаяг дээрээ байхгүйгээсээ болоод сонгуульдаа оролцож чадахгүй байх ийм тохиолдлууд гардаг учраас энэ асуудлыг мэдээж Сонгуулийн хууль тогтоомжийнхоо статистик дүн мэдээ судалгаанд мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэж хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай энэ саналаа бэлтгэж Улсын Их Хуралд оруулж ирнэ.

С.Бямбацогт: Баярлалаа. Ц.Уртнасан нэр дэвшигч хариулъя.

Ц.Уртнасан: Нэр дэвшигч Ц.Уртнасан. Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

Бид Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд нэр дэвшихдээ хийх ажлынхаа талаар тодорхой тавьж байгаа зорилтуудаа танилцуулгадаа оруулсан байгаа.

Миний гол зарчим болгож байгаа нэг зүйл бол манай Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнд хуульчид нэлээн түлхүү орсон. Миний хувьд менежментийн мэргэжилтэй. Өнөөдөр сонгуульд оролцож байгаа олон талууд сонгуулийн үр дүнд сэтгэл ханамжтай байх, сонгуулийг шударга, олон нийтийн санаа бодолд тусгагдсан ийм сонгууль болно гэж хүлээн зөвшөөрөхийн тулд сонгуульд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, харилцан ойлголцох, зөвшилцөх менежментийн арга хэрэгслүүдийг бий болгох замаар сонгуулийн байгууллагад илүү институцийн чадавхтай тийм байгууллага болоход хувь нэмрээ оруулна гэсэн ийм зорилтуудыг би тавьсан байгаа.

Мөн таны ярьж байгаа сонгуулийн тойргийн хороодын бүрэлдэхүүнийг зохион байгуулахтай холбоотой асуудал бол бас бид бүх шатдаа л ойлголцож хамтарч шийдэх ёстой асуудал. Тухайн орон нутагт нэг нам олонх боллоо гээд тэр намын харьяалал гэдэг юм уу, тийм нөлөөний хүмүүсээр тойргийн хороог бүрдүүлж байгаа нь л бас сонгуульд оролцогч талууд сэтгэл ханамжтай бус, сонгууль шударга боллоо гэдэгт эргэлзэх нь эргэлзээний нэг хүчин зүйл болж байгаа.

Тийм учраас тойргийн хорооны бүрэлдэхүүнийг балансжуулах, тэнцвэржүүлэх чиглэлээр сонгуулийн байгууллагын хэмжээнд ойлголцох, зөвшилцөх ажлыг хийж, сонгуулийн үр дүнг эцсийн дүндээ талууд харилцан зөвшөөрөхөд анхаарч ажиллах болно.

Мэдээж хэрэг тойргийн хороонд ажиллах төрийн албан хаагчдыг сургах, бэлтгэх, тэднийг зохих хэмжээний гэрчилгээжүүлэх ажлуудыг зохих журмын дагуу хийх ажлыг түлхүү зорилт болгож ажиллана.

Мөнгө тараалт, санал худалдан авалттай холбоотой асуудал зөвхөн цөөнхийн бүлгийн ч гэх юм уу, олонхын бүлгийн, ер нь сонгуульд оролцогч бүх л хүмүүсийн асуудал болсон байгаа. Бид энэ асуудлыг сонгуулиас сонгуульд яриад л өнгөрдөг, домог болгоод өнгөрдөг, инээдэм наргиан болоод өнгөрдөг. Эцсийн дүндээ түрүүн Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчдийн ярьж байгаагаар сонгуулийн хуулиар хариуцлага хүлээсэн нэг ч хүн Монгол Улсад байхгүй гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид ийм байдлаар яваад байх уу? Энэ асуудлаа илүү ёс суртахууны гэдэг юм уу, зан байдлын, мэргэжлийн, ёс зүйн, нийгмийн хариуцлагын хүрээнд бид энэ асуудлаа шийдэхгүй бол төрийг шударгаар байгуулах, сонгогчдын хүсэн хүлээсэн төр засгийг эмхлэн байгуулах энэ ажилд бэрхшээл тулгарч байгаа. Энэ асуудал дээр одоогийн үйлчилж байгаа дүрэм журам, тухайн цаг үед нь энэ асуудлыг шийдэх ямар бололцоотой байна вэ. Энэ журам дүрмийг сайжруулах чиглэл дээр таны саналыг анхаарч ажиллах болно.

Дараагийн дугаарт нь сонгогчид бусдын нөлөөнд орохгүйгээр төрийн сонгуульд оролцох байдал гарцаагүй хөндөх ёстой асуудал. Өнөөдөр цэргийн ангиудын түвшинд ялангуяа... /минут дуусав/

С.Бямбацогт: Д.Жаргалсайхан гишүүн тодруулж асууя.

Д.Жаргалсайхан: Ирцтэй холбоотой асуудал дээр Та нар дорвитой арга хэмжээ хийхгүй бол саяын хариултаас үнэхээр дутмаг байна.

Ер нь хүн бүр л саналаа өгөх эрх байгаа. Тэгэхдээ үүрэг гэдэг юмыг байх байлгах ёстой.

Тийм учраас олон нийт рүү хандсан арга хэмжээнүүдийг Сонгуулийн ерөнхий хороо байнга зохион байгуулмаар байна. Ийм арга хэмжээ хийхгүйгээс болж хүмүүс төрөө барьж чадаж байна уу, үгүй юу. Тийм ээ. Үүний цаана ямар будилаан гарч байна. Ямар байдлаар сонгуульд өрсөлдөж байгаа, оролцож байгаа хүмүүс сэтгэл ханамж маш муу байна гэдэг чинь үүнтэй холбоотой байгаа шүү дээ.

Ийм сургалт судалгаануудыг байнга явуулж баймаар байна.

Миний зүгээс тэр хар машинд итгэх, итгэхгүй асуудал дээр үнэхээр бидний хувьд шинэ дэвшилт технологи нэвтрүүлж чадсан нь сайшаалтай байна. Гэхдээ үүнээс цааш бид ямар өөр шинэ технологиудыг хэрэгжүүлэх шаардлагатай вэ? Жишээ нь, саналыг цахимаар авдаг байх нь зөв үү?

С.Бямбацогт: Хоёр нэр дэвшигч хариулъя. Ц.Уртнасан нэр дэвшигч хариулъя. Ээлжлэн хариулъя.

Ц.Уртнасан: Өнөөдрийн үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ашиглаж байгаа сонгуулийн автоматжуулсан систем технологийн хувьд бололцоотой, илүү хяналт тавих бололцоотой технологи гэж үзэж байгаа.

Ер нь улс орнуудын сонгууль зохион байгуулж байгаа үйл явц хэдийгээр дэлхий ертөнц дижиталчлал руу шилжиж байгаа боловч дижиталчлах үйл явцын нөгөө талд нь эрсдэлүүд байгаа. Мэдээллийн аюулгүй байдлыг хадгалах, төрийн мэдээллийн нууцлалыг хадгалах түвшний асуудлууд байгаа учраас өнөөдрийн түвшиндээ бид энэ технологио ашиглаад сонгуулиа зохион байгуулаад явахад бололцоотой гэж хувь хүний хувьд боддог юм.

С.Бямбацогт: Н.Мягмар нэр дэвшигч хариулъя.

Н.Мягмар: Мэдээж сонгуулийн автоматжуулсан системийг Монгол Улс 2012 оноос хойш хэрэглээд өнөөдрийг хүртэл энэхүү системээр гарсан дүн болон хяналтын... /минут дуусав/

С.Бямбацогт: 4 номерын микрофон өгье.

Н.Мягмар: Сонгуулийн автоматжуулсан системийн дүн болон хяналтын тооллогуудаар зөрж байсан тохиолдол байхгүй байгаа.

Тийм учраас энэ автомат системийн үр дүн цаг хугацааг хэмнэсэн, сонгуулийн урьдчилсан дүнг гаргахад чухал алхам болсон.

Хэдийгээр мэдээллийн технологи ашиглан улс орнууд бүх нийтийн оролцоог хангахын тулд цахимаар санал өгөх туршилтыг хийж байгаа мэдээлэл байдаг. Тэгэхдээ энэ асуудлыг бид бүхэн Монгол Улсын хувьд өнөөдөр цахим засаглал, дижитал шилжилттэй өнөөгийн цаг үетэйгээ уламжилж уялдуулж нэлээн олон талаас нь судалсны үндсэн дээр энэ асуудлыг шийдэх ёстой гэж үзэж байгаа.

Цахим технологийн цаана тэр хүн –

- аюулгүй байдлаа хангаж саналаа өгч чадаж байна уу,
- эсвэл бусдын дарамт шахалтад,
- эсвэл янз бүрийн дэмжлэг туслалцаа авсны үндсэн дээр саналаа өгч байна уу гэдгийг ямар байдлаар нь хянах вэ,
- технологийн нөхцөл байдал нь бүрдэж үү.

Хоёрдугаарт, саналаа хэнд өгсөн нь нууц байх ёстой.

С.Бямбацогт: **Зочин танилцуулъя.** Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалын урилгаар Увс аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алх цохив/

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшинэ гэдэг бол маш хариуцлагатай ажил.

Сонгуулийн ерөнхий хорооны төсвийг Улсын Их Хурал баталж өгдөггүй юм билээ. Маш жоохон төсвөөр ажил хийх болдог.

Тийм учраас одоо энд захиад байгаа гишүүдийн даалгаврыг биелүүлэхэд хүндрэлтэй. Соён гэгээрүүлэх ажил дээр бараг мөнгө тавьдаггүй юм билээ. Соён гэгээрүүлэх ажил хамгийн чухал.

- Хүн саналаа худалдахгүй байх ёстой.
- Хүн сонгууль өгөх үүрэгтэй.

- Сонгууль битгий өг гэж уриалах ёсгүй гэх мэтчилэн зүйлийг мэддэггүй.

Дээрээс нь аль нэг намаас таныг бид хянаж байгаа шүү. Та манай нэр дэвшигчид нэрээ заавал өгөөд дугуйлчхаад гараад ир. Тэгэхээр чинь мөнгө өгнө. Таныг тэр нэр дэвшигчийг дугуйлахгүй байгааг бид харж байгаа гээд ийм юм их явдаг л даа. Тэрийг болиулах нь шинээр орж байгаа Та нөхдийн үүрэг болж байгаа.

Тэгээд төсөв хэлэлцэх үеэр энэ мэт ажлыг маш тийм санаачилгатай Улсын Их Хурлын гишүүдэд хэлж ойлгуулж баймаар юм билээ. Надад тэгж санагдсан шүү. Өмнөх Сонгуулийн ерөнхий хорооны дарга орж ирээд хэлж байхад төсөв бид нарт ерөөсөө байдаггүй. Чүү ай цалингаа аваад л явдаг гэж хэлж байсан.

Би асуулт асуухгүй. Үг хэлж байгаа юм.

Ц.Уртнасан нэр дэвшигчийн хувьд төрийн албанд маш олон жил ажилласан, тулхтай, жинхэнэ төрийн хар хүн. Хамгийн сүүлд Байгаль орчин уур амьсгалтын өөрчлөлтийн яаманд ажиллаж байхдаа Орхон-Онги, Хэрлэн-Тооно мега төслүүд дээр маш их санаачилгатай ажиллаж ажлын хэсгийг ахалж байсан. Усны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсгийг ахалж байсан гээд говь төрж өссөн хүн болохоор энэ тал дээр маш сайн ажиллаж байсан.

Өөрийг нь би сайн мэдэх юм. Тийм учраас Монгол төрийн энэ өндөр албан тушаалыг та сайн хаших байх аа. Н.Мягмар нэр дэвшигчдэд ч гэсэн амжилт хүсье.

Тэгээд Монголын ард түмний, Монголын төрийн эв нэгдэлтэй байх нь Сонгуулийн ерөнхий хорооноос шалтгаалдаг гэж би боддог юм. Сонгууль ямар зөв шударга явснаас бүх юм шалтгаалдаг гэж боддог.

Тийм учраас энэ эв нэгдлийг хангахын тулд сонгуулийг шударга явуулах ёстой.

Тэгэхээр загийн үндэс шиг зангидаж яваад Монгол төрийн эв нэгдлийг ямагт дархалж хамгаалах ажилд нь амжилт хүсье.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулах боломжгүй боллоо. 5 минут завсарлаад төхөөрөмжүүдээ засах хэрэгтэй байна.

Тийм болохоор дараачийн асуудлуудаа явуулна. Санал хураалтыг 16 цаг 30 минутаас нэгтгээд явуулна. Гуравхан асуудал байгаа нийлүүлээд явуулна.

Танхимдаа сууж байж болно. 5 минут завсарлаад. Сая статик цохиод микрофонууд ажиллахаа болилоо. Үүнийг Тамгын газраас засаадахъя. Түр 5 минутын завсарлага. Тэгээд дараагийнхаа асуудалд орно шүү. Нийгмийн

даатгалын хуулиудаа хэлэлцэнэ. Гишүүд ээ. 5 минутаараа нийгмийн даатгалын хуулиудаа хэлэлцээд явна шүү.

**Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын
гишүүд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалдаа оръё.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулъя.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний хөгжлийн нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэвжавын Ганзориг. Алга байна.

Х.Булгантуяа гишүүн танилцуулах уу? Ажлын хэсгийн ахлагч. Санал, дүгнэлтийг танилцуулъя.

Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүнээс 2026 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26 дахь хэсгийг үндэслэн дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн хэлэлцүүлэх хүсэлтээ хууль санаачлагч нараас

ирүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 279 дүгээр захирамжаар Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагаар ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпкар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат нарыг оролцуулан байгуулсан.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байгаа 5 хүртэлх ажилтантай ажил олгогчийг дэмжиж, ажил олгогчийн төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлээс 60 хүртэлх сарын хугацаанд чөлөөлөхөөр;
2. Ахмад насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд эмэгтэй 55 эрэгтэй, 60 насанд хүрсэн тэтгэвэр авагч болон цэргийн алба хаасныг тэтгэвэр тогтоолгосон иргэд ажил, хөдөлмөр эрхлэх тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байж болохоор;
3. Хэд хэдэн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа иргэн өөрт таатай зөвхөн нэг гэрээг сонгон нийгмийн даатгалын шимтгал төлж болохоор;
4. Тэтгэвэр тогтоох сүүлийн 20 жилийн дотор дараалсан 5 жилийг үе шаттайгаар нэмэгдүүлэх хугацааг 2029 оноос хэрэгжүүлэхээр;
5. Олон давхаргад тэтгэврийн тогтолцооны олон улсын нэршилд нийцүүлэн “баталгаат тэтгэвэр” гэснийг “суурь тэтгэвэр” болгон өөрчлөхөөр;
6. Суурь тэтгэврийг Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа эмэгтэй 55 эрэгтэй, 60 насанд хүрсэн нийт ахмад настанд авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулж улсын төсвөөс сар бүр олгохоор тус тус тусгасан байна.

Ажлын хэсгээс Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэгтгэсэн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 32 санал, найруулгын шинжтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй нэг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, зарчмын зөрүүтэй 14 саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Монгол Улсад сурч байгаа гадаад улсын оюутнууд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдах боломжийн талаар;
- Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр 5 хүртэлх ажилтантай ажил олгогчийн 3 хүртэлх ажилтны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалаас чөлөөлөхдөө тухайн ажил олгогчийг нийгмийн даатгалд ажилтнуудаас сүүлийн 5 жил бүрэн хамруулсныг хэрхэн баталгаажуулах талаар асуулт асууж хариулт авлаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэгтгэсэн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөж, Журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний

хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: Х.Булгантуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Лхагвасүрэнгийн Мөнхзул Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Тамир Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч, Баасангийн Алтанхуяг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны орон тооны бус дэд ерөнхийлөгч, Чимэдцэрэнгийн Нанжидсамбуу Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч, Энхтайвангийн Энхжаргал Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга, Чимэдгочоогийн Өнөржаргал Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, судлаач, Бямбаагийн Мөнхбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч.

Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаан хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд төрийн албаны болон холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцдог болохыг сануулж байна.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэт хариулт өгөхийг Та бүхнээс хүсье.

Мөн товч тодорхой хариулахыг хүсье.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар Баянгол дүүргийн 12 дугаар хорооны хэсгийн ахлагч ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алх цохив/

Гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Б.Жаргалан гишүүн, Ардчилсан намын бүлгийн дэд дарга.

Б.Жаргалан: Нийгмийн даатгалын багц хууль Монгол Улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн нэг бүрт хамаатай маш чухал хууль орж ирсэн байгаа.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлтэй хамтаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нарын 41 гишүүнээс өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хамтатгаад нэгтгээд хэлэлцэгдэж байгаа.

Тэгэхээр энэ Нийгмийн даатгалын багц хуулийг аль болох эдийн засагт ээлтэй, иргэн нэг бүрт хүртээмжтэй болгох үүднээс нэгтгэлийн асуудал дээр дахиад бага зэргийн тохируулгын шинж чанартай ойлголцол хийх шаардлагатай байгаа учраас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс яг энэ асуудал дээр 2 цагийн завсарлага хүсэж байна.

С.Бямбацогт: Засгийн газар өргөн барьсан Нийгмийн даатгалын багц хууль байгаа.

А.Ариунзаяа нарын гишүүдийн хууль байгаа. Б.Түвшин нарын гишүүдийн хууль байгаа. Гурвууланг нэгтгэж хэлэлцье гээд хууль санаачилж зөвшөөрсөн.

Анхны хэлэлцүүлэг ажлын хэсэг байгуулж, Х.Булгантуяаг гишүүн ахлуулж хийсэн байгаа.

Тэгээд энэ дээр уг нь хууль санаачлагч хоорондоо маш сайн ярилцаад, ойлголцоод асуудлаа шийдсэн бол их зөв байлаа.

Тэгээд ойлголцоогүй зарим нэг асуудал байвал ярилцах боломж олгоё доо.

Энэ дээр хамгийн гол нь улс орныхоо эдийн засгийнхаа нөхцөл байдлаа сайн бодоорой. Манай гишүүд ээ. Тийм ээ.

Тэтгэвэр авагчид, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага гэдэг нөхцөл байдлаа сайн бодож асуудлаа шийдэх хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол өнөөдөр яаран сандран сэтгэлийн хөөрлөөр

шийдвэр гаргадаг. Тэр нь эргээд нийгмийн даатгалын сандаа сөрөг нөлөөтэй болдог. Эргээд тэтгэвэр авагчид маань тэтгэвэр авч чадахгүй вий. Иймэрхүү юмнуудаа нэг сайн ярилцаач.

Тэгвэл 2 цагийн завсарлага. Б.Түвшин гишүүн ээ, нэлээн сайн ярилцаарай. Тэгээд ойлголцоод. 2 цагийн завсарлага. /алх цохив/

Завсарлагаа болж өгвөл хурдан дуусгахыг бодоорой. Хурдан ойлголцоод. Яагаад гэвэл дараа нь Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо чуулганаар анхны хэлэлцүүлэг хийсний дараа дахиж хуралдах юм байна. Тэгж байж Х.Булгантуяа гишүүн ээ, ажлын хэсгийн ахлагч, Б.Жаргалан дэд дарга аа. Та хэд маань хурдан хуралдаад хурдан дуусгавал Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дахиж 16.30-аас хуралдах товтой юм байна. Тэгж байж бид нэг хугацаандаа чуулган завсарлана. Тэгэхгүй бол амжихгүй болох гээд байна шүү.

Тэгээд Та хэд маань нэг сайн ярилцаадах. Хурдан хугацаанд. Б.Жаргалан гишүүн ээ, наана нь.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 25, 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ш.Бямбасүрэн, М.Бадамсүрэн, Р.Сэддорж нарын зүгээс Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан нэг зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар уг зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Л.Соронзонболд гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Ч.Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Төгөлдөр Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга, Ш.Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга, С.Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татварт хөгжлийн газрын дарга.

Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд, дээрээс нь товч тодорхой товлосон хугацаанд багтаж хариулна шүү.

Худлаа мэдээлэл өгөх, асуултад хариулахаас татгалзах, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцдог болохыг сануулъя.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төсөлтэй холбоотой бараг нэг л асуулт юм уу даа. Нэг асуултыг тодруулж асууя.

Ер нь энгийнээр тайлбарлавал газрын тос олборлодог 2 компани татвар төлөөгүй, татварын маргаан үүссэн, татварын акт тавьсан ийм асуудлыг л шийдэх гэж ийм хууль орж ирж байна.

Тэгээд олон улсын гэрээ мөн, биш гэдэг маргаанаас болоод энэ 760 орчим тэрбум төгрөгийн асуудал үүссэн байна. Монгол Улс жилдээ 200 гаруй тэрбум төгрөгийн газрын тосны орлого олдог бол 3 жилийн орлогоо буцаагаад олох бололцоогүйгээр үүнийгээ ирээдүйн орлоготой суутган тооцохоор.

Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд үүссэн маргаантай асуудлаа нөхөж хууль гаргаж хэрэглээд ирээдүйд суутгасан иймэрхүү дүр зураг харагдаад байна.

Тэгээд яах вэ, үүнтэй холбоотой мэдээж анх эхэлж Америкуудтай Монгол Улс бүтээгдэхүүн хуваах гэрээ хийхдээ одоо үл ойлголцлын асуудлууд байсан байж магадгүй. Америкийн хөрөнгө оруулагчид энэ гэрээг олон улсын гэрээ гэж үзээд тодорхой хэмжээний хөнгөлөлтүүд үргэлжлээд явна гэж үзсэн байж магадгүй.

Дараа нь худалдаж авсан Хятадын компаниуд ч гэсэн яг энэ агуулгаараа ойлгож байсан. Монгол Улсын хувьд ч гэсэн үүнтэй холбоотой өөрчлөлтүүдийг сүүлд хийх шаардлагатай гээд өдийг хүртэл хийгээгүй байсан. Тийм үл ойлголцол гарсан байж магадгүй байх.

Тэгэхээр яах вэ, үүнтэй холбогдуулаад хэрвээ олон улсын гэрээ гэж үзээд.

Өөрөөр хэлбэл татварыг зөвхөн хуулиар тогтоох ёстой. Олон улсын гэрээ л гэрээгээр тохиролцож болно.

Тэгэхээр энэ асуудлыг нөхөж ингээд хэрэглэх гэж байна. Үүнтэй холбогдуулж нэг тодруулах зүйл байгаа юм. 760.0 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа.

Татварын асуудал дотор анх хийсэн гэрээтэй холбоотой роялти, орлогын албан татвар гэх мэтчилэн тодорхой татваруудад заасан байгаа.

Гэтэл яг энэ торгууль, татварын акт дээр болохоор энд дурдагдаагүй зүйлүүд байгаа. Жишээлбэл, НӨАТ-тай холбоотой, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зардал, орлогоо бүртгээгүй, үйл ажиллагаанд хамааралгүй орлогууд байгаа. Анх эхэлж гэрээ хийхэд хамааралгүй үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой татварын актууд, зардлууд байгаа юм.

Тэгэхээр 760.0 тэрбум төгрөгөөс чинь хэрвээ “олон улсын гэрээ” гэж үзвэл хэд нь үүнд хамрагдах, аль аль зүйл, заалтууд нь энэ гэрээнд хамрагдахгүй байх. Ингэж салах бололцоо нь. Тийм мэдээлэл өгөөч. Ил мэдээлэл өгөөгүй учраас үүнийг тодруулъя.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 1991 онд Монгол Улс Газрын тосны хуулиа батлаад 1993, 1995, 1997 онуудад “бүтээгдэхүүн хуваах” гэрээ байгуулж гаднын хөрөнгө оруулалтыг урьсан байдаг.

Ингээд Америкийн Нэгдсэн Улсын “Медалион Ойл” (Medallion Oil) компани 1993 онд “бүтээгдэхүүн хуваах” гэрээ байгуулаад ажил эхэлсэн.

Мөн Америкийн “СОКО Тамсаг” (SOCO Tamtsag) компанитай 1995 онд гэрээ байгуулж ажилласан.

Мөн Австралийн “Нескор Энержи” (Nescor Energy) гэж компанитай 1997 онд.

Ингээд гурван хөрөнгө оруулагч ажиллаж байгаад энэ гурван хөрөнгө оруулагч өөрийн эзэмшил хувьцаа компаниа Хятадын төрийн өмчит “Си Эн Пи Си” (China National Petroleum Corporation, CNPC) компанид Тосон-Уул, Тамсаг XXI талбайг шилжүүлсэн.

“Дон Шень Жингүн Петролиум Девелопмент Групп Сток” (Dongsheng Jinggong Petroleum Development Group Stock Co.Ltd.), компани 2003 онд Австралийн “Нескор Энержи” (Nescor Energy) компаниас тус тус эрх, үүргийг шилжүүлж ажилласан байдаг.

Тэр үед “бүтээгдэхүүн хуваах” гэрээгээр бүх харилцаа зохицуулагдаж байсан.

Ингээд 2012 оноос Татварын хуулийг бид өөрчилсөн. 2014 оноос Газрын тосны хуулийг өөрчилж энэ хуультай холбоотойгоор энэ актууд тавигдаж эхэлсэн. Үүнийг хөрөнгө оруулагч тал хүлээн зөвшөөрөхгүй. Ингээд маргаанууд үүсэж байгаа.

Гол тавьж байгаа зүйл бол “бүтээгдэхүүн хуваах” гэрээгээр хүлээсэн Монгол Улсын Засгийн газар үүргээ хүлээгээч ээ. Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр хуваагдах газрын тос буюу Монголын талд ногдох ашигт газрын тосонд бүх татвар хураамж чинь шингэнэ гэсэн бүтээгдэхүүн хуваах гэрээг манайх өөр хууль эрх зүйн орчин гаргаж, түүнийгээ баримтлан тавьсан актыг нөгөө тал зөвшөөрөхгүй гэдгээр маргаан үүссэн. Тэгээд 30 жил боллоо.

Энэ асуудлыг шийдэхийн тулд бид хууль эрх зүйн орчин дээрээ эргэн харж зарим өөрчлөлтийг хийж байж газрын тосны салбарт хөрөнгө оруулалтыг татах, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх боломж байна.

- Энэ нь цагтаа сая гаруй тонн байсан шүү дээ. 1 сая 200 мянган тонныг олборлодог байсан. Жилдээ.

Хэрвээ үүгээр нь тооцох юм бол энэ асуудлыг нэг жилийн олборлолтоор нөхөх хэмжээний асуудал байгаа юм.

- ➔ 2023 онд гэхэд 660 мянган тонн.
- ➔ 2024 онд 500 мянган тонн.
- ➔ 2025 онд 400 мянган тонн болсон.

Улам унаж байгаа буюу асуудал шийдэгдэхгүй бол газрын тосны салбарт хийсэн хөрөнгө оруулалтаа зогсооё, гаръя гэдэг байдал үүссэн.

Иймд газрын тос, шатахууны хэт хамаарлыг бууруулах үүднээс, нөгөө талаар Алтанширээгийн нефть боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах бодлогын үүднээс газрын тосны нэгэнт батлагдсан нөөцийг идэвхтэй ашиглаж газрын тосны үйлдвэрийнхээ түүхий эдийг бэлтгэх нь их чухал болсон тул бид энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байна.

Тэгээд бусад татвартай холбоотой зүйл ажлын хэсгээс нэмээд.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмж хариулъя. 4 дүгээр микрофон. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

“Бүтээгдэхүүн хуваах гэрээ” нь “олон улсын гэрээ” биш. Гэхдээ Монгол Улсын Засгийн газар төлөөлж бүтээгдэхүүн хуваах гэрээний нэг тал болж гэрээг Засгийн газрын тогтоолоор баталгаажуулсан байдаг тул гэрээнд тусгагдсан зүйл, заалтынхаа дагуу хэрвээ Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл аль аль нэг байгууллагаас тухайн аж ахуйн нэгжүүдэд татвар, нийгмийн даатгал, нэмэгдсэн өртгийн албан татвар болон бүх төрлийн татвар тавьсан тохиолдолд Засгийн газрын төлөөлөлтэй зөвшилцөнө. Зөвшилцсөний дагуу Засгийн газрын төлөөлөл

төлөх чиглэл өгвөл төлсөн баримтаа буцааж авчраад төлсөн төлбөрөө буцааж авна гэсэн гэрээний зохицуулалт байдаг.

Энэ зохицуулалтаараа бид ямар нэгэн байдлаар... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Тухайн гэрээнд заасан татвар, хураамжийг буцаан төлөх ёстой гэсэн байгаа юм.

Үүний дагуу бид өнөөдрийн боловсруулж ирж байгаа хуулийн төсөлд “олон улсын гэрээ” биш. Гэхдээ “бүтээгдэхүүн хуваах” гэрээнийхээ үндсэн зарчмыг Монгол Улсын Засгийн газар баримталж хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах ёстой гэдэг байдлаар хуулийн томъёоллыг оруулсан байгаа.

Нөгөөтээгүүр бүтээгдэхүүн хуваах гэрээ өөрөө зарчим нь бүтээгдэхүүн хуваалтад бүх төрлийн татвар ногдож явдаг. Аж ахуйн нэгж оруулсан хөрөнгө оруулалт, эрсдэлээ өөрсдөө даадаг. Ашигт тос гарч ирвэл ашигт тосныхоо тодорхой хувийг Монгол Улсын Засгийн газарт ногдох хувь болж авдаг тийм зохицуулалттай. Үндсэн зарчим нь.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Яах вэ, энэ гэрээ маань 2012 оноос хойш 14 жил явж байгаа асуудал.

Өнгөрсөн хугацаанд шийдээгүй байж гэнэт яаралтай горимоор орж ирээд нөгөө тал нь гарна гэж айлгасан учраас хийж байгаа юм шиг.

Өглөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ч гэсэн гаднын байгууллагууд л болино, ингэнэ гэсэн гэнгүүт л баахан асуудал ярилцдаг.

Тэгээд асуудлуудаа ингэж овоолж байгаад оруулж ирдэг ийм баймааргүй байгаа юм.

Горим нь ч гэсэн яаралтай гэдэг нь ойлгомжгүй. Хэдэн арван жил зүгээр явж байснаа хаврын чуулганы бөгсөн дээр яаралтай гээд.

Би түрүүчийн асуултад хариулт авч чадсангүй. 760.0 тэрбум дотор чинь зарим тодорхой татваруудыг ярьсан байсан. Энэ дотор ороогүй байсан татваруудыг дахиж буцааж төлөх нь ирээдүйн орлогоосоо суутган тооцох нь буруу юм биш үү гэж бодоод байгаа байхгүй юу. /минут дуусав/

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Газрын тос, хий, уран гээд энэ гурав тусдаа бие даасан хуультай.

Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагддаггүй. Бие даасан, өвөрмөц эрх зүйн орчинтой.

- Анх 1991 онд гаргасан бодлого, гэрээ их сайн байсан.
- Монгол Улс шууд 28 хувийн дундаж өгөөжийг олборлосон тос болгоноос шууд хүртэж байсан. Ямар нэгэн эрсдэлгүйгээр.
- Газрын тос хайхад асар их хөрөнгө ордог. Эрсдэлээ хөрөнгө оруулагч хүлээдэг. Монгол Улс ямар нэгэн эрсдэл хүлээгээгүй.
- Газрын тос олборлосон тохиолдол болгонд дунджаар 28 хувь нь шууд Монгол Улсын өмч болж байсан.

Ийм онцлог бараа тул Монголын тал ногдож байгаа хувь дотор манай улсын бүх татвар хураамж, бүх асуудлууд дотроо багтаж явдаг.

Ер нь олон улсын жишиг бүтээгдэхүүн хуваах, нефтийн бүтээгдэхүүн хуваах гэрээний мөн чанар энэ байдаг.

Үүнийгээ бид сайн ойлголцоогүй явсан. Ингээд маргаан үүссэн. Энэ чинь 1991 оноос хойш зүгээр явж байсан ажил байхгүй юу.

- 1993 онд хөрөнгө оруулаад,
- 1995 онд хөрөнгө оруулаад,
- 1997 онд гэрээ хийгээд,
- 2012 он хүртэл ямар ч асуудалгүй явж байсан.

Тэгээд газрын тосны үнэ баррель нь 100 доллар даваад эхэлсэн.

Тэгээд л бидний асуудал үүссэн шүү дээ.

- ➔ Шинэ хууль эрх зүйн орчин үүсгээд л,
- ➔ хуулиа өөрчлөөд л,
- ➔ бүтээгдэхүүн хуваах гэрээгээ мөрдөхгүйгээр шинэ эрх зүйн орчноор тооцож татварын маргаан үүсгээд л.

Үүнийгээ харилцан зөвшөөрөхгүй явсаар байгаад өдийд хүрч байгаа нь энэ.

Нөгөө талаар сая олон жил хүлээгдсэн “Алтанширээ” нефть боловсруулах үйлдвэрийг барих зээлийн ашиглалтыг улсын төсвөөс гадуур гаргаж өглөө шүү дээ.

Ингэснээр нефть боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт эрчимжих бололцоо бүрдэж байгаа юм. Бид чинь жилдээ 50, 60 сая доллар зарцуулдаг. Авсан зээлээ ашиглаж чаддаггүй... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулья.

Ж.Энхбаяр: Энэтхэгийн Засгийн газраас тэрбум гаруй долларын зээл аваад байдаг.

- Жилдээ 50, 60-ыг ашигладаг.
- Бусдыг нь хүлээдэг.
- Зээл блоксныхоо төлөө хүү төлдөг байсан.
- Их Хурал сая хавар асуудлыг шийдэж өгсөн.

2026, 2027 онд ажил эрчимжээд, 2028 онд нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад орж дуусна. Одоо ямар нэгэн зээлийн хязгаарлалтгүйгээр ажил эрчимжих бүрэн нөхцөл бүрдүүлсэн. Их Хурал.

Одоо бидэнд газрын тос нийлүүлэх, түүндээ онцгой анхаарах ёстой. Энэ салбарт үүссэн маргаан, хууль, эрх зүйн орчин боловсронгуй болоод, энэ чинь жилдээ бараг сая 400 мянган тонн буюу “Алтан ширээ” үйлдвэрийг 100 хувь түүх эдээр хангах олборлолт хийж байгаа. Ийм техник, эдийн засгийн тооцоо үндэслэлтэй төслийг хурдан эргэлтэд оруулж, нефть олборлолтоо нэмэгдүүлэх нь чухал байна гэдэг бодлого оруулж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн тодруулья.

Д.Энхтүвшин: Би уг нь тодорхой асуулт асуугаад байгаа юм. Яг энэ 760.0 тэрбум төгрөгөөс чинь.

Өөрөөр хэлбэл нэмэгдсэн өртгийн албан татвар байгаа байхгүй юу. Нэмэгдсэн өртгийн албан татвар чинь хэрэглэгч төлдөг болохоос энэ компанитай холбоотой асуудалд хэрэглэгчийн төлсөн татварыг суутган төлөх ёстой. Дээр нь орлогоо нуун дарагдуулсан, үндсэн үйл ажиллагаатай холбоотой биш машин түрээсийн орлого гэх мэтчилэнгээр ийм орлогуудыг. Өмнө нь анх гэрээ хийхэд байгаагүй орлогуудыг энэ дотор оруулаад, ингээд 760 дотор чинь байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийгээ ингэж явах нь зөв юм уу? Хэрвээ хариулах боломжгүй бол татвартай холбоотой материалуудыг нь өгөөч гэсэн хүсэлт тавимаар байна.

С.Бямбацогт: Б.Цогтнаран дарга хариулья. 4 дүгээр микрофон.

Б.Цогтнарэн: Татварын ерөнхий газар. Б.Цогтнарэн. Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны компаниуд дээр Татварын албанаас татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд шалгалтуудыг хийсэн. Тухайлбал, “ПетроЧайна” (PetroChina Daqing Tamsag Co.Ltd.) компанитай холбоотой татварын актууд зөвхөн нөгөө оршин суугч бус этгээдэд гадагшаа шилжүүлсэн орлогоос нь суутган татвартай холбоотой төрлүүд дээр нь нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар буюу гадагш шилжүүлсэн орлогоос Монгол Улсаас эх үүсвэртэй орлогоос нь татвараас суутгаж төлөөгүй гэдэг дээр нь актыг тавьсан.

Мөн Монгол Улсад оршин суугч бус 183 хоногоос бага хугацаагаар ажилласан гадаадын ажилчдаасаа хувь хүний орлогын албан татвар суутгаагүй гэдэг ийм тодорхой гуравхан төрлийн зөрчил дээр хянан шалгалтын нөхөн ногдуулалтын актыг үйлдсэн.

Өөрөөр хэлбэл тухайн татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагаа... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. 4 дүгээр микрофон. Минут сунгая.

Б.Цогтнарэн: Тухайн татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагаагаас олсон орлого тухайн татвар төлөгчдөд яг үндсэн ажилтнаас суутгах ёстой байсан хувь хүний орлогын албан татвараа суутгаад төлөөд явж байгаа. Акт бол эх үүсвэртэй орлогыг суутгаж төлөөгүй гэдэг төрөл дээр тавигдсан.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Манай улс мөнхийн хоёр хөрштэй.

Хойд улсаасаа шатахуунаа авч байна, эрчим хүч авч байна. Хойд улсын нөхцөл байдал амаргүй байна. Урд улс бүх зүйлээрээ технологи, хөгжил, эдийн засаг, дэлхийн том тоглогч боллоо. Геополитикийн хоёр том дэлхийн хэмжээний тоглогч улсын дунд Монгол Улс эдийн засгийн хувьд сорилттой, ээдрээтэй.

Бидэнд сайн сайхан зүйл байгаа. Ямар ч байсан ардчиллынхаа төлөө, тайван замаар эрх мэдэлд шилждэг, сонгууль болдог. Иргэд нь эрх чөлөөний төлөө эрмэлздэг. Энэ улсад болохгүй байгаа хүнийг шүүмжилж чаддаг.

Гэхдээ улс орон тусгаар тогтносон бүрэн эрхт халдашгүй дархан байхын цаадын цаад углуурга ерөөсөө л эдийн засгийн бие даасан байдал руу эрмэлзэж байх ёстой.

Эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрүүд санаачлагддаг, явдаг ч гэсэн тэр нь улс төрийн хэрүүлийн хамгийн том алим болдог. Бие биеэ намнах, улс төрийн ашиг хонжоо хийх шалтаг бөгөөд шалтаг, шалтгаан болдог.

Монгол Улсад хөрөнгө оруулах нь монголчууд хэр найдвартай вэ, тогтвортой юу, улс төржөөд өмнөх гэрээ хэлцлээ хүчин төгөлдөр бус болгодог уу гэдэг асуулт, айдас байдаг учраас олон улсын хөрөнгө оруулалт ч гэсэн татахад асар ээдрээтэй.

Бид нарт улс төрждөг сэдэв, улс төрждөггүй сэдэв байхгүй. Бүгдэнгээр нь улс төрждөг. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд одоогийн мөрдөгдөж байгаа үзэл баримтлалд бид аль хэдийн 2020 он гэхэд—

- газрын тос, шатахуунаа өөрсдөө 100 хувь хараат бус байдалтай болно гээд зорилго тавьсан.

—Цаасан дээр байдаг. Хэрэгждэггүй.

—Нэг хууль гардаг.

—Нэг гэрээ байгуулдаг. Дараагийн засаг гарч ирээд өөрчилдөг.

Тэгээд хөгжлийг хурдасгах стратегийн гэдэг зүйлүүдээ бүх юмтай нь тэгш хэм рүү оруулж байгаад хяргадаг. Ингээд янз бүрийн одоо татвар, гааль, дарамтаар дарамталдаг. Жирийн иргэнээ дарамталдаг. Дэлхийн хэмжээнд Монголыг гаргах томоохон төслүүдээ ч дарамталдаг. Мэдээж алдаагүй юм гэж байхгүй.

Тэгээд төрийн алба хашиж байгаа хүмүүсийг дуудаж авчраад Их Хурал дээр загнадаг. Нөгөөдүүл нь зориггүй, дүлэгнээд болсон болоогүй бөөрөнхийлөөд өнгөрдөг. Энэ бидний бодит байгаа царай.

Уг нь томоохон намууд хамтраад засаг байгуулаад улс орныхоо томоохон хөгжлийг явуулах нь чухал байдаг. Гэхдээ бид тэрийгээ давсан улс төрдөө живдэг. Энэ бидний бодит байдал.

Эрчим хүч адилхан. Манай улсын өрсөлдөх чадвар яг уруудан татаж байгаа 5 шалтгааны нэгд засаглалын хямрал, тогтворгүй байдал чинь —

—эрчим хүчнээсээ өмнө

—бензин шатахуунаасаа өмнө ороод байгаа шүү дээ.

Тийм учраас бодлого боловсруулж, шийдвэр гаргаж байгаа хүмүүс энэ асуудал дээр маш ул суурьтай хандаад Монгол Улсад хөгжлийн бодлого явах юм уу, явахгүй юм уу. Жижиг сажиг зүйл дээр улалдаад хойшлуулаад байх юм уу, үгүй юм уу гэдэг асуултад бид хариулах ёстой.

Миний асуух гэж байгаа асуулт бол Их Хурлын гишүүд, шийдвэр гаргах гэж байгаа хүмүүс өөрсдөөсөө асуугаасай.

Ер нь бид Монголын хөгжлийн бодлогыг далайцтайгаар, үр ашигтайгаар явуулах юм уу, явуулахгүй юм уу. Бүтэн судлаагүй асуудлаа тал талаас нь хэмлээд бид хөгжих юм уу, хөгжихгүй юм уу гэдэг зарчмын асуултыг хаана хаанаа бодоцгооё л гэж үг хэлж байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ асуудлыг дэмжиж байгаа. Энэ маш чухал асуудал байгаа юм.

Яагаад чухал гэхээр энэ гацаанаас гарах гээд байгаа юм. Газрын тосны олборлох салбар чинь 2012, 2013 оны үед 1.1 сая тонныг жилдээ олборлоод улсын төсөвт өдөртөө 1 сая долларын орлого оруулдаг байсан ийм л салбар шүү дээ.

Тэгээд бууран буурсаар өнөөдөр 400 гаруйхан мянган тонн газрын тос олборлоод, тэгээд улсад оруулж байгаа мөнгө нь –

2025 онд 230 тэрбум,
2026 онд хүлээгдэж байгаагаар 230 тэрбум –

-гээд ингээд үлэмж багассан байгаа.

Тэгэхээр энэ яагаад буураад байгаа гэдгийн шалтгаан чинь өөрөө мэдээж хөрөнгө оруулж байгаа тал буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тал гэхэд энэ танилцуулга дээр байна шүү дээ.

- 4.3 тэрбум доллар оруулаад 1.8 саяыг нь газрын тос байдлаар аваад,
- 2.5 саяыг аваагүй л байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ олон жил, 30 жил явчхаад хөрөнгө оруулалт ийм түвшинд байна гэдэг нь өөрөө ашигтай юу, ашиггүй юу гэдэг асуудал байгаа юм.

Тэгээд нөгөө тал чинь өөрсдөө нэмж хөрөнгө оруулахгүй.

Яагаад олборлож байгаа тос буураад байна гэхээр нэмж цооног өрөмдөхгүй байна. Бидний “донк”¹ гэж ярьдаг. Нефтиэ сорж гаргадаг төхөөрөмжөө нэмэхгүй байна. Ингээд байхаар чинь энэ хэмжээ буураад байгаа юм.

¹ Газрын тос олборлолтын “pumpjack” буюу савлуурт насос (хөдөлгөөнт штангат насос).

Энэ ямар аюултай болж байна гэхээр одоо нөгөө дайн байлдаантай холбоотой асуудал гараад ирэхээр нөгөө талд Монгол Улс 2028 оны эхний улиралд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох гэж байгаа.

Бид 1.5 сая тонны хэрэгцээтэй. Үүндээ хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл ходоод руу нь хийнэ.

Тэгэхэд бид өнөөдөр 400 гаруйхан мянгатай буюу үлдсэн сая гаруй тонн газрын тосоо хаанаас авах вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Өөрт байгаад байдаг. Нөгөө олборлож байгаа компанитайгаа учраа олоод олборлолтоо нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд олборлох боломж байгаа дээр бид хуулиудынхаа зөрчилтэй асуудлаас болоод энэ гацаа үүсчээд байна.

Бид шинэ хууль батлахдаа хуучин байгаа хууль, бүтээгдэхүүн хуваах гэрээгээ сайн харж шигтгэж өгөөгүйгээс болоод төрийн байгууллагууд чинь шинэ батлагдсан хуулиар энэ актуудыг тавиад байгаа. Ялангуяа аудит, орон нутаг гээд.

Тэгээд энэ асуудлуудыг цэгцлэх чухал хуулийн нэмэлт, өөрчлөлт учраас үүнийг дэмжиж байгаа юм.

Тэгээд ганц хоёр асуулт байна.

- Энэ асуудлын гацааг гаргаад өгөхөөр нөгөө компанитайгаа ярьж хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх тал дээр ярьсан яриа хэлцэл байна уу?
- Өр ширний асуудал, Монголын талаас үүсээд байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдсэний дараа хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, олборлолтоо нэмэгдүүлэх үү?
- Дээрээс нь хайгуул хийж шинэ талбай руу орох уу?

Тэнд ажиллаж байгаа хүмүүсийн цалингийн асуудал байгаа. Маш бага цалинтай ажилладаг. Яг ажиллаж байгаа салбартайгаа харьцуулахад маш бага цалинтай ажилладаг.

- Тэгэхээр цалинг нь нэмэгдүүлэх үү?

Шинэ ашигт малтмалын тухай хууль нэг концепц явж байгаа шүү дээ. Алтыг нь авч байгаа тэр авдарт нь ахиухан юм үлдээ гэж. Түүн шиг газрын тос ашиглуулж байгаа Дорнод аймаг, тэр дундаа Дорнод аймгийн Матад сум, Халх гол сумууд үүссэн байгаа 5 аравны хэдэн тэрбум гэнэ үү.

- Асуудлыг нь энэ гарсан шийдвэрт нь багтаагаад шийдэх боломж байгаа юу?
- Суманд нь өгөх боломж байгаа юу? Ийм асуултуудыг асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

“Петро Чайна Дачин тансаг” (PetroChina Daqing Tamsag) болон “Доншин Монгол” (Dongsheng Mongolia) газрын тос компаниудтай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэвэл тус компаниудын хувьд нэмж тухайн ашиглалтын талбай дээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлье.

Дээрээс нь хайгуулын хоёр, хоёр талбайг сонирхоод мэдээллийг нь аваад ажиллаж байгаа. Хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлье. Монголын дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангахын төлөө хамтарч ажиллахад бэлэн байна гэдгийг уулзалт болгон дээр бидэнд бататгаж хэлдэг.

Шинэ талбайд хайгуулын ажил хийхэд бэлэн. Өмнө нь талбай дээр барьцаа хөрөнгийг нь төлөөд материалуудыг авсан судлаад явж байгаа.

Цалингийн хувьд өнөөдөр “Петро Чайна Дачин Тамсаг” компанид 422 монгол ажилчид ажиллаж байна. Талбай дээр.

Монгол ажилчдын цалин дунджаар 1100 ам доллар. Мэдээж ажилласан жил, ажлын цаг, орчин нөхцөлөөс хамаарч ялгавартай байгаа.

Хятад ажилчид 2 мянга орчим долларын цалинтай. Гадаад томилолт гэдэг байдлаар монгол ажилчдаас арай өндөр цалинтай байгаа.

Ажилчдын ажиллах орон байр, нөхцөл боломжийг нэмэгдүүлэх талаар тогтмол арга хэмжээ авч ажиллаж байгаа.

Ер нь шинэ хөдөлмөрийн хуулиар 14 хоног ажиллаад 14 хоног амарч байгаа. 1100 долларын цалин бол Монгол Улсын дунджаас дээгүүр орох цалин гэж үзэж байгаа.

Дорнод аймгийн Матад, Халхгол сумдтай үүссэн гурван талт хэлэлцээрийн дагуу ажил хийгдээгүй гэдэг асуудлаар сумдтай маргаан үүссэн, шүүхийн шийдвэр гарсан байгаа. Гэхдээ үүн дээр нэг хүндэтгэх шалтгаан байгаа нь 2020-2023 оны хооронд Ковид-19 цар тахлын улмаас тухайн гүйцэтгэх гурван талт хэлэлцээрийн дагуу хийгдэх ажлуудаа цаг тухайд нь хийж чадаагүй. Гэхдээ 2024, 2025 онд гүйцээж хийсэн ажлууд нь нотлох баримттайгаа байгаа. Үүнтэй холбоотой энэ асуудал маргааныг шийдвэрлэх чиглэлээр Ашигт малтмал, газрын тосны газар ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Бадамсүрэн нарын гишүүдээс мөн хууль санаачлаад энэ хуультай хамт зэрэгцэн хэлэлцэж байгаа.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулаад. Ялангуяа нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг тухайн нөлөөлөлд автаж байгаа аймаг, суманд хуваарилах хуулийн төсөл явж байгаа.

Үүнийг Засгийн газар дэмжиж, НӨАТ-ын зарчмын саналуудыг дэмжээд санал хураалтад оролцож явна. Энэ ингээд тодорхой болгох юм бол орон нутагт үүссэн асуудал шийдэгдэнэ. Тухайн нутгаас сонгогдсон гишүүд энэ тал дээрээ санаачилга тавиад Уул уурхайн яамтайгаа хамтраад бодлого чиглэл нь нэг болоод хамтран шийдэгдэх бололцоо бүрдэж байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя. Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Ажлын хэсэг бүтээгдэхүүн хуваах гэрээгээ хувиар нь хэлээч.

- Монголын талд тэдэн хувь.
- Хөрөнгө оруулагч талд тэдэн хувь гээд.

Хоёрдугаарт нь, бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр Монголын талд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орвол тэргүүн ээлжид тосоор хангах уу гэдэг заалтаа заалтаар нь уншаад өгөөч гэсэн хоёр асуулт ажлын хэсгээс.

Засгийн газраас Тэргүүн Шадар сайдаас нэг амлалт хүсмээр байна. Юу гэхээр бид энэ гацааг гаргахын тулд Засгийн газарт ногдох орлогоос нь энэ асуудлуудыг нь суутган удаан хугацаанд нь тооцож гацааг гаргах гэж байгаа.

Тэгэхээр мэдээж энэ дээр тодорхой хэлцэл, хэлэлцээр хийж таарна. Энэ дотроо орон нутгийн, ялангуяа Дорнод аймгийн ашиглуулж байгаа 2 суманд нь төлөх жоохон мөнгө, 5.6 тэрбум байх шиг байгаа юм. Матад, Халх гол. Энэ асуудлыг нь гэрээндээ оруулаад шийдээд... /минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай.

“Петрочайна Дачин Тамсаг” компани хоёр талдаа бүтээгдэхүүн хуваах гэрээнд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа.

- ➔ Тосон-Уул XIX талбайн өртөгт газрын тос 40 хувь,
- ➔ Ашигт газрын тосны 40 хувийг Монгол Улсын Засгийн газар,
- ➔ Гэрээлэгч 60 хувийг авч байгаа.

Олборлолтын хэмжээ нэмэгдэх тусам Монгол Улсын Засгийн газарт орох өгөөж нэмэгдэх байдлаар гэрээ хийсэн байдаг.

Өдрийн олборлолт 50 мянган тонноос дээш Монгол Улсын Засгийн газарт. Өгөх өгөөж 10 хувиар нэмэгдээд явна гэх жишээтэй.

- Засгийн газарт нийт тосны 24 хувь нь XIX талбай дээр.
- XXI талбай дээр 28.5 хувь нь Монгол Улсын Засгийн газарт.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээт 97 талбай, нийт олборлосон тосны 28.1 хувь нь Монгол Улсын Засгийн газарт тус тус ногдож байгаа.

Үйлдвэрийг түүхий эдээр хангах зохицуулалт гэрээн дээр нэгдүгээрт байдаг. Газрын тосны тухай хууль дээр мөн байгаа.

2011 онд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг болох протокол дээр гэрээлэгч нь өөрт ногдох түүхий тосыг тэргүүн ээлжид Монгол Улсад нийлүүлэхээр заасан байдаг.

Энэхүү протокол нь бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг болно гээд хоёр талаас гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг.

Газрын тосны тухай хуулийн 7.1.6-д Засгийн газрын бүрэн эрх гэж байгаа. 11.2.4-д гэрээлэгчийн үүрэгт Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр баригдсан тохиолдолд “гэрээлэгчид ногдох газрын тос” болон “өртөгт газрын тос”-ыг тэргүүн ээлжинд зах зээлийн үнээр худалдаж авахдаа давуу эрх нийлүүлэх үүргийг бас зохицуулсан байдаг.

Тэгэхээр Монгол Улсад Газрын тос боловсруулах үйлдвэр баригдсан тохиолдолд тэргүүн ээлжид газрын тосыг Монгол Улс давуу эрхийн дагуу худалдаж авах бүрэн боломжтой.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ ер нь ямар учиртай, ашигтай үр дүн өнгөрсөн хугацаанд явсан бэ гэвэл Монгол Улсын төсөвт 3 их наяд төгрөгийг энэ газрын тосны салбараас Монгол Улс олсон байна. Жигд доголлогүй явж байхдаа өдөрт 1 сая доллар Монгол Улсын эдийн засагт шууд орж байсан.

Хамгийн гол нь Монгол Улс ямар нэгэн үүрэг хүлээхгүй, эрсдэл гарахгүйгээр гарсан бүтээгдэхүүний дунджаар 28 хувийг шууд авдаг. Энэ нь дандаа дээшээ нэмэгдэх гэрээ.

Би түрүүний тэр тос яаж хуваагддаг юм бэ гэдгийг ахиад тайлбарлаадахъя.

- Тос олборлолоо. 100 хувь гэж үзэх юм бол –

- 40 хувийг зардалдаа шингээнэ. “**Өртөг тос**” гээд.
- 60 хувь үлдэнэ.

■ 60 хувиа 100 хувь гэж үзэх юм бол түүний –

- 40 хувийг Монгол Улс шууд авна.
- Хөрөнгө оруулагч тал 60 хувиа авдаг гэсэн байдалтай явж байгаа.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний анхны загвар манай 90-ээд онд байсан Засгийн газар их сайн хийсэн.

40 хувь гэдэг бол их өндөр тогтсон байдаг юм билээ. Эрсдэл хүлээхгүйгээр өндөр авдаг.

Тэр орон нутгийн асуудлыг мэдээж энэ асуудлаа шийдэгдсэний дараа бид уулзалтууд, хэлэлцээрийг сунгах. Ер нь гэрээ дуусах дөхөж байгаа. Гэрээгээ сайжруулах, өөрчлөх. Энэ хүрээндээ орон нутгийн асуудлуудаа шийдээд. Ер нь хаана хаанаа ойлгоцгоож байна шүү дээ.

Орон нутгийн асуудал, нийгмийн лиценз гэдэг юмаа хаана хаанаа аваад, орон нутагтаа тодорхой хэмжээний өгөөжийг нь өгөөд.

Одоо бидний хэлэлцэж байгаа ашигт малтмалын хуулиар ч гэсэн орон нутаг өгөөжүүд нэмэгдэж байгаа. Манай М.Бадамсүрэн, Л.Соронзонболд гишүүний санаачилгаар роялтиг нь бүр тодорхой болгож, орон нутагт үлдэх хэмжээг нь нэмэгдүүлэх саналууд энэ дотор шингээд явж байгаа болохоор урд урдахаасаа илүү үр дүн гараад хаана хаанаа. Хөрөнгө оруулагч тал ч тэр, Монголын талд ч гэсэн, орон нутагт ч гэсэн хөгжөөд хожоод аль аль талдаа учир нь олдоод энэ гацаанаас гарна гэдэгт итгэлтэй байгаа.

Энэ маань өөрөө дахин хөрөнгө оруулалтыг газрын тусгай салбарт татах том хөшүүрэг болно.

■ Монголд нөөц байна.

- Их нууруудын савт газар байна.
- Говьд байна.
- Алтайн өвөр говьд байна.

Тэр чигээрээ газрын тосны илэрцтэй, нөөцтэй нь тодорхой байгаад байдаг. Бид ашиглаж чаддаггүй. Зүүн бүсээсээ гарч чадахгүй байгаа юм. Энэ дээрээ нэг бодлогын том өөрчлөлт хийгээд урагшилья л гэдэг хуулийн төсөл юм.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Санал хураалтыг нэгтгээд явуулъя. Дараагийн асуудлаа хэлэлцээд. 16 цаг 30-аас. Дараагийн асуудал товчхон байгаа учраас 16.30-д гишүүдийг цуглахыг урья. Гишүүдийн зөвлөх, туслахууд, мөн бүлгүүдийн дарга, дэд дарга нар, бүлгүүдийн ажлын алба, Их Хурлын хуралдаан зохион байгуулах газар анхааралдаа авцгаана уу. Санал хураалт 16.30-аас цагтаа эхэлнэ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Лхагвасүрэнгийн Соронзонболд нарын урилгаар Хилийн цэргийн 0132 дугаар ангийн эмэгтэй албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа эмэгтэй хилчиддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Эх орныхоо хил манаж байгаа эмэгтэй дайчид маань хүрэлцэн ирсэн байна. Сайхан байна. /алга ташив/

Дараагийн асуудалд оръё.

**Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Х.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6

сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн Байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн Байнгын хороо 2026 оны 6 сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Евразийн хэлэлцээрт нэгдсэн орнуудаас тамхи, тамхин бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй импортлохоор байгаа нь бусад орноос импортолж байгаа гаалийн татвартай ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад үнийн зөрүү үүсэх эсэх, мөн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг гаалийн албан татвараас чөлөөлөх үндэслэл, шалтгааны талаар тодруулан асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хууль, тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хууль тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Х.Болормаа гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангиллын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Ажлын хэсгийн гишүүд Их Хурлын гишүүдийн асуусан асуултад бүрэн гүйцэд, үнэн зөв, товч тодорхой тогтоосон хугацаандаа багтааж хариулахыг хичээгээрэй.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь байсхийгээд Их Хурлын тогтоол гаргаад, 1999 оны тогтоол дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад 2017 онд импортын тамхины гаалийн татварыг өөрчлөх тухай тогтоол гарч байсан юм л даа. 2017 онд 4 сард.

Энэ үеэр импортын гаалийн татварыг 30 хувь болгосон юм. Тамхин дээр. Гэтэл тамхи үйлдвэрлэх зориулалт бүхий тамхийг дөнгөж 5-хан хувь болгосон юм.

Тэгээд энэ дээр юу шалтгаалсан бэ гэхээр тухайн үед “Монгол тамхи Со” компанийн хувьцаа эзэмшигч нь тухайн үеийн Их Хурлын гишүүн байсан хүн байсан л даа.

Тэгээд тэр хүнд нөлөөлөөд энэ татварыг хэтэрхий бага болгосон. Өнөөдрийг хүртэл 9 жилийн туршид энэ хууль үйлчлээд явж байгаа.

Ер нь Дэлхийн худалдааны байгууллага импортолж байгаа ч байсан, дотооддоо үйлдвэрлэж байгаа ч байсан аливаа онцгой татвартай бараа, бүтээгдэхүүнийг ижилхэн хувь хэмжээтэй байх зарчмыг барьдаг.

Тэгэхдээ үүнийгээ яаж шийддэг вэ гэхээр улс орнууд өөр бусад гаалийн татвар нь 30 хувь байлаа гэхэд биш онцгой татварыг нь багасгах ч юм уу, аль эсвэл онцгой татвар нь өндөр байлаа гэхэд гаалийн татварыг нь багасгах ч юм уу ийм байдлаар шийддэг юм л даа.

Гэвч тухайн үед лоббидоод энэ татварыг 5 хувь болгосон. Энэ дээр маш их тийм худалдааны зөрүү гарч, нэг компанид хэтэрхий давуу тал бий болгосон ийм зүйл явж байсан юм.

Тэгээд энэ нь өнөөдрийн Онцгой татварын хууль дахь тамхины асуудлыг шийдвэрлэхдээ нөгөөдхөө яах вэ 30 хувь болгосон байна. 30 хувь болгож. Тэгэхдээ энэ чинь нэг талдаа хэдийгээр тухайн үед хэтэрхий бага хувьтай байна гэж шүүмжилж байсан бол өнөөдөр буцаагаад нөгөө дотоодын үйлдвэрийнхээ тамхины юуг хэт өндөр 30 хувь болгохоор нөгөө үйлдвэр маань дотоодод ажлын байр бий болгож байгаа тэр хүмүүсийн асуудал ямар байдалд орох вэ гэдэгт эргэлзээд эхэллээ л дээ. Лобби ороод бага татвар тавихад нь би шүүмжилж байсан. Энэ хэтэрч байна.

Гэтэл өнөөдөр дотоодын үйлдвэрийнхээ тамхитай адилхан тавихаар энэ чинь дотоодын үйлдвэрлэлийг илүү хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зарчим дээрээ хэр байгаа юм?

Үүнийг одоо тодорхой хувиар багасгаж арай ч 5 хувь болгохгүй 20 хувь болгож дотоодын үйлдвэрээ дэмжих тийм бодлого яагаад барьж болоогүй юм бэ?

Үүнийг жишээ нь Дэлхийн худалдааны байгууллагын зарчмаар яваад адилхан байх ёстой гэдэг зарчим ярьж байгаа бол бусад гаалийн татварыг нь шийдэх замаар энэ асуудлаа яагаад зохицуулаагүй юм бэ гэдэг зүйлийг асуумаар байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Сангийн яам. Ч.Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам, Татварын бодлогын газар Ч.Чимидсүрэн.

Импортоор оруулж ирсэн дүнсэн тамхи болон мөн дотоодод үйлдвэрлэхэд зориулсан задгай тамхинд 5 хувиар гаалийн албан татвар авдаг байсан.

Тэгэхээр үүнийг гааль дээрх бүх татваруудаа тэглээд тэгээд онцгой албан татвар дээр бүгдийг 30 хувь болгож байгаа таны хэлсэн байна.

Тэгэхээр энд нэг ийм юу байгаа юм. Дэлхийн худалдааны байгууллагын 1947 оны тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасны дагуу Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улс орнуудын дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах зорилгоор дотоодын болон импортын нэг ижил бараанд ялгаатай татвар хураамж тогтоохыг хориглосон байдаг.

Ийм учраас бид импортын янжуурт ногдуулж байгаа 30 хувийн онцгой албан татварыг дотоодын үйлдвэрийн янжуурт мөн адил ногдуулахаар хуулийн төслөө боловсруулсан байгаа.

С.Бямбацогт: Б.Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Дэлхийн худалдааны байгууллагын өөр заалтаар дотоодынхоо үйлдвэрлэлийг хамгаалахын тулд импортын гаалийн татварыг өндөр тавиад, дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжээд, тэгсэн мөртлөө өндөр тавьсан тэр тарифаа жил болгон буулгах замаар дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжээд, тэгээд ижилхэн байх зарчим явдаг байхгүй юу даа.

Та нар нэг болохоор хэтэрхий бага тавьж, тухайн үеийн Их Хурлын гишүүний лоббинд ороод, нэг болохоор нөгөө хүн нь талийгаач болонгуут нь өндөр тавьдаг харгис хачин юм хийдгээ болиорой гэж зөвлөмөөр байна. Ажлын хэсгийн та нарт ямар хамаа байх вэ. Засгийн газар.

С.Бямбацогт: Хариулах уу? Хэрэггүй юу?

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Өнөөдөр бид Онцгой албан татварын хууль Засгийн газраас нэн яаралтайгаар 6 сарын 17-нд өргөн барьж, хоёр долоо хоног хүрэхгүй хугацаанд бид хэлэлцэн батлахаар явж байна.

Ер нь сүүлийн үед манай Улсын Их Хурал нэн яаралтайгаар маш олон асуудал гурилд нь гэдэг юм уу, машинд нь гэдэг юм уу явж байна.

- Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай үүний өмнөх асуудал 6 сарын 18-нд Улсын Их Хуралд өргөн баригдсан. 10 л хонож байна.
- Нийгмийн даатгалын багц хууль 6 сарын 12-нд өргөн баригдсан. 2 долоо хоног л болж байна.
- Бизнесийн эрх чөлөө гээд баахан дагасан 100 хэдэн хуультай хууль 6 сарын 03-нд өргөн баригдсан. 3 долоо хоног л болж байна.

Бүгдийг нь машиндаад батлах гэж байна л даа. Тэгтэл өргөн бариад жил орчим болж байгаа Тамхины хяналтын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг ирэх Пүрэв гарагт чуулганаараа хийх гэж байна. Энэ хуулийн хэлэлцүүлгийг ер нь гацаах, хойшлуулах маш олон оролдлого байсан.

Өнөөдөр янжуур нь байна уу, электрон тамхи нь байна уу, импортлогчид нь байна уу бүгдээрээ нэгдэж байгаад Ерөнхийлөгчид хандсан тухай мэдээлэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа юм.

Үгүй ээ, бүр эмгэнэлтэй. Энэ дээр. Монгол Улсын Ерөнхийлөгч өө, энэ хуулийг гацааж өгөөч ээ. Улсын төсвийн орлого буурна. Ажлын байр цөөрнө гээд. Хэзээ тамхины гадаад, дотоодын компаниуд Монгол Улсын төсөвт, Монгол Улсын ажлын байранд санаа зовдог болсон юм. Ашгаа л боддог шүү дээ. Монгол Улсын иргэдийн эрүүл мэндээр жилд эдийн засгийн хувьд 800 тэрбум төгрөгийн алдагдал хүлээдэг ийм л асуудал шүү дээ.

Тэгээд эрүүл мэндийг хамгаалах тамхины хуулийг эсэргүүцэх болохоороо ерөөсөө үеийн үед нэг шалтаг нь далд зах зээл бий болно. Гэтэл энэ ерөөсөө тийм биш байхгүй юу. Бүгд тооцоо судалгаатай. Далд зах зээл гэдэг худлаа шалтгаар. Үнэхээр тийм биш. Үүнийг далимдуулаад л төрийн шийдвэрт нөлөөлөөд, яаж энэ хуулийг гацаах вэ гэсэн ашиг сонирхлын бүлэг л ийм том илрэлээ бий болгож байна.

Ийм хэмжээний ил цагаан лобби яваад, эцэс сүүлдээ бүр Монгол Улсын Ерөнхийлөгчийг шантаажлах хэмжээнд очсон байна шүү дээ.

Тэгээд энэ хуулийг боловсруулаад явж байхад элдвээр бүтэн нэг жил гаруй би хэлүүлж байгаа. Нэг талыг нь барьсан. Нэгэнд нь давуу эрх олгосон, юу юу ч гэлээ дээ. Элдвээр гүтгэж харлуулж, мэдээллийн манипуляц хийсэн.

Хар даа. Бүгдээрээ ингэж байгаа юм.

- ➔ “Волтам” гэдэг компани дистрибьютер хийдэг.
— “Жэй Ти Ай” (JTI, Japan Tobacco International).
- ➔ “Алтан гадас” гэдэг компани байдаг.
— “Кэй Ти энд Жи Корпорэйшн” (KT&G).

Вэйпний (vape) монопол компани, электрон тамхины (e-cigarette) монопол компани. Электрон “Цахиур” гээд холбоо хамаарал бүхий компаниуд нь бүгдээрээ нэгдэж гарын үсэг зураад энэ тамхины хуулийг гацааж өгөөч ээ, Ерөнхийлөгч гэж байгаа байхгүй юу.

Ёстой нөгөө “худал хурдан боловч үнэнд гүйцэгдэнэ” гэдэг л энэ л болж байна шүү дээ.

Намайг гүтгэж янжуурынхан тал ч гэнэ үү, вейпнийх нь тал ч гэнэ үү, угтаа эд нар бүгдээрээ нэгдмэл ашиг сонирхолтой энэ хуулийг гацаах, батлуулахгүй байх ийм л зорилго эцсийн эцэст байсан гэдэг нь үүгээрээ нотлогдож байна шүү дээ.

Ингээд энэ хууль угаасаа эцсийн хэлэлцүүлэг нь дөрөв дэх өдөр явна. Тэгээд Монгол төр тамхины компаниудынхаа лоббинд дийлдэх юм уу, дийлэх юм уу гэдгийг харах өдрүүд ирж байна.

Тэгээд асуулт байна. Тамхины хяналтын тухай хууль Пүрэв гарагт эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Энэ хуулийн эцэслэн батлахыг энэ долоо хоногийн Баасан гарагийн 7 сарын 03-нд чуулган хаахаас өмнө хийх үү?

Дэгийн тухай асуудлыг би бүлэг дээрээ ч гэсэн ярьсан. Энэ дээр би албан ёсны тайлбарыг өнөөдөр чуулган дээрээ протоколтой, энэ дэг тайлбарлах албан ёсны хүмүүс байвал авмаар байна. Эсвэл Улсын Их Хурлын дарга. Энэ дээр би албан ёсоор тайлбарыг нь протоколд үлдээж авмаар байна.

С.Бямбацогт: Тамхины хяналтын тухай хуулийг манай О.Номинчимэг нарын олон гишүүн өргөн барьсан. Жил гаруй болж байгаа нь үнэн.

Би Улсын Их Хурлын дарга болоод үндсэндээ ажлын хэсгийг нь шинэчилж байгуулаад 2 сарын хугацаанд хэлэлцүүлгүүд хийгдээд, ажлын хэсэг хуралдаад, дунд нь ойлголцох, ойлголцохгүй олон асуудал үүсээд өдий хүртэл явсан.

Энд ямар нэгэн надад тийм удаасан, гацаасан зүйл огт байхгүй. Жил гаруй гацсан хуулийг харин би ч сүүлийн хоёр сарын дотор хурдан хугацаанд явууллаа шүү.

Үүнийг манай ажлын хэсгийн гишүүн, хууль санаачилсан гишүүд бүгд ойлгож байгаа байх.

Засгийн газар олон хууль өргөн барьсан. Үнэн. Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Нийгмийн даатгалын хууль, Газрын тосны хууль гээд. Үүнийг яаралтай горимоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хэлэлцээд бид батлах гээд хэлэлцүүлэг хийгээд явж байна.

Энэ бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай хуульд үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн бол үүнийг хэлэлцүүлэг хоорондын хугацаа хамаарахгүй. Бусад хуулиуд дээр Засгийн газрын өргөн мэдүүлсэн болон Их Хурлын гишүүдийн, Ерөнхийлөгч гээд хууль санаачлах эрхтэй 128 субъектийн санаачилсан хуулиуд ердийн горимоор явахдаа хэлэлцүүлэг хоорондоо заавал 5 хоногийн гэсэн зохицуулалттай. Энэ дагуу л явж байгаа. Ингээд л явж байгаа. Манай О.Номинчимэг гэж ойлгож байгаа байх.

Тамгын газар эцсийн хэлэлцүүлэг, эцэслэн батлах хоёрын хооронд 5 хоногийн хугацаа. Энэ дээр албан ёсны хуулийн тайлбар, лавлагаа хэлж өгөөч.

Ж.Бямбадулам: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 30.1-д эцэслэн батлах үе шат нь 30.1-д заасан 4 үе шатын нэг хэсэг болж байгаа.

44.1-д заасан эцэслэн батлуулах хувилбарыг гишүүд судлах бодит боломжийг хангах үүднээс дэгийн тухай хуулийн 32 дахь хэсгийн ажлын 5-аас доошгүй өдрийн хугацааг баримтлахаар заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дэгийн зөвлөгөө өгч хаврын чуулганаар хэлэлцэн баталсан бүх хуулийн төслүүд яг энэ дэгийн дагуу явж байгаа.

Дэгийн тухай хуулийн 30.1-д 4 үе шаттайгаар хэлэлцэн батална гэж заасан. Яг “эцэслэн батлах” гэдэг үг дээрээ “хэлэлцүүлэг” гэдэг үг байхгүй байгаа ч энэ нь цогц 4 үе шаттай процессын нэг хэсэг болж байгаа.

Тэгэхээр бид нэг үгээс болоод хамгийн сүүлийн “эцэслэн батлах” гэдэг энэ процессыг салгаж тайлбарлах боломжгүй байгаа юм.

Дэгийн тухай хуулийн 44.1-д Байнгын хороо эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараах үүрэгтэй гэж заасан.

Харин 44.2-т уг хувилбараар нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна гэж тогтоосон.

Өөрөөр хэлбэл гишүүдийн хууль батлах эцсийн шийдвэрийн шууд үндэслэл болох хувилбар нь эцсийн хэлэлцүүлгийн дараа бэлтгэгдэж гишүүд танилцуулагддаг учраас хэлэлцүүлгийн салшгүй нэг хэсэг бөгөөд зөвхөн санал хураалт гэж ойлгож хязгаарлаж болохгүй юм.

С.Бямбацогт: О.Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Орж, гараад шууд эцсийн хэлэлцүүлгээ эцэслэн баталж байгаа яаралтай дэгийнхээ асуудал дээр гишүүдэд танилцах хугацаа өгч байгааг та нар тэгвэл яаж тайлбарлах юм? Танилцахгүй л байгаа шүү дээ.

Би энэ Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргаар ажиллаж байсны хувьд дэгийн хуулиа мэднэ.

30.1, 30.2. Үүний дараа Байнгын хороогоор хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг, Байнгын хороо, чуулганаараа бүгд гишүүд хэлэлцүүлж асуулт асууж, үг хэлж хариулт авах хэлэлцүүлэгтэй явдаг.

Эцэслэн батлах процесс ерөөсөө Байнгын хороон дээр байдаггүй. Зөвхөн чуулган дээр ямар ч хэлэлцүүлэг байхгүй, асуулт асууж, үг хэлэхгүйгээр эцэслэн батлах ийм процесс явдаг. Санал хураалт явдаг гэсэн үг. Ямар ч хэлэлцүүлэг байхгүй.

Би цагаан дээр хараар бичсэн ийм тайлбар өгч байгаад харамсаж байна. Яагаад гэвэл Тамгын газар өдийг хүртэл бүх асуудал дээр зөв зүйтэй дэгийн зөвлөгөө өгч байсан гэдэгт би эргэлзэж байна. Яагаад гэвэл өмнө нь ч гэсэн өмнөх Улсын Их Хурлын дарга нарын хувьд ч гэсэн дэгийн хуулийн 36.12, 13... /минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Дахиад нэг минут байхгүй. Асуултаа гүйцээчих.

О.Номинчимэг: 36.12, 13-ыг ер нь дандаа л зөрчиж ирсэн шүү дээ. Бүгдээрээ.

Сая Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дарга, үгүй ээ, энэ чинь дэгийн хууль чинь ийм байна шүү дээ. Практик чинь буруу байна. Дэгийн хуулиараа явна гээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, хэлэлцэх эсэхээ хийж байхдаа Байнгын хорооны саналаар биш “хэлэлцэх эсэхийг дэмжье” гэдэг томъёоллоор хураадаг болсон шүү дээ.

Үүнийгээ яаж тайлбарлах юм. Тамгын газар. Дандаа дэг зөрчсөн зөвлөгөө өгч байснаа яаж тайлбарлах юм. Ийм ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэж болохгүй шүү дээ. Нэг талдаа гаргах хэрэгтэй. Протокол дээр үүнийг тэмдэглүүлэх хэрэгтэй. Чуулган дээр төрийн албан хаагч нар худал мэдээлэл буруу мэдээлэл өгөхгүй байх хэрэгтэй. Албан ёсны дүгнэлтээ гаргах хэрэгтэй.

С.Бямбацогт: Урьд нь Улсын Их Хурлын Тамгын газрын дэгийн зөвлөхүүд маань Үндсэн хууль зөрчсөн томьёоллоор санал хураалт хүртэл хураалгаад, асуудал үүсээд, шалгагдаад бөөн асуудал болсон. Та бүхэн мэдэж байгаа.

Урьд нь дэг зөрчдөг байсан байж магадгүй. Одоо дэг зөрчихгүй байгаа. Хуулиа дээдэлж байгаа.

Сая Та хэллээ. Дэгийн хуулийн 36.11, 12 чинь урьд нь хамаагүй тэгээд хуулиа зөрчөөд хураалгаж байсан бол одоо тэгвэл хууль зөрчихгүй болгоод хуульд нийцүүлээд санал хураадаг болсон гэдгээ албан ёсоор протокол тэмдэглэж хэлье.

Би бас Улсын Их Хурлын Тамгын газраас гадна Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөхөөс асуусан.

Урьд нь өмнөх Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх байсан Н.Отгончимэг гээд зөвлөх байдаг. Давхар нягталж асуусан. Яах аргагүй эцсийн хэлэлцүүлэг, эцэслэн батлах хооронд зайлшгүй 5 хоногийн хугацаа байх ёстой. Хууль дээр цагаан дээр хараад бичсэн байна. Энэ дэгээр явахаас өөр аргагүй гэж надад тайлбарласан байгаа. Та манай Н.Отгончимэг зөвлөхийг таних байх. О.Номинчимэг гишүүн асуучхаарай.

Дараагийн асуудал. Засгийн газрын өргөн барьсан ердийн хуулиуд. Одоо Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн. Одоо эцэслэн хийх гэж байгаа билүү, юу билээ. Хийсэн байх. Тийм үү. Эцэслэн батлах нь ингээд 5 хоногийн хугацаанд багтахгүй намрын чуулган руу орж байгаа.

Иймэрхүү байдлаар Засгийн газрын өргөн барьсан бүх хуулиуд хэлэлцэх эсэх, эцсийн хэлэлцүүлэг, маргааш нь эцэслэн батлах гээд яваад байхгүй байгаа шүү. Бас л Засгийн газар яаралтай батлаад өгөөч ээ гэсэн. Ажлын хэсэг, Байнгын хороод ажлаа хийхгүй удсаар байгаад л ингээд энэ хуулиуд амжихгүй болж байгаа юм.

Тийм болохоор хууль санаачлагчид нь ажлын хэсгээ яаралтай хуралдуулах, Байнгын хороодоо хуралдуулах, чуулганаар хэлэлцүүлж хаврын чуулганаар багтаах энэ талдаа өөрсдөө араас нь анхаарч ажилладаг баймаар байгаа юм.

О.Номинчимэг гишүүн их санаачилга гаргаж гүйсэн. Гэхдээ даанч ажлын хэсэг нь хэдэн сар ирц нь бүрдээгүй юм билээ шүү дээ.

Тийм учраас аргаа бараад ажлын хэсгийн гишүүдийг сольсон. Явсаар байгаад л ийм байдалд орсон.

Ж.Чинбүрэн ажлын хэсгийн ахлагч маш сайн ажилласан. Тийм болохоор бид ашигт малтмалын хуулиа баталмаар байна, тамхины хуулиа баталмаар

байна. Засгийн газрын өргөн барьсан, гишүүдийн өргөн барьсан. Гэтэл ганцхан хууль зөрчиж болохгүй учраас ийм болоод байгаа. Тийм болохоор хуулийг өөрийнхөө хүсэл зоргоороо тайлбарлаж болохгүй. Үүнийг Та бүхэн зөв ойлгоорой. Ганцхан Их Хурлын гишүүд хуулийг бүгдийг мэддэг биш шүү. Үүнийг ойлгох хэрэгтэй шүү.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Би тамхины хууль санаачлагч гишүүдийн нэгийн хувьд дахиад тодруулъя.

Тэгэхээр ер нь нийгмийн эрүүл мэндийн асуудал байхгүй юу. Хүүхэд, залуучуудын эрүүл мэндийн асуудал. Жилд хэчнээн мянган хүн тамхинаас болж өвдөж байгааг бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр ер нь ямар асуудлыг яаралтай гэдэг ангилал руу оруулдаг юм бэ? Би дахиад асууя.

Нийтийн эрүүл мэндэд хор хөнөөлтэй байгаа асуудал ер нь яаралтайдаа ордог юм уу. Яг энэ яаралтай гэдэг асуудал дээр яг яаж эрэмбэлж оруулж ирээд байгаа гэдгийг Улсын Их Хурлын дарга болон Тамгын газраас тайлбар хүсэж байна. Нэгдүгээрт.

Хоёр гэвэл дахиад нийтийн эрүүл мэндтэй уялдана л даа. Онцгой татвартай холбоотой асуудал хөндөж байгаа учраас би мэргэжлийн хүмүүс ирсэн байгаа учраас тодруулах гээд байгаа.

2027, 2028, 2029 оноос эхлээд манайх чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны тогтоосон биет нэгжид онцгойд албан татвар ногдуулна гэсэн байгаа. Би хэдэн сарын өмнө асуухад бэлтгэл хангагдаагүй байгаа гээд гэсэн. Одоо тэр бэлтгэл нь хангагдсан уу гэдэг мэдээллийг авъя.

Чихэртэй ундааны татварыг ер нь ямаршуу маягаар зохицуулалт хийж ирж байгаа вэ? Яагаад гэвэл 100 миллилитрт агуулагдах чихэр чихэр орлуулагч 5 граммаас дээш гэж байгаа юм. Энэ бүр 5 грамм байтугай 8, 10, хэд дахин өндөр байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ер нь Та нар бэлэн байдал чинь хангагдсан юм уу? Одоо ахиад онцгой татварууд нэмэгдэж байна.

Тэгэхээр энэ дээр ер нь хэр бэлтгэл хангагдсан гэдгийг тодруулъя. Хариулт дээр үндэслээд дахиад тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон. Индрийн. Дараа нь Тамгын газар тэр яаралтай болон бусад асуудлууд дээр тодорхой хариулт өгөөдөх. Гишүүдийн эргэлзээг тайлах ёстой байх. Ямар нэгэн байдлаар Засгийн хуулиуд

дээр давуу байдал олгоод байгаа юм уу, гишүүдийн хуулийг дараад байгаа юм уу. Тийм юман дээр хариулах нь зөв шүү.

Ажлын хэсэг хэн хариулах юм?

Ч.Чимидсүрэн: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Чихэр, чихэрлэг ундааны онцгой албан татварын хууль 2027 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ.

Үүнтэй холбоотой бэлтгэл ажлуудыг үлдэх 6 сарын хугацаанд гааль болон татварын байгууллагууд дээр бэлтгэлээ хангаад 2027 оны 01 сарын 01-нээс бүрэн хэрэгжүүлээд явахаар ажиллаж байна.

С.Бямбацогт: Тамгын газар асуултад хариулах уу? Тодруулах юм уу? Тамгын газар. Ж.Бямбадулам дарга хариулъя.

Ж.Бямбадулам: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх асуудлыг зохицуулж өгсөн.

Энд Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасан байгаа. Зохицуулалт нь.

Яаралтай хэлэлцүүлэх асуудлыг дэгийн хуулийн 30.2-т энэ хуулийн 33.1-д заасан яаралтай хэлэлцүүлэх болон хуульд батлах хугацааг нь тусгайлан зааснаас бусад хуулийн төслийн хэлэлцүүлэг хоорондын хугацаа ажлын 5-аас доошгүй өдөр байна гээд Улсын Их Хурлын Тамгын газар яг энэ дэгийн дагуу хуулийн төслүүдийг хэлэлцүүлэг, цаглаврын дагуу хэлэлцүүлж байгаа.

Дэгийн энэ өөрчлөлт нь 2024 онд шинэчилсэн найруулгаар орсон зохицуулалт байгаа.

С.Бямбацогт: О.Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Баярлалаа.

Тэгэхээр яаралтай гэдэг процессыг нь би ингэж ойлголоо. Засгийн газрын хуралдаанд хуралдаад шийдвэр гаргаад, тэгээд үндэсний аюулгүй байдлын

асуудалтай холбоотойгоор ийм ийм эрэмбэ байна гэж оруулаад бичгээр хүсэлт Улсын Их Хурлын даргад тавьсан тохиолдолд. Энэ бол процесс л байна л даа.

Би яаралтай гэдэг тэр шинжийг яг ямар асуудалд эрэмбэлж оруулдаг юм бэ л гэж асуугаад байгаа юм.

- Нийтийн эрүүл мэндийн асуудал яаралтайд орох уу?
- Бага насны хүүхдийн асуудал яаралтайд орох уу?
- Гамшиг, цар тахал гэдэг яаралдаад орох уу? Тийм ээ.

Хэрвээ яаралтай гэдэг асуудлын эрэмбэд байдаг бол тэр дотор нь нийтийн эрүүл мэндийн асуудал нь хэддүгээрт нь байдаг юм бол оо? Тийм ээ.

Иймэрхүү эрэмбэ дарааллын мэдээлэл байна уу л гэж асуугаад байгаа юм.

С.Бямбацогт: Хэлэлцэж байгаа асуудлаа солиод явчихлаа. Тийм.

Тийм болохоор Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Засгийн газар л зөвхөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Тэрийг үнэхээр тийм байна гэж үзэх юм бол Их Хурлын гишүүд санал хураалтаар яаралтайгаар хэлэлцдэг дэгтэй гээд сая тайлбарлаад өгчихлөө.

Хууль тогтоомжийн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, Ерөнхийлөгч хууль тогтоолын төсөл санаачлах хүрээ хязгаарыг заасан байгаа.

Тэр хүрээ хязгаарын хүрээнд л асуудал явагддаг. Тийм болохоор Хууль тогтоомжийн тухай хууль, мөн Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудаа л гишүүд маань сайн судалчхаарай. Баярлалаа.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Тамхины онцгой татварыг нөхөж тавих тухай, тохируулах тухай хууль яаралтайгаар орж ирж байна л даа.

Энэ хуулийг нэг харахаар энгийн ч юм шиг. Нөгөө харахаар Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээр гэж татвараа тэглэж байна гэххээд зөрүүлээд өөр төрлийн татвар тавьж байгаа асуудал. Ердийн юм шиг. Гэтэл үүний цаана нөгөө баталсан олон улсын хэлэлцээр нь хэрэгжиж эхлээгүй байхад өөр төрлийн татвар ногдуулж байдаг.

Энэ нь олон улсын гэрээ хэлэлцээрийнхээ зарчимд хэр нийцэж байдаг юм бол? Энэ хариуцсан хүн нь ямар хүн байна вэ? Сайд нь хэн хариулах юм бол оо?

Олон улсын гэрээ хэлэлцээрээрээ чөлөөт худалдаа гэгчхээд өөр нэг бүтээгдэхүүнийг тасалж аваад татвар нөхөн тавихаар энэ өөрөө Дэлхийн худалдааны байгууллагын тэр дүрэм журамдаа хариуцлага санцтай юу байдаг юм? Хамаагүй болж байгаа юу, бүтэж байгаа юу?

Нөгөө Евразийн 5 орон чинь зөрүүлээд Монголоос гарсан экспортыг чөлөөтэй тэглэнэ гэсэн тэр хэлэлцээрээ биелүүлэх үү, биелүүлэхгүй юу? Энэ чинь тэгээд ер нь хамаагүй болчхож байгаа юм биш үү? Ямар ч утгатай жилийн дотор наана цаана анхнаасаа энэ асуудлаа зөв зүйтэй яриад ч явж болдоггүй. Нэг хүнтэй хэлэлцээр хийлээ. Маргааш нь шал өөр юм яриад. Энэ чинь утга учир гэдэг юм үүнд чинь байна уу?

Энэ дээр нэг хариулт өгөөч. Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм журам чинь нийцэж байгаа юм уу? Нөгөө улс орнууд чинь, нөгөө 5 орон чинь дураараа асуудлаа яриад зөрүүлээд ирэхээр энэ гэрээ хэлэлцээрийн чинь утга учир, мөн чанар цаашдаа байж байгаа юу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд нар Оюу Толгойн хэлэлцээр яг хийгдэж байна. Яг одоо Ерөнхий сайдын өрөөнд. Энэ дээр сууж байгаа болохоор байхгүй байгаа шүү. О.Цогтгэрэл гишүүн зөв ойлгоорой.

Сангийн яамнаас хариулах уу? Энэ чухал асуудал. Нэг талдаа чөлөөлнө гээд байдаг. Нөгөө талдаа татвар тавиад байгаа чинь зөв гэж байна. Хариулъя.

Ч.Чимидсүрэн: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Татварын бодлогын газар Ч.Чимидсүрэн

Тэгэхээр Евразийн түр хэлэлцээр, ер нь олон улсын зохицуулалтаар хийгдсэн худалдааны хэлэлцээрийн асуудал дээр зөвхөн гаалийн татварын асуудлыг хөндөж байгаа юм.

Тэгэхээр бид гаалийн татвар дээрээ 5 улс орноос гаалийн татварыг тэглэхээр хэлэлцээр хийгдэхээр зэрэг манай дотоодын зах зээл, ердийн бизнесийн зах зээлийн үйл ажиллагаанд ийм доголдолтой үйл ажиллагаа гарч ирж байгааг бид бүхэн бүгдээрээ анзаарч байгаа.

Тэгэхээр тамхи өөрөө нийгмийн эрүүл мэнд болоод нийгэмд нэлээдгүй тийм нөлөөтэй ийм зохицуулалт. Түүнийг нь онцгой албан татвараар зохицуулах олон улсын практикууд байгаа юм.

Тийм учраас бид өмнө нь тамхин дээр онцгой албан татварыг биет хэмжээнд ногдуулдаг. Дээр нь үнийн дүнд ногдуулах буюу хайбрид хосолсон онцгой албан татварын зохицуулалтыг оруулж ирж байгаа. Бидний судалснаар 63 улс оронд биет болон үнийн дүнгээс нь хосолсон хэлбэрээр авч дотоодынхоо

хууль дүрмээр зохицуулсан зохицуулалт байгаа учраас энэ практикийг л хэрэглэж зохицуулалт хийсэн байгаа.

С.Бямбацогт: О.Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Үгүй ээ, яах вэ. Асуултад тэр чигээр нь эргээд л байгаагаар нь хариуллаа л даа.

Миний хэлж байгаа нь нэгдүгээрт нь энэ чинь тоглож байгаа юм шиг. Анхнаасаа энэ чинь тов тодорхой л асуудал байсан шүү дээ. Тэнд чөлөөлч татваргүй болгочоод, хэрэгжиж эхлээгүй байхад ийм асуудал ярьж байгаа нь өөрөө утга учиргүй.

Хоёрдугаарт нь, наад олон улсын байгууллага чинь зүгээр л баахан чөлөөллөө гэгчхээд өөр татваруудаар нөхөөд, ялгаатай татварууд наана цаана тавиад байдаг юм бол ер нь наад улсын хэлэлцээр чинь утга учиртай ч юм уу, үгүй ч юм уу. Гаалийн татварт хамаардаг гэж байгаа бол НӨАТ-аар ялгаатай баахан татвар тавиад зарим бүтээгдэхүүнүүд дээр өөр өөр татвар тавиад явах юм байна л даа.

Яг үүний цаана нөгөө талд нь нөгөө улс орнууд чинь татварын болоод тарифын, тарифын бус янз бүрийн арга хэмжээ авах бололцоо нөхцөлүүдийг чинь нөгөө талд нь бодлогогүйгээсээ болоод, жилийн дараах үйл ажиллагаагаа хараагүйгээсээ болоод манайх үндсэндээ гэрээгээ зөрчиж л эхэлж байна.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхэлж байгаа асуудал.

Бид Евразийн хэлэлцээрт нэгдсэн. Евразийн хэлэлцээрт нэгдэхдээ бид импортын гаалийн татваруудыг хөнгөлөөд, чөлөөлнө гээд хэлэлцээрт нэгдсэн байгаа. Гэтэл импортын гаалийн албан татвартай байсан тамхийг онцгой албан татвартай болгож байгаа чинь нөгөө 5 орон чинь хүлээн зөвшөөрөх юм уу. Ингээд ерөөсөө ялгаагүй л гээд байгаа юм биш үү гэдэг асуулт О.Цогтгэрэл гишүүн асуугаад байна л даа. Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Евроазийн холбоотны орнуудтай байгуулж байгаа худалдааны түр хэлэлцээр 3 жилийн хугацаатай үргэлжилнэ.

Энэ зөвхөн гаалийн татварын асуудлыг тусгаж харилцан хөнгөлж байгаа. Нийт 367 төрлийн бараа. Монгол Улсын нийт барааны 90 гаруй хувь нь хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн манай уламжлалт бараа. Хүйтэн, сэрүүн бүсийн 180 сая хүнтэй зах зээлд нэн таатай татварын орчинд нэвтрэх бололцоотой.

Өмнө нь 15-аас 55 хувийн татварын босго байсан ийм бараанууд тэг болж байгаа.

Тамхитай холбоотой асуудал үүссэн. Бид гаалийн татвараа мөн тэг болгох үүрэг хүлээсэн. Энэ дагуу биелнэ. Онцгой албан татварын зохицуулалтууд харин гишүүн орнуудын өөрийн бие даасан байдал, тухайн хамгаалах ёстой бараан дээрээ онцгой албан татвараараа зах зээлээ хамгаалах зохицуулалт хийж байгаа. Тэр бодлогын үүднээс тамхины гаалийн татвар. Зөвхөн Еврази төдийгүй бүх орнуудаас импортолж байгаа тамхины гаалийн татварыг тэг болгоод, онцгой албан татвараа өсгөж, босгож ирж, тэнцвэржүүлж байгаа хууль орж ирж байгаа. Ингэснээр худалдааны өрсөлдөөн, тэгш байдлыг хангаж байгаа ийм л зохицуулалт шүү дээ.

Зарим гишүүд жоохон андуураад өөр юмтай холиод байсан. Ингэснээр Монгол Улс Евразийн орнуудтай 7 сарын 22-ноос гэрээ үйлчилнэ. Гэрээ үйлчлэхэд үндсэндээ бэлтгэл ажил хангагдаж байгаа юм.

Бид нэлээн цаг алдаад зохицуулж чадахгүй байсан тамхины асуудлаа ийм хувилбар дээр. Гаалийн татвараа тэглэе. Онцгой татвараа нэмэгдүүлье гэж явж байгаа.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Хариултуудаа ерөнхийд нь авлаа. Би саналаа хэлье.

Онцгой албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Евразийн хэлэлцээртэй холбогдолтой асуудал дээр тодорхой бусад улсуудын зүгээс ямар нэгэн хэлэлцээртэй холбогдолтой санал юмнууд гаргах уу гэдэг асуултыг асууя гэж бодож байлаа.

Их Хурлын дарга, удирдлагуудад хандаж хэлэхэд тамхины хуулийн ажил дээр нэлээн анхаарал хандуулаад явахыг дэмжиж байна.

Зарим хуулиуд бүтэн жил болж байж батлагдаж байгаа асуудал дээр анхаарлаа хандуулаад явах нь зөв гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Үүнийг анхааралдаа аваад хаврын чуулгандаа багтаах талаас нь харвал яасан юм бэ. Ер нь тамхины тухай хууль хамгийн олон гишүүд өргөн барьсан цөөхөн хэдэн хуулийн нэг байгаа.

Тийм учраас гишүүн болгон өөрсдөө нийгмийн явж байгаа процесс дээр дүгнэлтүүдээ хийгээд энэ хууль батлагдаасай гэсэн байр суурьтай байгаа юм.

Үүнийг хагалаад хаврын чуулгандаа багтаад хийх нь зөв байна гэсэн байр суурийг би нэмж илэрхийлье. 70 гаруй гишүүд сунаад ажиллахад буруугүй байгаа болов уу гэж бодож байна. Шаардлагатай бол долоо хоногоор Их Хурлынхаа чуулганыг сунгаад, үлдэж байгаа асуудлуудаа хэлэлцэхэд ч буруугүй юм байхгүй.

Энэ дээрээ Та бүхэн дахиж ярилцах нь зөв гэсэн байр суурьтай байна.

Онцгой албан татвартай холбогдолтой асуудал дээр гишүүд сая асуулаа. Цаашдаа импортын болон дотоодын үйлдвэрлэлийн хооронд ялгамжтай байх, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих гэдэг агуулга дээр анхаарал хандуулах зохицуулалтуудыг Татварын ерөнхий газар, Сангийн яамныхан тийм байр сууриас хандах нь зөв гэсэн байр суурьтай байгаа. Олон улсынхаа хэлэлцээрийн дагуу жигд байхаар орж ирж байгаа юм байна.

Евроазийн хэлэлцээрийн 7 сарын 20-ноос хэрэгжиж эхлэх байх.

Тэгэхээр бусад улсууд хориг, ийм арга хэмжээнүүд авах нөхцөл бүрдэх вий дээ. Энэ чиглэлд бусад улсуудын санаа бодлыг тусгаж байгаад ч байдаг юм уу, ямар нэгэн сөрөг арга хэмжээ авах вий гэсэн эмзэглэл байна.

Тийм учраас энэ чиглэлээр уулзалт юмнууд хийсэн бол тэр талаараа тодруулж хэлж өгнө үү гэдгийг ахиж тодруулъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Үг хэлсэн үү? Үг хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхбат: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг яаралтай горимоор оруулж ирээд бид хэлэлцэж байна.

Яах вэ, ач холбогдол юмнууд зөндөө байгаа. Тэрийг ойлгож байгаа.

Манай Засгийн газраас оруулж ирж байгаа хуулийн төслүүд сайхан ногоон гэрлээр хурдан шуурхай явж байна. Цаг хугацаатай уралдаж байгаа юмнууд ч байдаг байх.

Гэхдээ бид гадаад ертөнц талдаа наадам, баяр ёслол дөхөхөөр хуулиудыг ёстой гялалзуулж байна. Түүгээр л хамаг гол юмнуудаа хийгээд байна гэдэг хардлага сэрдлэг, шүүмжлэлүүд байгаад байдаг. Үүнийг бид бодолцох ёстой гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, бид энэ тамхитай холбоотой юман дээр онцгой албан татвар авах ёстой. Энэ зарчмын асуудал. Ер нь одоо энэ архи, тамхи хүний биед хортой, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг зүйлүүд дээр бид онцгой албан татвар аваад явах ёстой.

Нөгөө талд нь сая Х.Булгантуяа. Биш ээ. Манай нөгөө О.Номинчимэг гишүүний хэлсэн Тамхины тухай хууль нэлээн удаан хугацаанд ярилцаж байгаад л дараа долоо хоногт орох гэж байна. Энэ хууль батлагдхаар зэрэг яах юм? Онцгой албан татварын хуульд дахиад өөрчлөлт оруулах юм уу? Онцгой албан татварынхаа хуулийг жоохон хойшлуулж байгаад тэр Тамхины тухай хууль

батлагдсаны дараагаар дахиж оруулж ирж болдоггүй юм уу гэдэг нэг ийм асуудал байна

Хоёрдугаарт, өнөөдөр анхны хэлэлцүүлэг явж байна.

Тэгээд 2026 оны 7 сарын 22-ны өдрөөс дагаж мөрдсүгэй гээд төсөл нь ороод ирсэн юм байна. Энэ ямар учиртай хугацаа юм? 7 сарын 22 гэдэг.

Энэ хууль 7 сарын 03-аас өмнө батлагдах юм бол 7 сарын 03-аасаа байж болдоггүй юм уу? Ямар учиртай хугацаа болохоор ингэж орж ирсэн юм бэ гэдэг ийм хоёр асуудал дээр хариулт авъя.

Хамгийн гол миний хэлэх гээд байгаа зүйл бол тэр Тамхины тухай хууль. Ялангуяа тэр электрон тамхи. Электрон тамхи чинь нийгэмд маш том лоббитой компаниуд байдаг юм байна. Сошиал орчинд явж байгаа, нийлж бүүлийдэж байгаа. Янз янзын лоббинууд хийж байгаа байдлыг харахад тамхины төрөлд оруулахгүй гэж л үхэн хатан зүтгэж байх шиг байна л даа. Энэ компаниуд.

Би өмнө нь аймгийн Засаг дарга байхдаа дунд сургуулийн хүүхдүүдэд электрон тамхийг зарж борлуулаад байна. Дуртай дэлгүүр, хоршоо, ТҮЦ нь зарж борлуулаад байдаг. Ийм байдлыг эсэргүүцээд хориглох шийдвэр гаргаж байсан.

Харамсалтай нь шүүхдээд. Эд нар буцаагаад л шүүхийн шийдвэр гаргуулаад л, миний тэр захирамжийг цуцлуулж л байсан юм л даа.

Тэгээд электрон бараа гэж оруулж ирээд л. Ялгаа байхгүй л хүний биеийг хордуулж байгаа ийм л зүйл.

Тэгээд энэ электрон тамхийг болохоор хууль юмнууд нь хойшлогдоод байдаг. Тэгэхдээ би С.Бямбацогт даргыг түргэн шуурхай ном горимоор нь явуулж байгаа гэдэгт хараад баяртай байгаа. Тамхины хууль явах ёстой. Энэ хаврын чуулгандаа багтаад шийдэгдэх ёстой.

Тамхины хууль батлагдлаа гэхэд араас нь Онцгой албан татварын хуулийг дахиад өөрчлөх юм уу, яах юм? Үүнийгээ хойшлуулж байгаад эхлээд тамхины хуулиа баталж аваад дараа нь үүнийгээ баталж болдоггүй юм уу гэдэг л ийм асуултыг асууя.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Евразийн орнууд буюу бид 5 оронтой худалдааны хэлэлцээр байгуулсан. Энэ хэлэлцээр маань 7 сарын 22-ноос хүчин төгөлдөр болж мөрдөж эхэлнэ.

Гааль, тариф, техникийн зохицуулалт, лаборатори, итгэмжлэл, олон зүйлүүд мөрдөнө гэсэн үг. Энд 5 орны парламентаар эцэслэн баталсан. Манай Улсын Их Хурал ч гэсэн эцэслэн баталсан.

Үүгээр нэг асуудал үүсэж байгаа нь бид Евроазийн орнуудаас импортлох тамхин дээр гаалийн татвараа тэг болгосон.

Иймд худалдааны тэгш байдлыг хангах үүднээс бүх орнуудаас импортолж байгаа тамхиныхаа гаалийн татварын 5 хувийн татварыг нь тэг болгоод онцгой татвараа нэмэгдүүлээд, төсвийнхөө, татварынхаа суурийг алдахгүйгээр харин ч бүр нэмэгдүүлэх маягаар шийдээд гарч байгаа ийм л зүйл. Учир нь 7 сарын 22-ноос мөрдөхөд бид энэ асуудлаа шийдсэн байхгүй бол татварын хөнгөлөлттэй тамхинууд орж ирэх гээд байгаа юм. Тэгэх юм бол бусад орнуудын орж ирж буй тамхитай зах зээлийн өрсөлдөөний тэгш бус байдал үүсгээд нэг ийм зарчим алдагдах гээд байгаа тул үүнийгээ яаралтай шийдье ээ гэж оруулж ирж байгаа нь энэ.

Энэ бол Засгийн газраас орж ирж байгаа Евроазийн гэрээтэй холбоотой зохицуулалтын хууль. Тамхины хяналтын хууль гишүүдээс өргөн барьсан. Энэ тусдаа зохицуулалтаар тэр вэйп болон бусад тамхины хортой хоргүй асуудал дараа нь чуулган дээр хэлэлцэгдэж байгаа.

Тэгэхээр тэр чиглэлийн асуудалд нь би хариулж чадахгүй байна. Мэдэхгүй байна. Энэ бол гишүүдийн өргөн барьсан хууль хэлэлцэж байгаа. Засгийн газар бол Онцгой албан татвараараа зохицуулалтаа хийгээд худалдааны тэгш өрсөлдөөнийг хангаад, Евразийн орнуудтай хийх худалдаагаа бүрэн төгс бэлэн болгоод ингээд 7 сарын 22-ноос мөрдөж эхэлье гэсэн ийм зохицуулалт.

С.Бямбацогт: Тодруулж асууя. Ц.Мөнхбат гишүүн. Үүний дараа санал хураалт явна шүү. Гишүүд.

Ц.Мөнхбат: Ер нь Евразийн улс орнуудаас манайд хэчнээн хэмжээний тамхи орж ирдэг юм бэ гэдэг мэдээллийг нэмж авъя.

Хоёрдугаарт, Тамхины тухай хууль батлагдвал энэ Онцгой албан татварын тухай хуульд дахиад л өөрчлөлт орж таарах нь байна. Тийм үү? Үүнтэй Та санал нэг байна уу?

С.Бямбацогт: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Бид гаалийн албан татвар дээр өөрчлөлт оруулахгүй гэсэн үүрэг хүлээж байгаа.

Нийт 367 бараан дээр харилцан үүрэг хүлээж байгаа. Онцгой албан татварыг нэмэх, хасах асуудал манай өөрийн дотоодын бүрэн эрхийн асуудал. Тэр хүрээн дээрээ тамхины хяналтын хууль дээрээ татварын хүрээгээ

нэмэгдүүлээд янжуур байна уу, дүнс байна уу, тэр вэйп байна уу, тэр зажилдаг нь байна уу, яадаг нь байна уу, хэрхэн онцгой албан татвар ногдуулах нь манай дотоодын асуудал байгаа юм.

Бид гадаад худалдаандаа барьж байгаа гаалийн татвар дээрээ ижил тэнцүү үүргээ хүлээгээд өөрчлөлт оруулж байгаа юм.

Татварынх нь мэдэгдээрээ. Ялангуяа Евроазийн орнуудын гол тамхи үйлдвэрлэгч нь Казахстан Улс байгаа юм. Америкийн гол гол үйлдвэрүүд Казакстанд байршиж үйлдвэрлэл явуулдаг. Тэндээс нэлээд том урсгал байгаа.

Татварын газар, гаалийнхан мэдээ өгөөрэй.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт өгч дууслаа. Санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Санал хураалт явуулна. Ажлын хэсэг яасан. Ажлын хэсэг нэмэлт хариулт өгье. Хэн хариулах юм? Ч.Чимидсүрэн дарга. Гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирээрэй. Санал хураалт явах гэж байна шүү.

Ч.Чимидсүрэн: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам, Татварын бодлогын газар Ч.Чимидсүрэн

Тэгэхээр Евразийн 5 орноос тамхины нийт импортын 37.9 хувийг нь энэ 5 орноос оруулж ирдэг.

Гишүүдийн санаачилсан хуультай энэ хууль тэрсэлдээд юм уу, өөрөөр хэлбэл зөрчилдөх зүйл байхгүй. Энэ хууль Улсын Их Хурлаар түр хэлэлцээр батлагдаад, түүнийг дагалдуулж гарсан Улсын Их Хурлын 117 дугаар тогтоолоор тарифын зөрүүг зохицуул гэж Засгийн газарт үүрэг өгсний дагуу оруулж ирж байгаа хуулийн төсөл байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдаад явахад дараагийн гишүүдээс санаачилсан хууль дээр электрон тамхи болон вэйп, түүнд биет хэмжээгээр ногдуулахтай холбоотой татварын асуудал нь яригдах учраас одоогийн бидний хөндсөн асуудалтай нэг ч зүйл зөрчилдөхгүй.

С.Бямбацогт: Ирц, бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. /алх цохив/

Гишүүд ээ, танхимд 60-аад гишүүн байгаа мөртлөө санал хураалтад бэлдсэн 40 хэдэн гишүүн болоод байна. Хуруугаа уншуулаад. Та бүхэн суудлаа эзэлье. Тэгэх үү?

Х.Булгантуяа гишүүн суугаадахъя. Б.Уянга гишүүн суугаадахъя. Н.Наранбаатар дарга жаахан хурдан алхана. Т.Аубакир сайд сууя. Санал хураалт. Санал хураалт явуулъя. /алх цохив/ Ирц бүртгэлийн санал хураалт.

О.Батнайрамдал гишүүн, С.Лүндэг гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Б.Найдалаа гишүүн оруулаад татгалзсан гарч байгаа бусад гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Б.Пунсалмаа гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн нарыг хасаад татгалзан гарч байгаа гишүүд чуулгандаа оролцож байна шүү. Санал хураалт явуулъя.

Одоо Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооноос Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

105 гишүүнээс 71. Даваагийн Цогтбаатар гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, Х.Булгантуяа гишүүн, Б.Хэрлэн гишүүд дэмжсэнээр 75 гишүүн. Ж.Батсуурь гишүүн. 76 гишүүн дэмжлээ. С.Эрдэнэбат гишүүн. 77 гишүүн дэмжлээ. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

**Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг
томилох, чөлөөлөх тухай асуудал
санал хураалтаар үргэлжлэв**

Одоо Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох эсэх асуудлаар нууц санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлдэж дууссан уу? Тамгын газар хоёр талаар нь хараарай. Санал хураалтыг явуулъя.

Нэргүй Мягмарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. /алх цохив/

105 гишүүнээс 74 гишүүн буюу 70.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.
/алх цохив/

Цэцэгмаагийн Уртнасанг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя.

105 гишүүнээс 69 гишүүн буюу 65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.
/алх цохив/

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр. Улаанбаатар хот.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Нэргүй Мягмар, Цэцэгмаагийн Уртнасан нарыг томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Барсүрэнгийн Баасандоржийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилсон Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ баярлалаа.

Монгол төрийг байгуулах сонгуулийн үйл ажиллагааг Та бүхэн шударга, хараат бус, ямар нэг хууль зөрчсөн зүйлгүй явуулах ёстой шүү. Энэ тал дээр илүү анхаарч, хариуцлагатай ажиллахыг Та бүхнээсээ хүсье. /алга ташив/

Дашдондогийн Ганбат гишүүн дэмжиж байна. Нууц учраас Та хэдийн санал гарахгүй ээ. Тийм. Санаа зоволтгүй ээ.

**Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
санал хураалтаар үргэлжлэв**

Газрын тосны тухай хууль. Байнгын хороо анхны хэлэлцүүлэг хийсэн. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй нэг саналын томьёолол байгаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 3 дугаар зүйлийн “5” гэснийг “7.5” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, Л.Соронзонболд, Р.Сэддорж.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

105 гишүүнээс 78 буюу 74.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

**Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
санал хураалтаар үргэлжлэв**

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр сая Ардчилсан намын бүлэг завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна.

Б.Жаргалан гишүүний микрофон өгье. Бүлгийн дэд дарга.

Б.Жаргалан: Нийгмийн даатгалын багц хуулийг ажил олгогч ажилтан, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болон тэтгэвэр авагсдын эрх ашгийг хангаж ийм сайн хууль батлах ёстой гэдэг үндсэн дээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг сая завсарлага авсан.

Сая 2 цагийн туршид ажлын хэсэг дээр нэлээн тийм ажил хэрэгч саналууд ярилцлаа.

Тэгээд завсарлагын хугацаагаа дуусгаж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Ойлголцоод асуудлаа шийдээд улс орныхоо эрх ашгийг нэгдүгээрт нь. Дээрээс нь хууль санаачилсан гишүүд харилцан тохиролцоод, ойлголцоод явж байгаад талархлаа.

Манай Б.Түвшин гишүүндээ, ажлын хэсэг, Х.Булгантуяа ахлагчдаа, Засгийн газар, Т.Аубакир сайддаа баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүдээс Байнгын санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Асуултын дараа санал хураалт. 30-аад санал хураалт байгаа.

Өлзийхүүгийн Шижир гишүүн алга байна. /алх цохив/
Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. /алх цохив/
Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. /алх цохив/
Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. /алх цохив/

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Өчигдөр Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад дэмжигдээгүй нэг заалт байгаа юм.

Энэ нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль байгаа.

Тэтгэврийн тухай хуулийн 1 дэх зүйлийн 4 дэх хэсгийн 9.1.3 дахь заалт.

Энэ дээр тэтгэвэрт байгаа гэр бүлийн хоёрын аль нэг нь нас барвал үлдсэнийх нь тэтгэврийг нь нэмэх ийм хуулийн заалт байгаа.

Гэхдээ үүнийг тавьдаг шаардлага нь хоёр зүйл байсан. Гэр бүл бүртгүүлсэн, тодорхой хугацаанд хамт байсан шалгуурыг давсан хүмүүст нэмэгдлийг олгох бололцоотой байсныг хуулийн төслийн шинэ өөрчлөлтөөр дахиад дээр нь нэг зүйл нэмж орж ирсэн байгаа юм. Аль аль нь баталгаат тэтгэвэр авдаг байх гэсэн шаардлага тавьсан байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөөр хэлбэл, би зүгээр энэ дээр нэг жишээ аваад үзвэл шударга бус иймэрхүү байдал руу орчхоод байна л даа. Эхнэр нь олон жил өндөр цалинтай, өндөр тэтгэвэр тогтоолгосон байна. Гэтэл нөхөр нь бага тэтгэвэртэй буюу баталгаат тэтгэвэр авдаг.

Тэгэхээр энэ тохиолдолд нөхөр нь нас барвал сайн тэтгэвэртэй байсан эхнэр нь орлогоо нэмэх бололцоотой. Харин эсрэгээрээ эхнэр нь нас барвал бага тэтгэвэртэй нөхөр нь тэр тэтгэврээ нэмэх бололцоогүй.

Өөрөөр хэлбэл шударга бус зохицуулалт орж ирэх гээд байна.

Тэгэхээр үүнийг өөрчилье гэж санал гаргасан боловч адилхан “хоёулаа баталгаат тэтгэвэр авах ёстой” гэсэн заалтыг хасах санал гарсан боловч дэмжигдээгүй.

Тэгэхээр ажлын хэсгээс өчигдөр энэ тайлбарыг ер нь энэ зөв юм байна гэдэг саналыг ажлын хэсгийн гишүүд гаргаж байсан.

Тэгэхээр энэ дээр ажлын хэсгээс нэмэлт тайлбар хийж өгөөч ээ гэж хүсэж байна. Энэ зохицуулалтыг илүү зөв болгох талаас нь.

Өөрөөр хэлбэл бидний анхаарах ёстой, хамгаалах ёстой хүмүүсээ хамгаалж чадахгүй ийм заалт болж байна. Нөгөө талаасаа нийгмийн даатгалын сан дээр ачаалал ирэхгүй ийм заалт байгаа.

Дахиад хоёр дахь асуудал нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль дээр ажлаас гарч байгаа шалтгаанаас хамаараад хоёр өөр янзаар ажилгүйдлийн тэтгэмж тогтоогдож байгаа.

Өөрөөр хэлбэл ажил олгогчийн санаачилгаар буюу цомхотгол, янз бүрийн байдлаар ажил олгогчийн санаачилгаар чөлөөлөгдвөл ажилгүйдлийн тэтгэмж нь болохоор 76 хоног, өөрийн санаачилгаар гарвал 55 хоног. Яг адилхан шимтгэл төлсөн хоёр хүн гарах шалтгаанаасаа болоод хоёр өөрөөр тогтоогоод байгаа.

Энэ нь өөрөө ажил мэргэжлээ өөрөө сонгох Үндсэн хуулийн эрх байна. Энэ байдлыг зөрчихөөр. Дээр нь энэ дээр ажлаас өөрийн санаачилгаар гарсан ч гэсэн зохиомлоор ажил олгогчидтойгоо тохирч ажил олгогч чөлөөлсөн юм шиг хиймэл зохицуулалтууд энэ хуулийн өөрчлөлтөөс болж үүсэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ хоёр зүйл, заалт дээр ажлын хэсгээс тайлбар хийж өгөөч ээ. Хоёр дахь саналын хувьд ажил олгогч болон ажилтан хоёрын хоёуланг нь гарсан шалтгааныг нь хэний санаачилгаар гэдгээс үл хамаарч адилхан байлгая гэдэг санал байгаа юм.

Энэ дээр яагаад зөрүүтэй байх ёстой гэдэг талаар тайлбар хийж өгье. Яг энэ хоёр дахь шалтгаан дээр энэ өөрөө ажилгүйдлийн сан маань алдагдалтай

байгаа учраас үүнийг нь тэгшитгэхийн тулд л нэг ийм санал орж ирсэн харагдаж байна лээ л дээ.

Тэгэхээр насыг нь өөр ялгаатай тогтоож байгаа нь шударга зарчимд нийцэхгүй байна. Энэ талаар тайлбар хийж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Б.Батжаргал дарга. 4 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий газар. Б.Батжаргал.

Эхний асуулт нь суурь тэтгэврийг настай гэр бүлийн хоёр хүн авч байгаад нэг нь унаад өгвөл өөрийнхөө авч байгаа суурь тэтгэврийнхээ 50 хувиар нэмэгдүүлэх зарчмаар оруулж өгсөн. Одоо мөрдөгдөж байгаа хуулийн дагуу ямар процесс явж байна вэ гэхээр хоёулаа өндөр нас авдаг байж л одоогийн нас барагчийнхаа тодорхой 20 хувийг авна гэсэн ойлголт яваад байгаа юм.

Тэгэхээр одоо амьдрал дээр –

- зарим нь групп авдаг,
- зарим нь цэргийн тэтгэвэртэй,
- зарим нь тэжээгчээ алдсан авдаг байхаар –

-авч чадахгүй болчихоод байгаа юм.

Одоо манай хуулийн төслийн томъёоллоор суурь тэтгэврийг –

- өндөр насны тэтгэвэр авагч,
- групп авагч,
- тэжээгчээ алдсан авагч,
- цэргийн тэтгэвэр авагч

-бүгдээрээ авахаар оруулаад тэгээд хүрээг нь өргөтгөсөн учраас одоо мөрдөж байгаа зохицуулалтаас илүү хамаагүй түгээмэл хүнд ээлтэй болсон гэсэн агуулга бас явж байгаа.

Тэгээд хоёр хөгшний нэг нь унаад өгвөл ар гэрт үлдсэн хүн нь суурь тэтгэврийнхээ авч байгаа дүнгийн 50 хувийг өөрөө авах ийм зохицуулалт байгаа.

Хоёр дахь асуултын хувьд ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой асуулт нь одоо 76 хоногоор өгдөг. Энэ өөрөө даатгалын зарчим учраас эрсдэлээ өөрөө үүсгэсэн бол түүн дээр бас жаахан тийм торгуулийн арга хэмжээ байя гэсэн зарчим яригдсан. Одоо жишээлбэл автомашины даатгал дээр ч юм уу, ямар нэгэн

даатгал дээр согтууруулах ундаа хэрэглэсэн, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ ажлын байран дээр осол гаргасан бол тэнд даатгал эсвэл үйлчилдэггүй, эсвэл бага үйлчилдэг олон улсын зарчим байгаа.

Энэ зарчим руу нь дөхүүлээд хэрвээ Та өөрийн санаачилгаараа гараад явсан бол Та хэдийгээр адилхан шимтгэл төлсөн ч гэсэн эрсдэлээ өөрөө үүсгэсэн учраас танд 55 хоногоор өгнө гэсэн заалт оруулсан.

2015 оноос өмнө энэ бүр 40 хоног байсан. Одоо бид ярьж байгаад үүнийг 55 болгоё. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний конвенц дээр 96 хоногоос доошгүй байх ёстой гэсэн заалт байдаг. Бид одоо 76 хоног дээр явж байна. Эрсдэлээ өөрөө үүсгэсэн бол 55 хоногоор олгоно гэсэн заалтыг оруулсан. Баярлалаа.

С.Бямбацогт: Тодруулж асууя. Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: 9.1.3 чинь яг тэгж уншигдахгүй л байгаа юм даа.

Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх гэдэг шаардлага чинь. Саяын хэлсэн тайлбар дээр өргөтгөсөн гээд байгаа. Гэхдээ энэ өөр тэтгэвэр, тэтгэмжүүд, энэ өөр харилцаанууд байгаа.

Тэгэхээр энэ дээр нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх гэсэн шаардлагыг хангаж байж аль нэг нь нас барвал тэтгэврийн нэмэгдлээ авах бололцоо чинь нээгдэж байна.

Тэгэхээр саяын хэлсэн агуулга уншигдахгүй л байна даа. Энэ дээр дахиж нэмж тодруулга хийж өгөөч.

Түрүүчийн тэр хоёр дахь асуулт дээр ажлын байраа сайжруулах гээд хүн гарч байгаа. Үүнийг торгоно гэдэг чинь ямар утгатай юм. Үндсэн хуулиар ажил хөдөлмөрөө өөрөө сонгох эрхтэй байгаа. Ажил, мэргэжлээ сонгох эрх байгаа. Тэгэхээр үүнийгээ сонгосныхоо төлөө, ажлын байраа сайжруулсныхаа төлөө ажлаас гарах шийдвэр гаргаад ажлаас чөлөөлөгдсөн нь... /минут дуусав/

С.Бямбацогт: Хариулъя. Б.Батжаргал дарга. 4 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий газар. Б.Батжаргал.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2.1.8 дээр тодорхойлж өгсөн байгаа. Суурь тэтгэвэр гэж энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр. Үүнийг бид групп гэж нэрлэдэг. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авагч

ахмад настанд авч байгаа тэтгэврийн хэмжээнээсээ хамааруулан тооцож улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг гээд тодорхойлсон.

Тэгэхээр энэ дээр өндөр нас авагч байж болно, групп авагч байж болно, тэжээгчээ алдсан байж болно. 9 жил ажилласан хүн энд орж ирэхгүй. Энэ 10-аас доошгүй жил буюу. Тэр халамжийн хуулийн зохицуулалтаараа тусдаа явж байгаа. Тэр тусдаа хуулиар зохицуулагдана. Халамжийн хуулийн төслөөр.

Энэ зөвхөн нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлт учраас шимтгэл төлсөн харилцаатай хүмүүсийн харилцааг зохицуулж байгаа юм. Тийм.

С.Бямбацогт: Даваахүүгийн Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Даваасамбуугийн.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ер нь зарчмын хувьд дэмжиж байгаа.

- Хуулийн өмнөх тэгш байдлыг хангах оролдлого хийж байна.
- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хийж байна.
- Албан бус хөдөлмөрийг бууруулах боломжийг нэмэгдүүлж байгаа гэж бодож байгаа.

Тэгэхдээ хэд хэдэн асуудлууд байна. Хаанаас нь эхлэх вэ.

Даатгалын үндсэн зарчим чинь ер нь нийгмийн даатгал. Шимтгэл төлж байгаа бол эрх нь сайжирна гэдэг зарчимтай байх ёстой. Тийм үү.

▷ **Нэгдүгээрт**, Үргэлжлүүлэн ажиллаж байгаад, тэгэхдээ шимтгэл төлөхөө болихоор даатгалын системийн үндсэн философи юм уу, концепцтойгоо нийцтэй байгаа юу? Төсөл дээр лав тайлбарыг нь олж харсангүй.

▷ **Хоёрдугаарт**, нэгтгэсэн хуулийн төслийн 4.1.20 дээр тэтгэврийн мөнгөн хуримтлал гэж даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувьтай тэнцэх хөрөнгө улсын төсвөөс олгосон урамшуулал гэж байгаа юм. Тэгээд хөрөнгө оруулалтын өгөөжөөс бүрдсэн мөнгөн хөрөнгийг.

Энэ ямар хөрөнгө оруулалтын тухай ярьж байгаа юм. Өгөөж нь. Тэгээд улсын төсвөөс олгосон урамшуулал гэж яг юу вэ? Тус тусад нь задлаад тайлбарлаад өгөхгүй юу? Яг юу юуг оруулж байгаа юм гэдэг санаа.

Ер нь энэ хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа үндсэн ажилтнууд нь “хөлсөөр ажиллах гэрээ” гэж байгаа, “ажил гүйцэтгэх гэрээ” байгаа. Ажиллаж хүмүүс байгаа. Эд нараас бүгдээс нь нийгмийн даатгалын шимтгэлийг аваад нэмээд ажил олгож байгаа хүмүүс дээр шимтгэл төлдөг нь л гол хүндрэлийг уг нь үүсгээд байгаа шүү дээ.

Би өөрөө ч гэсэн судалгааны байгууллагад Монголд ажиллаж байхдаа 200, 300-аад хүмүүсийн нийгмийн даатгалын шимтгэл дээр аягүй их дарамт ирдэг юм бтлээ. Санхүүжилт гээд. Гэтэл яг энэ гол асуудлыг шийдэхийн тулд шимтгэлийг бууруулах ч юм уу, шимтгэлийг засаж янзлах дээр тийм жоохон өнгөц төдий өөрчлөлтүүд орсон биш үү гэсэн сэтгэгдэл надад хүрч байна.

Тэгэхээр шимтгэлийн хувь хэмжээг бууруулах, хөдөлмөрийн бусад гэрээнээс нийгмийн даатгалын шимтгэл авдаггүй байх зохицуулалтыг хуульд уг нь тусгах шаардлагатай байх. Үүнийг хэзээ, хаана, яаж тусгах гэж төлөвлөж байгаа вэ?

Одоо ингэж байна шүү дээ. Төсөлд тэтгэврийн сан жилд 95.8 тэрбум төгрөгийн орлого алдана гэж дурдсан байгаа. Тэгэхдээ тооцоо нь 2030 онд ч юм уу, 2040 онд гээд актуар тооцоолол байх ёстой шүү дээ. Нийгмийн даатгалтай холбоотой. Ийм актуар тооцоолол энд харагдахгүй л байна л даа. Яг манай эрүүл мэндийн даатгалтай адилхан.

Сангийн сайд юм уу, Сангийн яамнаас жилд 95.8 төгрөгийн орлогын алдагдлаа улсын төсөв хэдэн жил ер нь нөхөх боломжтой вэ гэдэг дээр тооцоолол байна уу?

Дээрээс нь уул уурхайн орлого буурсан үед энэхүү тогтолцоо нь тогтвортой байж чадах уу?

Мөн ахмадын хөдөлмөр эрхлэлт 5 хувиар өснө гэсэн нэг тийм тооцоолол явж байна лээ. Энэ судалгааных нь үндэслэл байгаа юу? Ямар судалгаа дээр үндэслэж 5 хувиар өснө гэсэн тооцоо гаргасан байна.

Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Х.Булгантуяа ажлын хэсгийн ахлагч хариулъя. Х.Булгантуяа гишүүний микрофон.

Х.Булгантуяа: Д.Ганмаа гишүүн маш чухал асуудлууд хөндөж байна.

Одоо манай нийгмийн даатгалын сангийн тогтолцоо ерөнхийдөө малгайтай цамцны хармаа шиг. Бид энэ талынхаа гараар аваад л шууд ийшийгээ ахмадууддаа тэтгэвэр болгож өгдөг. Үүн дээр хуримтлал болгож үүсгэж чадахгүй байгаа.

2023 оны хуулиар уг нь бид тэтгэврийн шимтгэлийнх нь 2 хувийг мөнгөжүүлээд энэ мөнгийг бид ахмадуудын тэтгэвэрт тавихгүйгээр өнөөдөр төлж байгаа хүмүүсийн мөнгийг мөнгөжүүлж явъя гэсэн. Үүнийгээ харамсалтай нь бид олигтой хийж чадаагүй.

Тэгэхээр одоо шинэ хуулиар юу гэж орж ирж байна гэхээр шимтгэл төлсөн хүний өөрийнх нь шимтгэлийнх нь төлсөн 1 хувь.

Тэгээд үүн дээрээс нь нэмээд ахиад одоо нэг бодлын шимтгэл төлөгч таныг шимтгэлээ төлөөч ээ гэж улс дэмжиж уриалж ахиад улсын төсвөөс 0.5 хувийг нэмээд 1.5 хувийг мөнгөжүүлнэ. Үүнийг ингээд хуримтлал үүсгэнэ.

Өөрөөр хэлбэл гар хүрэхгүй, өнөөдрийн ахмадуудын тэтгэвэрт тавихгүйгээр хуримтлуулна гэж үзэж байгаа юм. Ингээд аваад үзэхэд 2027 онд гэхэд нийтдээ 210 орчим тэрбум төгрөг хуримтлагдахаар байна. Мөнгөжүүлээд 1.5 хувийг.

Энэ бол нэлээн хурдан ахиад явахаар үүнийг хөрөнгийн менежментийн компаниар удирдуулах, цааш нь хөрөнгө оруулалт, үнэт цаасанд хийх гэдэг юм уу ийм арга хэмжээг авах шаардлага үүснэ.

Шинээр шимтгэл төлөгч хүү, залуучуудын хувьд энэ жишээлбэл ажил хөдөлмөр эрхэлж байх бүх хугацаандаа хуримтлал үүсгэхэд зөвхөн 1.5 хувь нь гэхэд 200 гаруй сая төгрөг болохоор байгаа. Үүнийг 100 хувь үр хүүхдүүдэд нь өвлүүлнэ.

Одоо би үргэлжлүүлээд 15 жил ажиллана гэхэд 15 жил миний ажилласан мөнгийг 1.5 хувийг мөнгөжүүлээд үүний дараа авч чадахгүй нас барах юм бол гэр бүлийнх нь хүмүүст нь 100 хувь өвлүүлэхээр байгаа.

Хөдөлмөрийн гэрээ хөлсөөр гүйцэтгэх гэрээ хоёр дээр нэлээдгүй маргаан өрнөж Ардчилсан намын бүлгээс ч гэсэн үүнтэй холбоотой завсарлага авсан.

Одоо энэ шинэ хуулийн зохицуулалтаар ийм байгаа юм. Д.Ганмаа гишүүн.

Нэгдүгээрт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад. Их сургуулийн багш нар голцуу тийм байдаг. Хөдөлмөрийн гэрээгээр их дээд сургуульдаа багшлаад хажуугаар нь хөлсөөр гүйцэтгэх иргэний гэрээгээр судалгааны ажил хийх, багшлах ч байдаг юм уу, нэмэлт ажил хийх юм бол тэр бүгдээс нь нийгмийн даатгалын шимтгэл авахгүй. Ямар нэгэн газраас ямар ч байсан төлөх ёстой гэдэг зохицуулалтыг хийж өгсөн юм.

Гэхдээ одоо ч гэсэн одоогийн хуулиар яаж байгаа вэ гэхээр нийт дүнгээс нь авдаггүй. Жишээлбэл, барилгын бригад 200 саяар барилгын ажил гүйцэтгэлээ гэхэд тэр дотор нь барилгын материал, тээвэр байлаа гэхэд 20 саяын цалингийн зардал юм шүү, цалин хөлсний зардал гэвэл тэндээс нь авдаг.

Шинэ хуулиар юу гэж хийж өгч байгаа гэхээр 10 гэрээтэй байж болно, 20 гэрээтэй байж болно. Хөдөлмөрийн гэрээгүй бол нэгийг нь сонгоно. Өөртөө хамгийн таатайг нь.

- Ахмадууд өндрийг нь сонгох байх.
- Залуучууд багыг нь сонгох байх.

Үүнээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 нугалсан хүртэл л төлнө.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

В.Рэнцэнханд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд. Гишүүний асуултад хариулъя.

Даатгалын үндсэн зарчим алдагдахгүй байгаа.

Тэгэхээр ажил олгогчийн зарим шимтгэлүүд чөлөөлөгдөх зохицуулалт орсон. Гэхдээ зөвхөн ажил олгогчийн төлөх хэмжээ нь чөлөөлөгдөөд харин даатгуулагч төлдгөөрөө төлөх юм.

Тэгээд тэр бүртгэл бүгдээрээ явах болохоор тэрийг төлснөөр тооцохоор хуулийн төсөлд тусгасан.

Тэгэхээр зэрэг даатгуулагчийн эрх ашиг алдагдахгүй. Даатгалын үндсэн зарчим алдагдахгүй байгаа.

Нийгмийн даатгалын сангийн хуулиар нийтдээ төсвийн нөлөө 1 их наяд 400 тэрбум төгрөгийн нөлөөтэй байгаа.

С.Бямбацогт: Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя. Дуусаагүй юу? Х.Булгантуяа гишүүн. Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Булгантуяа: Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн хувьд ийм.

2023 онд тухайн үед би сайдаар ажиллаад. Одоо манай ажлын хэсэг хамтдаа бид нийгмийн даатгалын багц хуулийг батлуулж байсан.

Тэр хууль дээр манай ахмад настнууд тэтгэврээ тогтоолгоод ахмадын насанд хүрсэн бол ажил хөдөлмөр эрхлэхэд тэтгэврийн шимтгэлийг төлөхгүй байх. Өөрөөр хэлбэл бараг нийгмийн даатгалын шимтгэлийн хамгийн том хэсэг нь тэтгэврийн шимтгэл учраас үүнээс чөлөөлөгдөх ийм эрх зүйн орчныг нь бид бий болгож өгсөн.

Ингэснээр манай ахмадуудыг ажил эрхлэх нэгдүгээрт хүсэл сонирхолтой байсан. Манай ахмадуудын хэлдэг нэг асуудал бол бид 55, 60 гэдэг залуу хүмүүс байна. Үргэлжлүүлээд ажил хийх гэхээр би аль хэдийн тэтгэврээ тогтоолгосон мөртлөө би яагаад үргэлжлүүлээд тэтгэврийн шимтгэл төлөх ёстой юм бэ гээд байдаг.

Тэгэхээр энэ хүрээнд бид өмнө нь энэ хуулийн зохицуулалтыг хийсэн байсан. Манай А.Ариунзаяа нарын гишүүдээс өргөн барьсан нь үүнийг нэлээдгүй насны хэтэрхий хатуу хязгаар тавьсан байгааг нь жоохон бууруулах шаардлага байна гэдэг үндэслэлээр тэтгэврийн... /минут дуусав/

С.Бямбацогт: Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Тийм. Энэ яг ямар судалгаан дээр тулгуурлаж 5 хувиар өснө гэсэн юм бэ? Үндэслэлийг нь л асуусан юм. Тийм ээ. Энэ дээр судалгаа байгаа бол тийм судалгаа гээд хэлээд.

Тэр тэтгэврийн санг 95.8 тэрбум төгрөг алдагдана гээд байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр 2030 онд гэхэд жишээлбэл ямар нөлөө үзүүлэх юм. Дараалах тооцоо нь юу юм. Актуар тооцоолол алга байна гэдэг дээрээ нэг тодруулга авъя.

Тэгээд улсаасаас буюу төсвөөс 1 хувийг бүрдүүлж байгаа гээд сая ажлын ахлагч маань хариуллаа шүү дээ. Энэ нь яг юу юунаас бүрдэх юм бэ гэдгийг асуугаад байхгүй юу. Улсаас тэр хөрөнгө гэдэг нь яг аль юм гээд задлаад тайлбарлаад өгөөч. Яг юу юу орж байж гарах юм бэ энэ дээр. Тийм ээ?

Тэгээд цаг байвал уг нь тэр нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүрэн төлж дуусахгүй бол дансыг нь хаана гээд заалт ороод ирсэн байна лээ шүү дээ. 38.10.4 дээр. Энэ чинь нөгөө “чөлөөлье” гэдэг агуулгатайгаа зөрүүд байгаа юм биш үү. Манай Засгийн. Арай хатуу биш үү? Үүнийг ямар... /минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Х.Булгантуяа ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Булгантуяа: Одоогийн байдлаар 27 мянган ахмад настан ажил хөдөлмөр эрхэлж байна.

Тэгэхдээ тэтгэврийн ердийн насанд хүрээгүй байгаа учраас нийгмийн даатгалын шимтгэл төлөх нөхцөл байдал үүсэж байгаа.

Дээрээс нь нэмээд цэргийнхэн маань нэлээдгүй эрт тэтгэвэрт гардаг.

Тэгэхээр энэ бүгдийг сая А.Ариунзаяа нарын гишүүдээс өргөн барьсан хууль дээр ердийн нас биш 55, 60 хүрсэн бол нийгмийн даатгалын шимтгэл авахгүй байснаар хамгийн багадаа 5 хувь орчмоор өснө гэж үзэж байгаа. Яагаад гэвэл шимтгэлийн хувь хэмжээг нь тооцож авч үзээд.

Даатгалын үндсэн зарчим алдагдахгүй. Харин төсөв дээр ирэх ачаалал энэ хуулиар нэлээдгүй нэмэгдэнэ. 0.5 хувийг төсвөөс нэмж даана.

- 1 хувийг нь шимтгэл төлөгчөөс.
- 0.5 хувийг нь хуримтлалын сангаас.

Дээрээс нь нэмээд баталгаат тэтгэврийг тэтгэвэр авагч болгонд өгнө. Энэ бол 100-аас 300 орчим мянган төгрөг байхаар байна. Үүнийг улсын төсвөөс давхар даана.

С.Бямбацогт: Зарим үлдсэн асуултад бичгээр хариулт өгчих. Тэгэх үү? Дэгийн хуулиараа. Тэгэхгүй явахгүй байна.

Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн сан багагүй хэмжээгээр тоногдсон байдаг. Өмнө нь.

Тэгэхээр компаниудын махыг нь идээд л хөөрхий амьтдыг. Тийм ээ. Цалинг нь ажилтнуудад нь олгуулахаас гадна нийгмийн даатгалын шимтгэл төлүүлдэг. Давхар ачаалал өгч давхар шийтгэдэг.

Тэгээд асар их хэмжээний мөнгө тэр сандаа хуримтлуулчихаад, цуглуулчихаад тэр нь алга болдог. Капитал билүү, Капитрон ч билүү. Банкных нь нэрийг нь санахгүй байна. Ингээд банкттайгаа цуг дампуураад алга болдог.

Тэгэхээр энэ мөнгө миний санаж байгаагаар 240 орчим тэрбум төгрөг байх. Энэ мөнгө ер нь юу болсон бол оо? Буцааж үүнийхээ тал хагасыг нь ч болтугай олж авч чадсан болов уу?

Энэ мэтээр бид нийгмийн даатгалын сангаа хэн нэгэн улс төрчид бөгөөд бүлэглэлд тонуулаад дайх юм бол ингэж амьтны мах идэж тэтгэвэр, нийгмийн даатгалын шимтгэл авч байх хэрэг байгаа юм уу гэдэг асуулт байна. Энэ талаар танд мэдэж байгаа зүйл байгаа болов уу?

Хоёрдугаарт, ер нь манай систем хуваарилалтын тогтолцоо. Тийм ээ. Одоо хуримтлалын тогтолцоо руу орох гэж үзэж байх шиг байна. Гэхдээ энэ төсөлд даатгуулагчийн шимтгэлийн 1 хувийг нь л хуримтлалын дансанд тусгуулахаар зохицуулсан байна. Гэтэл олон улсад ер нь ямар байдаг юм бол оо?

Миний харснаар хуримтлалын дансанд –

- | | |
|-------------|---------------------------------|
| ➤ Австралид | 12 хувийг, |
| ➤ Чили | 10 хувийг, |
| ➤ Казакстан | 10 хувийг, |
| ➤ Сингапур | 20 хувийг гээд хийдэг юм байна. |

Тэгэхээр энэ ганцхан хувь гэдэг чинь тийм бодтой хуримтлал үүсгэж чадах уу? Энэ дээр ямар бодолтой байгаа вэ?

Тэгээд 40 жил тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн тэтгэвэрт гарах үед нь яг энэ 1 хувийн хуримтлал нь тухайн тэтгэврийнх нь хэдэн хувийг эзлэх юм бол оо? Энэ дээр гаргасан тооцоо байгаа юу?

Өөрөөр хэлбэл 1-хэн хувь гэдэг чинь ямар ч хуримтлалын дорвитой сан бүрдэж тэтгэвэр авагчдад нэмэр хандив үзүүлэхгүй байх гэж бодож байна.

Гурав дахь асуулт. Үзэл баримтлалдаа бичсэн байна. Тийм ээ. 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчдын тоо маш ихээр өсөж байгаа гээд байна. Дэлхий даяараа л өсөж байгаа.

Дэлхийн банк, OECD, Олон Улсын Валютын Сангаас насжилтын дарамтад орж байгаа улсуудад асуудлаа яаж шийдэхийг зөвлөдөг вэ гэвэл тэтгэврийн насыг нь нэмэх. Тэгээд хуримтлалын тогтолцоо руу шилжих. Хуримтлалын бүрэлдэхүүнийг олон төрлийн болгох гэж ингэдэг.

Тэгээд энд чиглэл рүү өөрчлөгдсөн улсууд байгаа. Тийм ээ. Жишээлбэл, Скандинавын орнууд.

Гэтэл манайд. Одоо Та бүгдийн оруулж ирж байгаа төсөлд насжилттай холбоотой асуудал ер тусгагдаагүй байна. Монголд ч гэсэн насжилт эрчимжиж байгаа гэж үзэж байгаа. Үүнийгээ мэдэж байгаа мөртлөө тэтгэврийн насжилттай холбоотой асуудал хуулийн төсөлд огт тусгагдаагүй байна.

Тэгэхээр өөрөөр хэлбэл... /минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа дуусгая. 1 минут. Ж.Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэгэхээр насжилтын энэ асуудлыг тусгаагүй байна гэдэг чинь реформын шинжтэй дорвитой өөрчлөлт болж чадах уу? Эсвэл дахиад л нэг тийм косметик шинжтэй ийм өөрчлөлт болох юм уу гэж бодож байна. Дахиад сүүлийн асуулт.

Ер нь ямар ч хуулийн эцсийн үр дүн тоо гарч байх ёстой. Тийм үү. Тэгэнгүүт одоо жишээлбэл –

- 2025 онд тэтгэврийн сангийн алдагдал 5.3 их наяд юм байна.
- 2030 онд улсын төсвийн дэмжлэг 3.8 их наяд гэсэн.
- 2035 онд 5.7 их наяд гэсэн байна.

Гэтэл энэ төсөл батлагдсанаар эсрэгээрээ төсвөөс олгодог санхүүгийн дэмжлэг буурах уу?

- 2030 онд хэдэн хувиар яаж буурах вэ?
- 2035 онд яаж буурах вэ?

→ Тодорхой судалсан тоо дүн байна уу? Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Х.Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Капитал, Чингис хаан банканд 2016 онд байршуулж алдсан мөнгөнөөс 80.1 тэрбум төгрөгийг төлүүлсэн.

Одоо 2026 оны 6 сарын 12-ны үлдэгдэл Капитал банкнаас 51.0 тэрбум төгрөг. 2026 оны 6 сарын 12-ны үлдэгдэл 76.7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа.

Үүнийг хаахын тулд 2023 оны нийгмийн даатгалын багц хууль дээр. Манай нийгмийн даатгалын санг зарим хүмүүс ингэж яриад байдаг юм. Өндөр өгөөжтэй газар хийж санхүүгийн хэрэгсэлд байршуулж арвижуулах ёстой гэж. Номер нэг асуудал үүнийг найдвартай байлгах ёстой. Найдвартай байлгах ёстой.

Монгол Улсад яг үнэнийг хэлэхэд найдвартай хэрэгслүүд тийм олон биш. Зарим улс орнуудад үүнийг ипотект байршуулах нь түгээмэл байдаг. Урт хугацааных учраас хүмүүсийг хэзээ тэтгэвэрт гарах вэ, иргэн Булгантуяа хэзээ тэтгэвэрт гарах вэ гэдгийг тооцоолж чаддаг учраас.

Ингээд Засгийн газрын зарим бондууд гэх мэтчилэн байршуулдаг. Манай улсын хувьд жоохон хэцүү. Хэтэрхий ихээр банканд байршуулахаар энэ бол бас нөгөө талдаа банкны баланс талдаа эрсдэлийг үүсгэдэг.

2023 оны хууль дээр бид Монголбанкаас, ер нь томоохон эрсдэл даах банкуудад л зөвхөн байршуулахаар хуульчилж өгсөн байгаа. Өмнө нь эрсдэл ихтэй, өндөр өгөөжтэй банканд байршуулсан нь энэ санг эрсдэлд оруулсан.

Улс төржсөн шийдвэр энэ сан дээр ерөөсөө гаргаж болохгүй. Үнэнийг хэлэхэд нийтдээ. Би Та бүхэнд сүүлийн 10 гаруйхан жилийн юуг харахад 2008 онд шимтгэл хувь хэмжээг бууруулсан. Дараа нь 2012 онд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль гээд.

Зөвхөн энэ хуулийн нөлөөнд гэхэд нийтдээ 6 их наяд орчим төгрөгийн зардал гарсан байна. Түүнээс хойш нийтдээ 8.3 их наяд төгрөгийг тэр хэсгээ ч дэмжинэ, энэ хэсгээ ч хайрлана халамжилна гээд.

Нийгмийн даатгалын сан халамжийн сан биш. Өнөөдөр ажил хийж байхдаа иргэн хүн өөрөө тэжээгчээ алдах юм бол үр хүүхдүүдэд нь зориулж. Би өөрөө тэтгэвэрт гарах юм бол би өөрийнхөө орлогыг хамгаалж. Би ажилгүй болох юм бол ажилгүйдлийн тэтгэмж авах гэж төлдөг болохоос биш хэн нэгнийг адилхан хөгширч байж хэн нэгнийг халамжлах гэж энд төлдөггүй.

Тэгэхээр хэрвээ улс төржсөн шийдвэр гарах юм бол түүнийхээ төлөөсийг төсвөөсөө нэмж өгөх ёстой. Зарчим нь. Гэтэл өнгөрсөн хугацаанд яадаг вэ гэхээр улс төрчид улс төржсөн шийдвэр гаргачхаад тэр мөнгөө улсын төсвөөс өгөхгүй

Нийгмийн даатгалын сангаас, шударга төлж байгаа хүмүүсээс энэ сангаас энэ санхүүжилтийг нь хийлгэж байсан нь энэ санд нөлөөлсөн гэж манай мэргэжлийн хүмүүс, судлаачид үздэг.

10 хувь гэх мэт мөнгөжүүлэх боломж байна уу гээд. Яах вэ, бид үүнийг дөнгөж эхлүүлж байна. Яг үнэнийг хэлэхэд 2 хувийг ч гэсэн мөнгөжүүлсэнгүй гэж би чуулган дээр шүүмжлэлтэй хандаж байсан. Та санаж байгаа байх. Мэдээж манай Сангийн яам тэтгэврийн нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нэмээд... /минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

Уучлаарай гүйцээгээд хариулъя. Х.Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ хууль батлагдсанаар энэ сан нь өөрөө өөрийгөө. Ер нь одоо ч гэсэн яг 100 хувь орлогоороо зарлагаа арай гаргаж чадахгүй байгаа. Одоо энэ хууль батлагдсанаар суурь тэтгэврийг улсын төсвөөс тавина. Тэгэхдээ нийгмийн даатгалын сан руу өгөхгүй. Улсын төсвөөс тавина. 0.5 хувийг мөнгөжүүлэхээс улсын төсвөөс.

Тэгэхээр улсын төсвийн оролцоо, ер нь нийгмийн хамгааллын тэтгэврийн тогтолцоон дээр ялангуяа нэлээдгүй нэмэгдэж орж ирнэ. 2028 оноос бид тооцож үзэхэд 1.5 орчим их наяд байсан. Тийм ээ. Орлого нь буураад зарлага нь нэмэгдэж байгаа тооцооллуудыг нь аваад үзэхээр.

Тэгэхээр ингэж байж энэ шинэ хуулийн хэрэгжилтийг улсын төсвөөс дэмжлэг нэмж үзүүлж байж хэрэгжүүлэхээс өөр аргагүй болно.

Би эдийн засаг, улсын төсөв сайжрах тусам мөнгөжүүлэлтийг нэмэх ёстой гэж бодож байна. Хувь хүний хувьд. Ямар ч байсан өнөөдөр 1.5 хувиар эхэлье. Цаашдаа боломж бололцоо нь байвал 3 хувь, 6 хувь, 9, 10 хувь гээд явах нь зүйтэй.

Шинэ цагийн шимтгэл төлөгчид ер нь... /минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Нийгмийн даатгалын хууль суурь асуудал. Олон чухал саналууд орж байгаа. Үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа.

Тэтгэвэр тэтгэмжээ жил болгон 5, 10 хувь биш, олон хохирсон, эрт гаргасан, хязгаарласан, тайрсан гээд тэтгэвэрийн олон хүмүүс нэлээн өндөр хүлээлттэй байгаа. Хөдөө орон нутаг, энд тэнд явж байхад үүнийг л их асууж байна.

Тийм учраас үндсэн концепцыг нь дэмжиж байгаа. Гэхдээ маш болгоомжтой хандах хэд хэдэн асуудал ороод ирсэн.

Би үүнийг зориуд асууя. Манай зарим гишүүдийн санаачилсан болон Засгийн газрын оруулж ирсэн төсөл дотор ажил олгогчийн төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг хязгаарлаж тогтоож байгаа.

Энэ нь юу вэ гэхээр 8 сая төгрөгөөс дээш хэмжээний цалинтай хүмүүст ажил олгогчийн төлдөг даатгалын мөнгийг байхгүй болгох гэсэн үг. Ингэснээрээ нийгмийн даатгалд яг хэдэн төгрөг дутах вэ? Дээрээс нь хэчнээн аж ахуйн нэгж, байгууллага хамаарагдах вэ?

Дөнгөж сая Оюу Толгойн хэлэлцээр байж байна. Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэе гээд байгаа. Тухайлбал, энэ олон том компаниудаас Оюу Толгой гэхэд хэдэн төгрөгийг нийгмийн даатгалын санд өгөх байсныг өгөхгүй болгох вэ гэж.

Тэгээд энэ дээр тодорхой асуултыг асуумаар байна.

Хоёрдугаарт, давхар гэрээний асуудал орж ирж байгаа. Гоож вий дээ гэдэг санаа байгаа. Магадгүй үүнийгээ урт хугацаанд байя гэх юм бол нийгмийн зөвшилцлөөр явах учраас бүх хөдөлмөрийн гэрээгээ “ажил гүйцэтгэх гэрээ” рүү шилжүүлээд тэгээд маш олон нийгмийн даатгал төлөхгүй арга руу шилжээд сан нь байхгүй болоод. Үүний дараа юу болох вэ гэхээр 2017 онд болж байсан сан хүрэхгүй нь ээ. Шимтгэлээ 5 пунктээр нэмье гээд. Олон Улсын Валютын Сан ингэж зөвлөсөн гээд 5 хувиар нэмэх гэдэг ийм юм давтагдахгүй биз дээ гэдгийг би бүр зориуд асуумаар байна.

Энэ юуг хэлэх гэж байна вэ гэхээр нэг хэсэгт нь үлэмж хэмжээний хөнгөлөлт үзүүлэнгүүтээ болохоо байлаа гэнгүүтээ нийт шударгаар төлж байгаа хүмүүст ачаалал ирэхгүй биз дээ гэдэг дээр. Ийм тооцооллыг нарийн хийсэн биз дээ гэж.

Хоёрдугаарт, тэр 5 жилийг нэг нэг жилээр нэм гээд нэлээн хойшлуулсан. Гэхдээ яг шударгаар төлж байгаа хүмүүсийг хохироож болохгүй. Итгэлцүүрийн болон тэтгэвэр тооцох аргачлалуудыг та хэд яаж тооцож байгаа вэ? Энэ тал дээр ялангуяа манай үйлдвэрчний эвлэлийнхэн энэ тэр нэлээн болгоомжтой эсрэг байр суурьтай байгаа. Энэ тал дээрээ ямар тооцоолол хийх вэ?

Сүүлийнхээ 5 жилийг огцом төлөөд өндөр тогтоогоод байгаа учраас хаах гэж байна гээд 10 жил болгож байна. Гэтэл яг шударгаар 30, 40 жил төлж байгаа хүмүүсийг яаж хамгаалах вэ? Тэд нарын тэтгэвэр ирээдүйд бага тогтох уу? Хэдэн хувиар тогтох вэ гэдэг дээр яг тодорхой хариулт өгөөрэй.

Нэмээд нэг юугаа авъя. Дарга аа. Нэгмөсөн асуугаад. 3 дахь асуулт.

С.Бямбацогт: Нэмж 1 минут. С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сан гээд хамгийн ашигтай мэт харагдаж байгаа боловчиг гэхдээ энэ яг юу ч хийгээгүй сан.

Өөрөөр хэлбэл үлдэгдэл нь өндөр харагдаад байгаа. Сүүлдээ үүнийгээ бүр хасаад байхгүй болгоё гэдэг байдал руу орж болохгүй юм. Зөндөө л осол аваар, гэмтэл болж байдаг. Зарцуулж болохгүй. Сангаа банканд хадгалах гэдэг байдлаар байгаа. Сүүлдээ мөнгө ашигтай байгаад ирэнгүүтээ байхгүй болгох гэдэг тэр өнцгөөс нь харж байгаа буруу. Тэгэхдээ ажлын хэсэг дээр засаад бид болиулсан.

Энэ мөнгөө осол аваараас сэргийлэх, осол аваарт өртсөн, мэргэжлээс шалтгаалах өвчлөлтэй олон мянган хүнийг асарч сувилах гэдэг энэ зүйл рүү зарцуулах юмыг нь би нээж өгч зарчмын санал оруулж өгсөн.

Тийм учраас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн хэчнээн мянган хүмүүс байгаа вэ? Эд нарт яг ямар үйлчилгээ үзүүлж байгаа вэ гэдэг дээр нэг тодорхой хариулт өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүний хэлж байгаа асуудлууд яг энэ хууль дээр хөндөж байгаа гол гол зүйл, заалтууд.

Ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээр хязгаарлаж байгаа.

Үүн дээр нийтдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-аар хязгаарлахад 6900 орчим аж ахуйн нэгжийн 102 мянга орчим шимтгэл төлөгчийн ажилтан талаас нь төлдөг шимтгэлийн хувь хэмжээ буурна гэсэн үг. Энэ манай нийгмийн даатгалын сан дээр орлого талдаа нэлээдгүй бууралт болж орж ирнэ.

Одоо даатгуулагч талынхыг угаасаа 10-аар гээд хязгаарласан байгаа. Тэр ажил олгогч талынх нь хязгаарлах нь зүйтэй гээд Б.Түвшин нарын гишүүдийн хууль дээр ч байгаа. Засгийн газраас өргөн барьсан дээр ч гэсэн “чөлөөлье” гэдэг Ерөнхий сайдын дэвшүүлсэн бодлогын хүрээнд үүнийг тэгэхдээ үе шаттайгаар бууруулаад 12 жил, 11 жил, 10 жил гээд 2027 оноос. Тийм ээ. 2028 оноос хэрэгжиж эхлэхээр тусгасан.

Яг тухайн компани дээр нь шаардлагатай бол индэр дээрээс нэмээд хариулаарай.

5-аас 10 жил болгож тэтгэвэр тооцох хугацааг нэмэх дээр нэг ийм зүйл сүүлийн үед нэмэгдээд байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дөнгөн данган илүүхэн шимтгэлээ төлж, цалингаа бодож шимтгэлээ төлж, сайн

дурын шимтгэлд төлж явж явж байгаад сүүлийн 5 жилд огцом өндөр төлөөд. Ингээд хамгийн өндөр тэтгэвэртэй хүмүүс болоод байхаар нөгөө шударгаар олон жил ажилласан хүмүүсийн хувьд энэ үнэхээр шударга бус байдлыг бий болгоод байдаг. Гэтэл бид нийгмийн даатгал дээр нэгдсэн нэг л томьёо байгаа.

Тэгэхээр үүнийг 5-аас 10 жил болгож тооцоолж сунгалтыг хийхийг Үйлдвэрчний эвлэлийн холбоотой зөвшилцөөд 2029 оноос эхлүүлэхээр болсон.

Яг шударгаар төлдөг хүмүүс дээр энэ хүн маань 5 жилийн дараа тэтгэвэрт гарах юм. Цалинг нь огцом нэмье гэж бараг байдаггүй. Үүнийг тэгэхдээ бид 2023 оны хууль дээр сайн дурын шимтгэл төлөгчийг төлж байгаа шимтгэл нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг долоо нугалснаас илүүгүй гэж тавьсан. Түүнээс өмнө замбараагүй төлдөг байсан.

Тэгээд хамгийн өндөр тэтгэвэр авагчид болж хувирсан. 7 жилийг 5 жил болгоход зарим тэтгэвэр авагчдын хувьд 400 орчим мянган төгрөгийн сар болгон тэтгэврийн зөрүү гарсан. Жирийн багш, жирийн эмч, жирийн албан хаагчдын хувьд энэ нэг их ялгаа гардаггүй. Тэр битгий хэл манай ахмадуудыг тэтгэвэр лүү дөхөх тусам цалин нь бүр буурах гээд байх ч үзэгдэл байдаг.

Тийм учраас бид үүнийг зөв зүйтэй ашиглах ёстой. Одоо цалингаар тооцох биш систем рүү шилжиж байгаа учраас, тогтолцооны ийм өөрчлөлтийг хийж байгаа учраас.

Үйлдвэрлэлийн осол, мэргэшүүлэх залах өвчин дээр С.Эрдэнэбат гишүүний саналтай санал нэг байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийг Засгийн газраас дахин Үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогч нартай хэлэлцээд өргөн барья гэсэн.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Б.Батжаргал хариулах уу? 4 дүгээр микрофон. Тодорхой хариулчхаарай.

Б.Батжаргал: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий газар. Б.Батжаргал.

5 жилийг 10 жил болгоход үүсэж байгаа асуудлыг хүмүүст шокийн байдал үзүүлэх зорилгогүйгээр аажуухан хийх зорилготой орж байгаа. Хэрвээ үүнийг арай өөрөөр хийх аргачлалыг бид энэ хуулийн төслөөр байхгүй болгосон. Тэр нь Нэрийн дансны тухай хууль. Тэр нь юу вэ гэх юм 1979 оноос хойш төрсөн хүмүүсийн хувьд амьдралын бүх насны хугацаанд төлсөн хугацааг нь ашиглаж хувааж төлөх аргачлал байсныг ингээд өөрчилж байгаа. Арай илүү зөөлөн байдлаар. 2 жилийн дараа нэг нэг жилийн аргачлалаар 2033, 2034 оноос эхлээд нөлөөллүүд нь бага багаар эхлэхээр оруулж тооцсон байгаа.

Хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс буюу 792 мянгыг үржих нь 10 гэсэн хувилбараар, түүнээс дээш цалингийн шатлалтай буюу сард нэг удаа ийм цалин авч үзсэн гэсэн судалгаагаар баазаас хайлт хийгээд ерөнхий тойм мэдээ эхлээд авсан.

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Хэн нэмж хариулах юм? Х.Булгантуяа гүйцээгээд хариулъя. Б.Батжаргал дарга гүйцээгээд хариулъя.

Б.Батжаргал: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий газар. Б.Батжаргал.

Энэ судалгааг тойм байдлаар дөнгөж сая авсан.

6906 байгууллага ажил олгогчийг нь, 102 мянга 943 ажилтан нь сард нэг удаа ядаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс буюу түүнээс дээш цалин авч байсан гэсэн судалгаа байна.

Үүнээс аваад үзэх юм бол хамгийн их энэ 6900 ажил олгогчоос худалдааны салбарын буюу 1350 ажил олгогчийг нь 10 мянга 116 ажилтан нь энэ ажил олгогчийн тоогоор хамгийн өндөр байна.

Хүнийх нь тоогоор харах юм уул уурхай, олборлолтын салбарын 19 мянга 813 ажилтан нь энэ ангиллаар сард нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үржих нь 10 гэсэн ангиллаар цалин авч байжээ гэсэн ийм судалгаа байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Дэг дэгийн хуульд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна гэсэн байгаа.

Оюу Толгой, бусад асуудлууд анх хэлэлцэх эсэх дээр асуудаг асуулт. Хэлэлцэх эсэх дээр мэдээлэл авах. Тухайн салбартай холбоотой, тухайн хуультай холбоотой. Дэгийн хууль дээр Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуудаг шүү.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Яаралтай хэлэлцээд шийдвэрийг нь гаргаж өгөөд, тэгээд намар 9 сарын 15-нд улсын төсөв барихаас өмнө нь энэ тооцооллуудаа хийгээд яаравчлахгүй бол цаана чинь ахмадууд маань дэлбэрэхэд бэлэн болсон байна.

Хөдөө орон нутгаар уулзаад явж байхад сум болгонд уулзалтад ирж байгаа хүмүүсийн дийлэнх нь ахмадууд. Ерөөсөө ярьж байгаа юм нь л ахмадын тэтгэвэр. Яг хэдэн төгрөг байвал та хэдийн амьдралд хүрэх гээд байна гэхээр л нөгөө сая

500 мянган төгрөгөө ярьж байгаа. Ордны гадаа ч гэсэн ахмадууд жил гаруй жагсаалд л шаардлагаа хүргүүлээд явж байгаа.

Тэгэхээр энэ ер нь боломжтой юу гэдэг асуулгыг бид Ерөнхий сайдаас асуусан. Ардчилсан намын бүлгээс. Тэгээд боломжгүй гэдэг шийдвэрүүд ирсэн.

Тэгэхээр энд бага ч гэсэн нэмэр болох хууль гэж бодож яаралтай горимоор хэлэлцэж дэмжиж байгаа.

Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 769 мянга байна. Орон нутагт явахад энэ жил махны үнэ ч үнэтэй байсныг хэлэх үү дорухан нэг эр хонины гулууз аваад цаана нь юм үлдэхгүй л хэмжээний мөнгө гэж ярьж байгаа. Энэ нь ч яг үнэн.

Тэгэхээр үлдсэн эм тарианы мөнгө, бүр хувцас хунар, чихэр жимс, ач зээ нарт өгөх юм чинь бүр өнгөрсөн. Тэгэхээр энэ тэтгэвэр яалт ч үгүй хаанаа ч хүрэхгүй байгаа учраас үүнийг яаралтай шийдэх асуудал байгаа юм.

Сая Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэг бичиг яаралтай хэлэлцэхээ болиоч ээ. Үүнийгээ татаж аваач ээ гэсэн агуулгатай бичиг гишүүд рүү ирсэн.

Тэгэхээр ажлын хэсэгт байгаа бол энэ ямар үндэслэлээр ийм зүйл хэлсэн юм бэ? Яагаад үүнийг хойшлуулах санал хэлсэн гэдгээ тайлбарлаад өгмөөр байна.

100 мянгаас 300 мянга. Одоо тэр “баталгаат тэтгэвэр” гэмээргүй байна. “Суурь тэтгэвэр” гээд л явмаар байна. Толгой эргүүлсэн үг хэллэг хэрэглэмээргүй байна. 100-аас 300 мянган төгрөг гэсэн зөрүүтэй.

Тэгэхээр тодорхой хэлээд өгөөч.

- Хэдэн жил ажилласан хүн суурь тэтгэврээ 300 мянга болгох юм?
- Хэдэн жил ажилласан нь 100 мянгаар нэмэгдүүлэх юм?

Үүнийг ажлын хэсэг тодорхой хэлээд өгөөч ээ. Тэгэхгүй бол энэ дээр шударга бус байна гээд л баахан хэрүүл. Минийх их, минийх бага нэмэгдлээ гэдэг бөөн хэрүүл. Нөгөө тэтгэврийн зөрүүний асуудал чинь дахиад босоод ирэх вий дээ гэдэг ийм асуултыг асууя.

Дээрээс нь хамтын тэтгэврийн тухай хуультай холбоотой маягийн заалт орсон байна лээ. Энэ дээр 20 жилийг 15 жил болгох гэсэн зүйл байна уу? Нэг гэр бүлийн хоёр хүний нэг нь нас барсан тохиолдол. Энэ дээр өөрчлөлт орж байгаа зүйл, заалт байна уу? Нэг минутаа нэмээд авчихъя. Нэгмөсөн асууя.

С.Бямбацогт: Ц.Туваан гишүүнд нэмж 1 минут.

Ц.Туваан: Үүнийг хариулаад өгөөрэй.

Тэгээд энэ дээр нөгөө олон давхар тэтгэврийн тогтолцоо руу орох гэж байгаа юм байна. Нөгөө хувийн тэтгэврийн тухай хууль маань хаана ч яваа билээ. Байхгүй. Гурав дахь давхаргын асуудал байна.

Энэ дээр нэг зүйлийг хэлье. Өнгөрсөн парламентын үед би санаачлаад батлуулж байсан байна. Нийгмийн даатгалын сан руу орох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх зорилготой төрөөс олгох урамшууллаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцох гээд. Эрүүл мэндийн даатгалаа төлж, суутгаж уг нь болмоор юм.

Дээрээс нь энэ урамшуулал гээд маш олон тэрбум төгрөг, 60, 70 тэрбум төгрөг хөдөө аж ахуйн салбарт төсвөөс өгч байгаа. Эндээс та хэд маань олигтой нийгмийн даатгалын байцаагч нартаа өгөөд, реклам сурталчилгаа хийгээд улсын төсвөөс өгч байгаа мөнгөнөөсөө суутгаж аваад тэр хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдаас суутгаж аваад энэ сангаа өргөжүүлэх боломж байгаа. Үүнийг нээж өгөх гэсэн л хууль шүү дээ.

Тэгээд энэ дээр хийх төлөвлөсөн арга хэмжээ байгаа юу гэсэн асуулт асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Х.Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Ахмадуудын тэтгэврийг 1.5 сая болгоход Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Т.Аубакир сайд өмнө нь хэвлэлд хэлж байсан. Тооцоолол хийгээд үзэхэд 4 их наяд төгрөг нэмж шаардлагатай байна гээд.

Тэгээд энэ одоохондоо төсөв тооцооллын хувьд хүнд байгаа учраас. Дээрээс нь нэмээд хэрхэн яаж нэмэх вэ гэдэг их чухал.

Ер нь хүмүүс тэтгэврийн зөрүү байх ёсгүй гэхээр хүн болгон ижил тэтгэвэр авах ёстой гэж бодоод байдаг. Гэтэл хүн болгоны цалин нэгэнт адилгүйгээс хойш, эсвэл бид хүн болгоноос 2 сая төгрөгийн цалинтай хүнээс ч 200 мянгыг, 5 сая төгрөгийн цалинтай хүнээс 200 мянгыг, саяас ч 200000-ын нийгмийн даатгалын шимтгэл нэгэнт авдаггүйгээс хойш буцаагаад өгөхдөө ялгаатай авсан ялгаатай өгөхөөс өөр ямар ч арга байхгүй.

Харин ямар зөрүү үүсэх вэ гэхээр би адилхан 20 жил ажилласан математикийн багш. Нэлээн хэдэн жилийн өмнө тэтгэвэрт гарсан. Одоо саяхан гарч байгаа математикийн 20 жил ажилласан багш бид хоёрын хооронд ялгаатай он цагууд гарснаас болоод л зөрүү үүсэх ёсгүй. Тийм ээ.

Үүнтэй холбоотой итгэлцүүрийн асуудал маш чухал байгаа юм. 2023 онд би сайд байхдаа итгэлцүүрийг хийсэн. 9 жилийн дараа хийсэн. Энэ уг нь

хуулиараа ч гэсэн жил болгон хийгээд үүний зөрүүг нь дандаа төсөв дээрээ тавиад нийгмийн даатгалын сангаасаа санхүүжүүлээд явах ёстой.

Гэтэл үүнийгээ тавиагүйгээс болоод 9 жилийн дараа хийхээр хэтэрхий ужгирсан асуудлыг нэг амьсгаагаар хийж чадахгүй. Дээрээс нь нэмээд улсын төсвийнхөө боломж бололцоогоор хийхээр нөгөөдөх нь дутуу хийсэн. Сая 400-гаар тайрсан. Түүнээс дээшээ гомдол үүсэх нь үүссэн. Гэхдээ түүнээс хойш 2023 оноос хойш 3 удаа төсөв баталсан байна. Тэгэхэд энэ төсвүүд дээр энэ итгэлцүүрийг шинэчлээд сая 400-аа тухайн үеийн нөхцөл байдал, сая 900, дараа нь 2 сая 400 болгоод нэмэх боломж байсан уу гэвэл байсан.

Тэгэхээр хийхгүй болохоор ахиад л гомдол үүснэ. Ерөөсөө хамгийн чухал асуудал нь 760 хэдтэй, сая төгрөгтэй ч биш. Энэ тогтолцоогоо тооцоолоо зөв хийгээд, Сангийн яам нэг үүн дээр нь горойхгүйхэн шиг мөнгийг нь тавиад, ахмадуудын яг төлсөн, нэгэнт л ард түмнээс албан журмаар авсан түүнийгээ олон юм яриулахгүй, жагсаахгүй, бухимдуулахгүй өгөх л ёстой.

Тэгээд үүнийг нь л бид хийх ёстой. Дээрээс нь төрөөс өгөх урамшуулал дээр Ц.Туваан гишүүний тухайн үед санаачлаад 2023 оны хуулийг хэлэлцүүлж байхад батлуулж байсан. Энэ маш их чухал.

Манай хоёр яамны төрийн байгууллагууд хоорондоо заримдаа бараг хамтран ажиллах санамж бичиг байгуулах ёстой байдаг юм уу, хаашаа юм. Үүнийгээ арьс ширний, ноос ноолуурын гээд олон урамшууллуудаас авах юм бол манай малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал, тэтгэврийн шимтгэлийн асуудал уг нь хамрагдах боломж бололцоог нь бид хуулиараа нээгээд өгсөн. Үүнийгээ хэрэгжүүлж чадахгүй байна л даа.

Малчдын тэтгэврийн шимтгэлийн асуудал дээр би нэг зүйлийг хэлэх гэсэн юм. 50 хувийг нь төрөөс даавал гээд. Уг нь ахмадуудыгаа шимтгэлд хамрагдуулах гэсэн. Яг үнэнийг хэлэхэд энэ хамрагдалт төдийлөн сайн биш байгаа.

Тэгэхээр нэг хамрагдаад, төсвөөс мөнгө гараад. Ийм юу бол ер нь бага шүү.

С.Бямбацогт: Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон. Э.Тамир хариулъя.

Э.Тамир: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо. Э.Тамир.

Тэгэхээр Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нийгмийн даатгалын ерөнхий хууль болон бусад хуулиудыг өргөн барьж байхтай холбоотой процессын болоод агуулгын шинж чанартай хэд хэдэн асуудлууд дээр Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо эсрэг байр суурь илэрхийлсэн.

Энэ агуулгуудынхаа хүрээнд хэвлэлийн бага хурлаа хийгээд, үүний араас Улсын Их Хурал дээр үүссэн ажлын хэсэг болоод Гэр бүл, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газраас манайханд яг энэ хуулийн үзэл баримтлал, хуулийн зохицуулалт, тодорхой асуудлуудаар бид нэлээн удаан хугацаанд зөвшилцсөн.

Энэ хүрээндээ Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос хэд хэдэн 5 янзын саналын зөрүү байсан. Яг энэ зөрүүтэй асуудлууд дээр Улсын Их Хурал дээр үүссэн Х.Булгантуяа гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгтэй зөвшилцөөд, энэ зөвшилцлөөс хүрсэн гэж үзэж байгаа.

Тэгээд яг энэ дээр хэд хэдэн агуулгууд байна.

Нэгдүгээрт, хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудын тэтгэвэрт гарах насны тусгай зохицуулалтын холбоотой асуудлууд байсан. Яг энэ асуудлууд дээр ажлын хэсэг дээр зөвшилцөөд яг эдгээр улсуудын тэтгэвэрт гарахтай холбоотой тусгай зохицуулалтыг урьдын байснаар хэвээр үлдээсэн.

С.Бямбацогт: Ц.Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Ажлын хэсэг дээр хэн 100 мянгыг авах юм, хэн 300 мянгыг авах юм гэдгээ, хэдэн жил ажиллаж байж хүрэх юм гэдгээ хэлээдэхээч.

Түрүүн бас нэг асуулт ажлын хэсгээс асуусан чинь юу байлаа. Тийм. Тэр нэг гэр бүлийн хоёр хүн. Тэр заалт дээр Хамтын тэтгэврийн хууль шиг заалт байсан шүү дээ. Тэрний жилд өөрчлөлт орж байгаа юм уу, үгүй юу гэдэг асуулт.

Дээрээс нь гарааны бизнес эрхлэгчдийг хөнгөвчилнө гэж байгаа юм. 36 сар. Энэ маш зөв өө.

Тэгсэн чинь энэ дээр оюутан суралцагчид дээр авах нийгмийн даатгалын шимтгэлээс зарим төрлийн гэж байгаа юм. Энэ ямар ажил эрхэлбэл нийгмийн даатгалын шимтгэл аваад гээд. Энэ “зарим” гэдэг үг чинь ямар учиртай юм бэ? Үүнийгээ гүйцээгээд тайлбарлаад өгөөч.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон хариулъя. Ажлын хэсэг.

В.Рэнцэнханд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. В.Рэнцэнханд. Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Хамтын тэтгэврийн шаардлага дээр өмнө нь 20 жил гэдэг шалгуур байсан. Энэ удаа 15 жил болж буурч орж ирсэн байгаа.

Баталгаат тэтгэврийн хувь хэмжээ шимтгэл төлж ажилласан жилийнхээ хэмжээгээр тэтгэврийн хэмжээ нэмэгдээд, авч байгаа тэтгэврийнхээ хэмжээгээр

буурдаг томъёотой байгаа. Тухайлбал, 769 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа 20 жил шимтгэл төлсөн хүний хувьд 201 мянган төгрөг нэмэгдэхээр байгаа.

Тэгэхээр энэ хүний тэтгэвэр 970 мянга 550 төгрөг болно гэсэн үг. Харин 40 жил шимтгэл төлсөн 769 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүний хувьд 300 мянган төгрөгөөр нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ хүний тэтгэвэр 1 сая 69 мянган төгрөг болно.

Оюутны хувьд 15-аас 22 насны их дээд сургууль, мэргэжлийн сургалт, боловсролын төвд суралцаж байгаа суралцагсад... /минут дуусав/

С.Бямбацогт: Б.Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Би юуны өмнө ажлын хэсэгтээ зөвшилцөлд хүрсэн гэдгээ хэлье.

Тэгэхдээ зарим зарчмын зөрүүтэй санал байгаагаа би үг хэлэхээр бэлдсэн байсныгаа уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Бид Үндсэн хуульд үнэнч байж, ард түмний эрх ашигт үйлчилгээ тангарагласан.

Энэ хуулийн төслийг жилийн өмнө Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж эхэлсэн. Тухайн үед Засгийн газраас ижил агуулгатай төслийг долоо хоногийн дараа өргөн мэдүүлнэ. Хамтад нь хэлэлцье гэж хойшлуулсан ч бүтэн жилийн дараа бид өнөөдөр дахин хэлэлцэж байна.

Би болон бусад 40 гишүүний хамт энэ төслийг өргөн мэдүүлэхдээ 3 зорилго дэвшүүлсэн.

- ➔ Иргэний эрх зүйн гэрээг хөдөлмөрийн гэрээтэй адилтган орлогод нь шимтгэл ногдуулдаг тогтолцоог өөрчлөх.
- ➔ Ажилтны амьжиргааг дэмжих, зарим олговор хөнгөлөлтөөс шимтгэл авдгийг халах.
- ➔ Ажил олгогчийн шимтгэлийн дээд хязгаарыг тогтоох зорилготой байсан.

Суурь асуудал нь иргэний эрх зүйн гэрээ, хөдөлмөрийн гэрээг зөв ялган зааглах явдал юм.

Өнөөдөр хувь хүн иргэний хуулийн дагуу гэрээ байгуулж, ажил хийж, үйлчилгээ үзүүлэхэд түүнийг хөдөлмөрийн гэрээт ажилтан мэтээр үзэж байна.

Ингэснээр түүний гэрээлсэн этгээдийг ажил олгогчоор тооцож, нэмэлт шимтгэлийн ачаалал үүрүүлж байна. Үүний үр дүнд хувь хүн нэг бол ажилтан бол, үгүй бол компани байгуул гэсэн шаардлагатай нүүр тулж байна.

Гэтэл иргэний эрх зүйн гэрээ, хөдөлмөрийн гэрээ хоёр –

- өөр өөр зорилго,
- өөр өөр шинж,
- өөр өөр эрсдэл,
- өөр өөр хариуцлагатай харилцааг зохицуулдаг.

Энэ бол иргэн хүн өөрийн нэрээр өөрийн хөдөлмөр, мэдлэг, ур чадвараар иргэний эрх зүй, бизнесийн харилцаанд чөлөөтэй оролцох эрхийн тухай зарчмын асуудал юм.

- ➔ Яагаад Монгол Улсын иргэн өөрийн нэрээр гэрээ байгуулж, ажил хийж, үйлчилгээ үзүүлж болохгүй гэж.
- ➔ Яагаад заавал ажилтан байх ёстой гэж.
- ➔ Яагаад зах зээлд оролцохын тулд заавал компани байгуулах ёстой гэж.

Үүний эсрэг ажил олгогчдод бүх хөдөлмөрийн гэрээг иргэний гэрээ болгон хувиргаж шимтгэлээс зайлсхийх эрсдэлтэй гэж тайлбар хийдэг.

Гэхдээ үүнийг төр хяналт, шүүхийн практик, харилцааны бодит шинжээр ялгах ёстой.

Мөн тогтмол бус орлоготой ажил, үйлчилгээний үр дүнгээр орлого олдог иргэдийн онцлогт тохирсон уян хатан нийгмийн даатгалын тогтолцоог судалж нутагшуулах шаардлагатай.

Гэхдээ бүх иргэний эрх зүйн гэрээг хөдөлмөрийн гэрээ мэтээр үзэж нийтээр нь шимтгэлийн дарамталд оруулах нь зөв шийдэл биш юм. Нэгтгэсэн төсөл энэ асуудлыг үндсэн зарчмаар нь бус тухайн сарын нэг гэрээний орлогоос шимтгэл тооцох хүрээнд л шийдвэрлэхээр хязгаарласан.

Хэлэлцээрийн явцад манай төслийн зарим санаа туссан. Ажил олгогчийн төлөөх шимтгэлийн дээд хязгаарыг үе шаттайгаар ч болов тогтоох зохицуулалт орсон нь сайн хэрэг.

Харамсалтай нь манай төслийн үндсэн философи бүрэн тусгасангүй. Бидний хөндсөн асуудал нэг гэрээнээс шимтгэл авах уу, хоёр гэрээнээс шимтгэл авах уу гэдэг тооцоо биш. Харин иргэний эрх зүйн гэрээний орлогод албан журмын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах нь эрх зүйн хувьд буруу гэсэн суурь зарчмын асуудал байсан юм.

Төр нэг талаас орлогыг татвар авахдаа бизнесийн орлого гэж үздэг. Харин нийгмийн даатгалын шимтгэл авахдаа цалингийн орлого гэж ханддаг. Төрд ийм хоёрдмол хандлага байж болохгүй.

Иймд бид хувь хүнийг нэг ажилтан бай, эсвэл компани байгуул гэсэн хууль зүйн гажуудлыг засаж, иргэн хүн зах зээлд бие даан оролцох боломжийг нээхийн төлөө үргэлжлүүлэн ажиллах болно.

Тэгээд эцэст нь хэлэхэд энэ асуудал дээр цаг хугацаа бага байсан учраас зөвшилцөлд хүрсэн гэдгээ хэлье.

С.Бямбацогт: Б.Түвшин гишүүнд баярлалаа.

Гэхдээ бас зөвшилцөж, ойлголцоод бүрэн шийдэгдэнэ гэж байхгүй, бас улс орныхоо эрх ашиг, нийгмийн даатгалын сангийнхаа дансыг улайлгахгүй байх, орлого, зарлагаа тэнцвэртэй байлгах талдаа хоёр тал ажлын хэсэг маань ажиллаад ойлголцсон гэж ойлгож байгаа.

Баярлалаа. Б.Түвшин гишүүнд.

Одоо ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Цөөхөн санал хураалт. Саналаа хурааа даа. Үгүүд тухайлсан саналууд дээр байгаа.

Гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Санал хураалтаа явуулъя.

Гишүүд чуулган танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Гишүүд чуулганы танхимд цуглаж байх хооронд мэдээлэл хэлье. Гишүүддээ.

Сая Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал тэргүүтэй Засгийн газрын гишүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Б.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням нар Рио Тинто компанитай Оюу Толгой төслийн талаар хэлэлцээр хийж, хэлэлцээр амжилттай үр дүн гаргаж дуусгасан байна. /алга ташив/

2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ хийж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийн 53 хувийг монголчуудад ноогдоно гэж хөрөнгө оруулалтын гэрээ хийж байсан.

Өнөөдөр бодит байдал дээр 25-аас 30 орчим хувь ногдож байгаа.

Үүнийг засах гэж Улсын Их Хурлаас олон Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, үе үеийн олон сайд нар, олон Засгийн газар, олон гишүүдэд үг хэлж, асуудал ярьж байсан. Тэгээд шийдэгдэж чадахгүй.

Улсын Их Хурал –

- 2019 онд тогтоол гаргаж байсан.
- 2021 онд тогтоол гаргаж байсан.
- 2025 онд тогтоол гаргаж байсан.

Монголын төр засаг, Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүд, Монголын ард түмэн, Монгол Улсын Үндэсний аюулгүйн зөвлөл нэг талдаа гарч нэлээн хүчин чармайлт гаргасны үр дүнд өнөөдөр энэ хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт орохоор болсон байна.

- Зээлийн хүү буурахаар болсон.
 - Менежментийн төлбөр 2 дахин буурсан.
 - Зээлийн хүү SOFR² +4 хувь болсон байна.
 - Мөн 7 жил тутам хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт хийдэг байсан хувь нийлүүлэгчдийн гэрээнд 3 жил тутам болсон байна.
- Үүгээрээ Монголын талын үр өгөөж нэмэгдэх нь.
 - Жил болгон ногдол ашиг авдаг болох нь. /алга ташив/

Урьд нь бид бүхэн Оюу Толгой төсөл Эрдэнэтээс 3 дахин илүү баяжмал зэсийн баяжмал экспортлоод, 3 дахин бага татвар төлдөг.

1 сая 600 мянган тонн баяжмал экспортолдог. Төлж байгаа татвар нь маш бага байсан. Үндсэндээ тэнд ногдох татвар нь Эрдэнэт 5 их наяд. Оюу Толгойтой тэнцэх хэмжээний зэсийн баяжмал экспортолсон бол 5 их наяд төгрөг төлж байх байсан.

Гэтэл Оюу Толгой компани 1.6 их наядыг л төлдөг. 3.4 их наядыг төлдөггүй байсан. Энэ бүхэн түүх болох юм шиг байна.

Энэ асуудлыг шийдсэн Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Сангийн сайд З.Мэндсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням нартаа нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс, Монголын ард түмний нэрийн өмнөөс талархал илэрхийлье. /алга ташив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй 50 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. /алх цохив/

О.Амгаланбаатар гишүүн, Г.Хосбаяр гишүүд суудалдаа суучих. Тэгээд санал хураалт явуулъя. /алх цохив/

² Secured Overnight Financing Rate.

С.Зулпхар гишүүн, Б.Жаргалан гишүүн. Ирц бүртгэлийн санал хураалт.
/алх цохив/

62 гишүүн. Энэ татгалзсан гарч байгаа 45 гишүүн. Ж.Батсуурь гишүүн, О.Саранчулуун гишүүн, Н.Алтаншагай гишүүдийг нэмж авъя.

Тэгээд бусад 42 гишүүн чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Ж.Чинбүрэн гишүүн, Д.Рэгдэл гишүүнийг нэмж авъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийн “хоёр хүртэлх гэрээнээс сонгон” гэснийг “нэг гэрээнээс” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпхар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат. Цаашид “Ажлын хэсэг” гэх. Мөн Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин гишүүн энэ саналыг гаргасан байна. Дэмжье гэсэн томьёоллоор

Санал хураалт явуулъя. /алх цохив/

107 гишүүнээс 70 гишүүн буюу 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.
/алх цохив/

Дэмжсэнд Л.Мөнхбаясгалан гишүүнийг авъя.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22” гэснийг “15-24” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “25” гэснийг “26” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг.

Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 73 буюу 68.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

3 дугаар санал. 3 дугаар санал дээр Ерөнхий сайд.

Н.Учрал: Үндэсний их баяр наадмын өмнө Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Монгол түмэндээ, Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэндээ сайн мэдээ дуулгая.

Монголчууд Оюу Толгойн хэлэлцээрт түүхэн амжилт гаргаж чадлаа.

Нэгдүгээрт, манай Засгийн газар байгуулагдсан даруйдаа Оюу Толгой төслийн менежментийн зардлыг 2.2 тэрбум америк доллар буюу 8 орчим их наядаар бууруулж сайн мэдээ дуулгаж байсан.

Эхний 100 хоногийнхоо босгон дээр Оюу Толгой хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бодитойгоор бууруулж чадлаа.

Зээлийн хүүг бууруулснаар Оюу Толгойн баялгаас өр зээлд төлөх байсан 6.2 тэрбум америк доллар буюу 22 их наяд төгрөгийг хэмнэж чадлаа.

Ингэснээр Монголын талын хүртэх өгөөж 2.5 тэрбум америк доллар буюу 8 орчим их наяд төгрөгөөр нэмэгдэх боломж бүрдэж байна.

Хоёрдугаарт, Оюу Толгой хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг 7 жил тутам бууруулах цонх нээгддэг байсныг 3 жил тутамд эргэж харах, хэлэлцдэг болгож чадлаа.

Гуравдугаарт, энэ жил бид Оюу Толгойгоос ногдол ашиг авна. Энэ асуудлаар Рио Тинтотой ажиллахаар тохиролцлоо.

Хэлэлцээрийн үр дүнд Оюу Толгойн баялгаас төлөгдөх 8.4 тэрбум америк доллар буюу 30 орчим их наяд төгрөгийн зардлыг бууруулж, Монголын талын ирээдүйд хүртэх өгөөжийг 4 тэрбум доллар буюу 13 орчим их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх боломж бүрдэж байна.

Монгол төрийн наадмын өмнө монголчууд эрх ашгаа хаанахын хэний ч өмнө хамгаалж чаддаг юм шүү гэдгээ батлан харуулж чадлаа.

Хамтарч ажилласан Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд, Их Хурлын хянан шалгах түр хороо Та бүгдэд талархал илэрхийлж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд, Монголын ард түмний дэмжлэгтэйгээр Оюу Толгойн хэлэлцээрт 17 жилийн дараа энэхүү түүхэн хэлэлцээрийг амжилттай хийлээ.

Цаашид манай Засгийн газар дуусдаггүй олон яриаг дуусгаж олон сайхан мэдээ дуулгахын төлөө хичээн ажиллана.

Үндэснийхээ эрх ашгаа хамгаалан улс орноо гэсэн нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэсэн бүх хүнд талархаж байна.

Ажлын хэсгийг ахалж ажилласан Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн Загджавын Мэндсайхан, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням нартаа онцгойлон талархал илэрхийлж байна.

Монголчууд хэлэлцээрийн ширээний ард сууж, санхүүжилтийнхээ өөрийн схем моделио танилцуулж, хэлэлцээр хийж чаддаг гэдгээ тод томруун харууллаа.

Хамтарч ажилласан хэлэлцээрийн багийн бүх гишүүддээ, төрийн албан хаагч нартаа чин сэтгэлээсээ талархаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэндээ дахин баяр хүргэе ээ. /алга ташив/

Нийгмийн даатгалын хуулийг хэлэлцэж байна. Засгийн газар тэтгэврийн реформыг хийх шинэчлэлийг оруулж ирлээ. Шударга тэтгэврийн тогтолцоо руу бид шилжих гэж байна. Үүний үр дүнд мэдээж санхүүжилтийн асуудал яригдана.

Олон сайхан мэдээтэй, хөгжлийн гацааг чөлөөлсөн Засгийн газрын бодлого шийдвэрүүд ард түмний өрхийн ахуй амьдралд хүрч, бидний бодлого, шийдвэр ард түмэндээ илүү ойртохын төлөө Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэнтэйгээ хамтарч ажиллана гэдгийг илэрхийлье.

Монголын заяа их юм аа. /алга ташив/

С.Бямбацогт: Баярлалаа.

“Хоёр хүн эвтэй төмөр хүрээ мэт, 20 хүн эвгүй эвдэрхий балгас мэт” гэж Чингис хаан маань хэлсэн байдаг.

Монголчууд хамтдаа эвтэй, хүчтэйгээ харуулж, олон жил, үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газар ард түмний шийдэж чадахгүй асуудлыг шийдэж том алхам гаргалаа, шийдлээ.

Энд санаачилж манлайлсан Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүддээ, мөн идэвхтэй санаачилгатай ажилласан Их Хурлын гишүүддээ, иргэний нийгмийн байгууллагадаа, ер нь бүгд нийлээд л явсан.

Ард түмэнтэйгээ Их Хурал, Засгийн газар бүгд нийлээд ажилласан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хүртэл нэмж орсон.

Үүний үр дүн гарлаа шүү. Тийм болохоор эвтэй байхдаа хүчтэй. Бүгдээрээ эвтэй байцгаая.

Улс орноо улам хөгжүүлцгээе ээ. Хамтдаа байж.

Ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа.

Х.Булгантуяа: 3 дугаар санал дээр Их Хурлын дарга аа, гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 3 дугаар санал дээр Ерөнхий сайд, ажлын хэсгийн ахлагчийн хэлсний дагуу чиглэл өглөө.

Гүйцээн боловсруулж чиглэл өгч байна. /алх цохив/

4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс” гэсний дараа “доошгүй орлогоос” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 75 буюу 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 1 болон 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 77 буюу 72.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “биечлэн” гэсний дараа “, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн бол асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 74 буюу 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “0.3, 1.0, 1.5” гэснийг “0.3, 1.2, 2.2” гэж, “10.4, 11.1, 11.6” гэснийг “10.4, 11.3, 12.3” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 75 буюу 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 74 буюу 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 74 буюу 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсгийн “шимтгэл төлөлтийн” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “тухайн гэрээ бүрт” гэснийг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 69 буюу 64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт болон 7, 10 дугаар зүйлийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11, 7.12 дахь хэсгийг тус тус хасах.

Б.Түвшин санал гаргасан. Б.Түвшин гишүүнд микрофон өгье.

Б.Түвшин: Ажлын хэсэгтэй энэ талаар зөвшилцөлд хүрсэн тул миний оруулсан 1, 2 дугаар хэсгийн саналыг татаж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. 1, 2 дугаар саналыг гаргасан Б.Түвшин гишүүн саналаа татлаа. /алх цохив/

3.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22 насны суралцагч” гэсний дараа “, мөн тухайн насны бүтэн бус цагийн ажил эрхэлж буй ажилтан” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Энхтүвшин гишүүнд микрофон өгье.

Д.Энхтүвшин: Байнгын хороон дээр энэ саналууд хураагдаад өөр хэлбэрээр тогтсон учраас энэ саналыг татаж байна.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн гаргасан саналаа татлаа. 4 дэх саналыг татлаа. /алх цохив/

5.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Эхний 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа гарааны бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа. Санал хураалт.
/алх цохив/

107 гишүүнээс 59 буюу 55.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.30 дахь хэсгийг “болон төрийн бус байгууллага” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт.
/алх цохив/

107 гишүүнээс 63 буюу 58.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төслийн 5 дугаар “4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах”, гэснийг мөн зүйлийн “7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасах.

Б.Түвшин гишүүнд микрофон өгье.

Б.Түвшин: Энэ саналыг татъя.

С.Бямбацогт: Б.Түвшин гишүүн саналаа татлаа. 7 саналыг татлаа. /алх цохив/ Санал хураахгүй.

ХОЁР.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1/Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төсөлд 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 70 буюу 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 3 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журам, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 73 буюу 68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.1.8 дахь заалтыгдоор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.8. “суурь тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авагч ахмад настанд авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан тооцож улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 70 буюу 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 3.2, 3.5, 3.6 дахь хэсгийн, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн “баталгаат” гэснийг тохиолдол бүрт “суурь” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 3 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийн “Бт” гэснийг “Ст” гэж, “Бсд” гэснийг “Сүд” гэж, 3.5, 3.6 дахь хэсгийн “Баталгаат тэтгэврийн суурь дүн” гэснийг “Суурь тэтгэврийн үндсэн дүн” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71.

Саяын санал хураалт хүчингүй. Техникийн саатал гарсан учраас хүчингүй болгох санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 69 буюу 64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

108 гишүүнээс 69 буюу 63.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэгт дурдагдсан “2027” гэснийг “2027, 2028” гэж, “2028” гэснийг “2029” гэж, “2029” гэснийг “2030” гэж, “2030” гэснийг “2031” гэж, “2031” гэснийг “2032” гэж “2032” гэснийг “2033” гэж тус тус харгалзуулан өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

108 гишүүнээс 73 буюу 67.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

108 гишүүнээс 74 буюу 68.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

108 гишүүнээс 70 буюу 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Суурь тэтгэврийг доор дурдсан насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгоно:

3.4.1.энэ хуулийн 5.1.1-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч;

3.4.2.энэ хуулийн 5.1.2-5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй 60 насанд хүрсэн, эмэгтэй 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч, мөн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 72 буюу 67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасаж, төслийн дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 73 буюу 68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг, төслийн 4 дүгээр зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэсний “55” гэж,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ хөндөгдөөгүй заалт гэдгээр хасагдсан юм. Ц.Мөнхтуяа гишүүн бид хоёрын санал.

Тэгэхээр 1, 2, 3 дугаар саналуудыг хасаад, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухайн хуулийг ярих үед дараа ярьж гэдгээр ярьсан учраас татаж авч байна.

С.Бямбацогт: Хөндөгдөөгүй заалтаар санал хураалгаж байгаа чинь өөрөө буруу шүү дээ. Энэ чинь өөрөө хууль зөрчиж байна шүү дээ. Ажлын хэсэг үүнд анхаарах ёстой шүү дээ.

Санал татлаа. /алх цохив/

Энэ Байнгын хороодын зөвлөхүүд юу хийж байна. Тамгын газар.

4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Энэ заалтыг татъя. Хэрвээ энэ заалт дэмжигдвэл одоогийн байдал нь дордохоор. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид энэ заалт хамрагдахгүй байх нөхцөл байдал үүсэх учраас энэ заалтыг татъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн саналаа татлаа. Баярлалаа.

3/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа гишүүн. Ажлын хэсгийн ахлагчид микрофон өгье.

Х.Булгантуяа: Их Хурлын дарга аа, 1, 2 дугаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 1, 2 дугаар саналууд дээр ажлын хэсгийн гаргасан саналын дагуу гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

3.Нэгтгэсэн төслийн 3, 4 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 68 буюу 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4/Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5/Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 70 буюу 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “баталгаат” гэснийг “суурь” гэж, мөн зүйлийн 2 дугаар заалт буюу 8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсгийн “баталгаат” гэснийг “суурь” гэж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 9 дүгээр зүйлийн 5, 6, 7 дахь хэсгийн “баталгаат” гэснийг “суурь” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 75 буюу 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 73 буюу 68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 72 буюу 67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 71 буюу 66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 55 хоногоор тооцож олгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Д.Энхтүвшин гишүүнд микрофон өгье. Санал хураалт хүчингүй.

Д.Энхтүвшин: Ажилгүйдлийн тэтгэмжийг өөр санаачлагчаар болон ажил олгогчийн санаачлагаар чөлөөлөгдсөнөөс хамаараад ялгаатай тогтоосныг нэг жил болгоё гэсэн.

Гэхдээ томьёоллын хувьд 55, 21 насны зөрүүтэй гээд 76 хоёр өөр ялгаатай байсныг 55-аар гэж томьёолсон нь өөрөө нэгдсэн саналд хүрч чадаагүй учраас энэ саналаа татъя.

С.Бямбацогт: Саналаа татлаа. /алх цохив/

9/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын “сэргээн засах” гэсний дараа “, гэрээр асрах, сувилах болон хувилбарт тусламж” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 74 буюу 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60

насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (Ст)-ийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгоно.”

Ажлын хэсэг. Х.Булгантуяа.

Х.Булгантуяа: Энэ бас гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

2.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй тэтгэвэр авагчид 60 насанд, эмэгтэй тэтгэвэр авагчид 55 насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (Ст)-ийг тооцон олгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 75 буюу 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1} дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 76 буюу 71.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

107 гишүүнээс 74 буюу 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Эрхэм гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд хэлэлцэж дууслаа.

Санал хураалтад эцсийн мөч хүртэл оролцсон гишүүддээ их баярлалаа.

Тамгын газрынхаа ажилтнуудад баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье.

Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороо хамтарсан хуралдаанаа одоо орох нь байна шүү. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо хуралдах нь байна шүү.

Гишүүд ээ, Хууль зүй, Аюулгүй байдал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо хуралдах нь хуралдаа ороорой. Байнгын хорооны гишүүд.

Хуралдаан 4 цаг 31 минут үргэлжилж, 18 цаг 46 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД